

**БАЯНХОНГОР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2024 оны 11 дүгээр сарын 25

Рашаант

Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн байгууллагын бүрэн эрх, чиг үүргийн хүрээнд Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2024 онд дэвшүүлсэн зорилт, Засгийн газрын тогтоолоор батлагдсан хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээг шуурхай, чанартай хүргэх үндсэн үйл ажиллагааны зэрэгцээ Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн зөвлөмж чиглэлийг удирдлага болгон бүртгэлийн ажил үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хангах ажилд онцгойлон анхаарал хандуулан ажиллалаа.

Улсын бүртгэлийн хэлтэс хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, улсын бүртгэгчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах, улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн цаасан болон цахим архив, цахим мэдээллийн санг үүсгэх, хөтлөх, төрөлжүүлэн хадгалах, тэдгээрийн хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах, улсын бүртгэлийн хөтлөлт, эх нотлох баримтын үнэн зөвийг нягтлан бүрдлийг хангах, илэрсэн зөрчлийг арилгуулах замаар улсын бүртгэлийн үнэн зөв, бодит байдлыг хангах зэрэг үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллав.

Мөн хэлтсийн нийт албан хаагчдад Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хуулийг чанд мөрдөн, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, үйлчилгээний стандартыг баримтлан ажиллахыг үүрэг болгон мэргэжлийн удирдлагаар ханган ажиллалаа.

Хэлтсийн 2024 оны жилийн эцсийн энэхүү тайланд хууль тогтоомж болон үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулсан, байгууллагын стратеги зорилтыг хангах зорилгоор нэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээнд хамрагдсан болон хэлтсийн хэмжээнд хийгдсэн ажил, улсын бүртгэгч нарын хийж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээг нэгтгэн танилцуулж байна. Үүнд:

- Хөтөлбөр ,төлөвлөгөөний хэрэгжилт;

- Улсын бүртгэлийн (иргэнийн, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн бүртгэлийн тасгууд) үйлчилгээг түргэн шуурхай, чанартай хүргэх ажлын зохион байгуулалт;
- Бүртгэлийн хяналт;
- Санхүү, төсвийн удирдлага, төлөвлөлт болон төсвийн гүйцэтгэл;
- Байгууллагын дотоод ажил, үйл ажиллагааг сурталчлах ажиллагаа;
- Байгууллагын албан хаагчийн сургалт, хөгжил, ёс зүй;
- Орон нутаг дахь хамтын ажиллагаа;
- Идэвхи санаачилга, шинэлэг ажил

### **НЭГ.ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг УБЕГ-аас батлан ирүүлсэн хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, зарим тохиолдолд хэлтсээс дэд хөтөлбөр, төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Дурьдвал :

1.1.1. “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” төлөвлөгөөний хэрэгжилт

1.1.2 Жендэрийн тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт

1.1.3 Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх дэд төлөвлөгөөний хэрэгжилт

1.1.4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүний эрхийг хангах дэд төлөвлөгөөний хэрэгжилт

1.1.4 “УББ-ын албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө гэх мэт.

Дээрх төлөвлөгөөнүүдийн хэрэгжилтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулах ажилтан, албан хаагчийг жил бүр өөрчлөн түүний гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулан биелэлтийг хангуулан ажиллаж байна. Улсын бүртгэлийн байгууллагын жендэрийн нэгдсэн бодлогын үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч А.Оюунсүвд хариуцан хэрэгжүүлдэг бол хуулийн этгээдийн улсын бүртгэгч Д.Отгонсүрэн Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх дэд төлөвлөгөөний хэрэгжилтийг, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч С.Баярмаа “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” төлөвлөгөөний хэрэгжилт гэх мэт хариуцан хэрэгжилтийг тайлагнан ажиллаж байна.

Жишээлбэл:

#### **1.Жендэрийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд**

“Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 2/11313 тоот “Биелэлт ирүүлэх тухай” албан бичгийн дагуу “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-ыг хөвгүүд, эрчүүдийн оролцоог хангах замаар охид, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй аливаа хүчирхийллийн эсрэг хөдөлгөөнд нэгдэж, хүчирхийлэлийг таслан зогсоох, түүнчлэн урьдчилан сэргийлэх чиглэлээр удирдамжид заасан санаачлагыг дэмжин, дараах арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:

-2023 оны 12 дугаар сарын 01-ны өдөр Баянхонгор аймгийн Цагдаагийн газартай хамтран ерөнхий боловсролын “Номун далай” цогцолбор сургуулийн 10-р ангийн сурагч нарт **“Тамхины хор уршиг”, “Гэмт хэрэг зөрчлийн тухай ойлголт”, “Үе тэнгийн дарамт дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх”, “Цахим орчинд хүүхдийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх”** гэсэн сэдэвтэй сургалт зохион байгуулсан.

-Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны **“Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил”**-ийн төлөвлөгөөнд **3** саналыг хүргүүлж тусгуулсан.

-Баянхонгор аймгийн залуучуудын Хөгжлийн төв, “Хөөрхөн зүрх” ТББ-аас бэлдсэн **6** төрлийн постор, зурагт хуудсыг өөрийн хэлтсийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд түгээж сурталчилсан.

-2024 оны 01 дүгээр сарын 09-ны өдөр АЗДТГ-аас Байгууллагын дэргэдэх хороо, зөвлөл “Хүйсийн тэнцвэрт байдлын 2023 оны мэдээ”, “Төрийн байгууллагуудын дэргэдэх хороо, зөвлөл, комиссын бүрэлдэхүүний хүйсийн тэнцвэрт байдлын 2023 оны мэдээ”, “Эрэгтэй эмэгтэй хүний наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн мэдээ”- г тус тус хугацаанд нь хүргүүлж ажилласан.

-Хэлтсийн албан хаагчид “Нэг тэрбумаараа тэмцье 2024” арга хэмжээнд өөрсдийн фэйсбүүк нүүр хуудсаа сольж охид, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй бүхий л төрлийн хүчирхийллийг хамтдаа таслан зогсоохыг уриалж цахимаар нэгдэж байгаагаа илэрхийлж хэрэгжилтийн тайланг 2024 оны 03 сарын 11 өдөр хүргүүлсэн.

Хэлтсийн бүх албан хаагч дээрх аянд нэгдэж байгаагаа илэрхийлсэн зурагт хуудсыг хэлтсийн сайт дээр байршуулж нийт албан хаагчдаар facebook хуудсаар нь дамжуулан олон нийтэд түгээсэн ба **3 264** хандалт авсан байна.

Ийнхүү хөтөлбөр төлөвлөгөөний дагуу ажлуудыг зохион байгуулж тус төлөвлөгөөний биелэлтийг гарган [khandsuren.v@burtgel.gov.mn](mailto:khandsuren.v@burtgel.gov.mn) хаягаар хүргүүлэв.

## 2. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр

Хэлтсийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын дэд төлөвлөгөөг тус тасгийн улсын бүртгэгч С.Баярмаа хариуцан авч төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

-Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд байгууллагын албан хаагчдаас “Авлигаас ангид байх амлалт”-ын дэвтэрт гарын үсэг зуруулсан.

-Улсын бүртгэгч нарын нэгдсэн сургалт зөвлөгөөн 2024 оны 04 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд зохион байгуулагдаж тус сургалт дээр сумдын улсын бүртгэгч нарт өмнөх оны “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө”-ний биелэлт болон тухайн оны төлөвлөгөөг танилцуулж төрийн албан хаагчдын тухайд гэмт хэрэг зөрчилд өртөхгүй байхыг анхааруулсан.

-Нийт албан хаагчдад “Цахим орчин дахь гэмт хэргээс бага насны хүүхдийг урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг аймгийн Цагдаагийн газрын хүүхдийн байцаагч ахмад Б.Ганбаяр, “Эрүүгийн болон Зөрчлийн хуульд орсон нэмэлт өөрчлөлт” сэдвээр аймгийн Цагдаагийн газрын ГХЗУСА хариуцсан чиглэлийн ахлах ц/хошууч Г.Анхбаяр нарыг урьж сургалт зохион байгууллаа.

-Аймгийн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймгийн Прокурорын газар хамтран Баянхонгор аймгийн хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөнийг 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсан ба нэгдсэн сургалт, зөвлөгөөнөөс гаргасан зөвлөмж, аяны хүрээнд 1 жилийн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг тогтоосон хугацаанд нь хүргүүлээ.

-Тоон гарын үсгийн ашиглалттай холбоотой Аймгийн прокурорын газраас ирүүлсэн мэдэгдлийн дагуу сумдын улсын бүртгэгч нарт зөвлөмж хүргүүлж, “Залилагч нарт боломж бүү олго” уриатай постер бэлтгэн сумдын бүртгэгч нараар дамжуулан сумдын фэйс группт, мөн байгууллагын пэйж хуудаст байршуулан иргэдэд сэрэмжлүүлэг мэдээлэл хүргэсэн байна.

-Эцэг эхийн зөвлөлөөс байгууллагын пэйж хуудсаар дамжуулан “Үр хүүхдээ ахуйн осол гэмтлээс хамгаалъя”, “Дэлгэцийн донтолтоос урьдчилан сэргийлье”, “Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг дэлхийн өдөр”, “Олон Улсын гэр бүлийн өдөр”, 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж буй “Хүүхэд хамгааллын тухай хууль”-ийн холбогдох заалтуудаар тухай бүр постер бэлтгэн хүргүүлсэн зэрэг ажлуудыг зохион байгуулж хэрэгжилтийг гарган [e.battsengel@burtgel.gov.mn](mailto:e.battsengel@burtgel.gov.mn) хаягаар хүргүүлсэн.

**ХОЁР. УЛСЫН БҮРТГЭЛИЙН (ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД  
ХӨРӨНГИЙН) ҮЙЛЧИЛГЭЭГ ТҮРГЭН ШУУРХАЙ, ЧАНАРТАЙ ХҮРГЭХ  
АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ;**

Хэлтсийн хамт олон холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм журам, эрх зүйн бусад актууд болон байгууллагын үйлчилгээний стандартыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчилж, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд баримтлан ажиллалаа.

Иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх эрх зүйн орчин, орчин үеийн мэдээлэл технологийн шаардлагад нийцсэн цахим үйлчилгээг хүргэх нөхцөл боломж улам бүр төгөлдөршиж байгааг тэмдэглэхэд таатай байна.

**2.1 ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР**

Энэ онд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа голчлон хуулийн хэрэгжилт, хамтын ажиллагааг дэмжин ажиллах, Сонгуулийн хуулиар Улсын бүртгэлийн байгууллагын хүлээсэн чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэх, иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим санг цэгцлэх, улсын бүртгэлийн явуулын төхөөрөмжийг ашиглан явуулын үйлчилгээг үзүүлэх, алслагдсан сумын иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж төрийн үйлчилгээний хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, улсын бүртгэлийн анхан шатны нэгжид улсын бүртгэлийн хүрээгүй үйлчилгээг хүргэхэд гол анхаарлаа хандуулсан явдал нь энэ тайлангийн гол онцлог юм.


**Цахим шилжилт-тоон гарын үсэг олголт болон  
тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр**

**2.1.1. Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд:**

Монгол Улсын Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого” бодлогын баримтын бичгийн Зургаадугаар бүлгийн 6.1. Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулна. "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1.1."Цахим үндэстэн" болох арга хэмжээг эрчимжүүлж, нийтийн мэдээллийн дэд бүтцийг боловсронгуй болгож, цаасан суурьтай үйл ажиллагааг багасган цахим харилцаанд

шилжиж, нийтийн мэдээллийн системээс олж авах, солилцох боломжтой мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх нөхцөлийг хангаж, цахимаар үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмж, тоог нэмэгдүүлж, иргэнийг цахим гарын үсгээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх” гэж төлөвлөсний дагуу Улсын бүртгэлийн Ерөнхий газраас Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан болон хэлтсийн зүгээс олон талт арга хэмжээг амжилттай хэрэгжүүллээ.

УБЕГ-аас Тоон гарын үсэг олголтыг идэвхижүүлэх, нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2023 онд ХААН банкт хамтран ажиллах санамж бичиг байгуулж, санамж бичгийн дагуу “Тоон гарын үсэг олголтыг идэвхижүүлэх аян”-г зохион байгуулсан аяны хүрээнд улсын бүртгэгч нар **13885** тоон гарын үсэг олголтыг хийсэн амжилтаар тэргүүлсэн билээ. 2023 онд ийнхүү тоон гарын үсгийн олголтыг чухалчилсан бол 2024 онд тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, тоон гарын үсэг хэрэглэх чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:



1. Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхам, улсын бүртгэгч Э.Адъяабаяр нар 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Эрдэнэмандал ахлах сургуулийн ажилтан, алба хаагчидад Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим шилжилтийн хүрээнд хийж, хэрэгжүүлж байгаа ажил, үйлчилгээ, тоон гарын үсгийн хэрэглээ, ач холбогдол зэрэг цаг үеийн мэдээллээр сургалт хийж, 25 иргэний гар утсанд Gsign аппликейшн суулгуулж, арга зүйн зөвлөгөө өглөө.



2. Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхам, улсын бүртгэгч Э.Адъяабаяр нар 2024 оны 05 дугаар сарын 04-ны өдөр Баянхонгор аймгийн Хаан банкны салбар, тооцооны төвийн 24 нэгжийн нийт 106 менежер, зээлийн мэргэжилтэн, салбарын захирал, эрхлэгч нарт Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим шилжилтийн хүрээнд хийж, хэрэгжүүлж байгаа ажил, үйлчилгээ, Тоон гарын үсгийн хэрэглээ, ач холбогдол зэрэг цаг үеийн

мэдээллээр сургалт хийж, тоон гарын үсэгтэй холбоотой гарч буй алдаа, анхаарах зүйлийн талаар харилцан санал солилцлоо.

3. Харин тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, тоон гарын үсгээ хэрэглэж хэвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл өгөх, гар утасны апплейкшнээ ашиглан хэрхэн хэрэглэх, улсын бүртгэлийн хичнээн төрлийн үйлчилгээг **E-Mongolia, E-Business** цахим платформаас тоон гарын үсэг ашиглан төрийн цахим үйлчилгээ авах чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга зүйн сургалтыг 2023 оны 10 сараас эхлэн хэрэгжүүлж эхэлсэн ба тус хугацаанд 20 төрийн байгууллагын 200 гаруй ажилтан, албан хаагчдыг сургалтанд хамруулж, тоон гарын үсгийн ач холбогдолыг таниулан сурталчилсан билээ.

4. Уг зорилтод сургалтыг цаашид үргэлжлүүлэн зохион байгуулж, сургуулийн ахлах ангийн сурагчдыг 2024 онд **“Цахим шилжилт-бүртгэлийн цахим үйлчилгээний хөтөч”**-өөр бэлтгэхээр төлөвлөсөн байсны дагуу Хуулийн хэрэгжилт



хамтын ажиллагааг дэмжих ажлын хүрээнд

Баянхонгор аймаг дахь Цахим үйлчилгээний хэлтэс, аймгийн Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран Төрийн цахим үйлчилгээг хэрэглэх, тоон гарын үсгийг хэрэглэх чадварыг сургагч багшаар дамжуулан нэмэгдүүлэхэд чиглэсэн "Цахим хөтөч-цахим ур чадварын сургагч багш" бэлтгэх сургалтыг арван жилийн сургуулийн 10 дугаар ангийн хүүхдүүдийг хамруулан 5 сарын 16, 17-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулав.

Тус сургалтанд аймгийн төвийн Номундалай, Номгон, Эрдэнэмандал, Эрдэм цогцолбор сургуулийн 10 дугаар ангийн 24 хүүхдийг хамруулж, "Цахим хөтөч-сургагч багш"-аар бэлтгэн сертификатаа 5 дугаар сарын 27-ны өдөр гардуулан өгөв.

Төрийн цахим үйлчилгээг сурталчлах, иргэд цахим үйлчилгээг авахад чиглүүлэгийн уриалч анхны (улсын хэмжээнд) "Цахим хөтөч-цахим ур чадварын сургагч багш" бэлтгэгдсэнээрээ энэ удаагийн сургалт ихээхэн онцлог байлаа.

Төрийн цахим үйлчилгээг хэрэглэх чадварыг сургагч багшаар дамжуулан нэмэгдүүлэхэд чиглэсэн "Цахим хөтөч-цахим ур чадварын сургагч багш" нарыг 2024 оны 06 дугаар сард бэлтгэсэн билээ. "Цахим хөтөч-цахим ур чадварын сургагч багш" нарыг чадавхжуулах 2-р ээлжийн сургалт, практик дадлага ажлыг 2024 оны 10 дугаар сарын 9-11-ны өдрүүдэд хэлтсийн байран дээр зохион байгуулсан. Уг сургалтаар "Цахим ур чадварын сургагч багш" нарынхаа үе тэнгийнхэндээ заах хичээлийг бэлтгэн өгч, чиглүүлсний дагуу сургагч багш нар маань 10 дугаар сарын 14-нөөс 10 дугаар сарын 18-ны өдрүүдэд Эрдэнэмандал, Номгон ахлах сургуулийн 10 дугаар ангийн сурагчдад "Цахим үндэстэн" болон "Цахим иргэн" гэж хэнийг хэлэх, "Цахим ур чадвар"-ыг хэрхэн эзэмших, мөн төрийн байгууллагуудын цахим үйлчилгээний нэр төрөл, цахим үйлчилгээг "Тоон гарын үсэг"-ээр хэрхэн авах, талаарх мэдлэг олгож, мэдээллийг түгээх сургалтыг амжилттай зохион байгуулж, үе тэнгийнхэндээ өөрийн ойр тойрны хүрээлэл дэх найз нөхөд, гэр бүлийнхэндээ мэдлэгээ түгээхийг уриалав. Тус сургалтанд 10 дугаар ангийн 168, 11 дүгээр ангийн 34 хүүхдүүд хамрагдсан байна.



Төрийн цахим үйлчилгээг сурталчлах, төрийн цахим үйлчилгээг авах ур чадварыг эзэмшүүлэх, ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн ажлыг хэрэгжүүлж "Цахим хөтөч" клубыг байгуулсан ба клубын суралцагч хүүхдүүдийнхээ ур чадварыг нэмэгдүүлэх ээлжит сургалтыг зохион байгууллаа. Энэ удаагийн сургалтыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар болон "Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв" УТҮГ хамтран "Цахимд зөв байя" уриатайгаар зохион байгууллаа.



Сургалтын хүрээнд Кибер аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал, Хиймэл оюун ухааны эерэг болон сөрөг нөлөө, Хувийн мэдээллээ зүй зохистой удирдах, хамгаалах, Цахим ул мөрөө хянах, хамгаалах, Цахим залилангаас урьдчилан



сэргийлэх, Эцэг эхийн хяналтын программ, Цахим орчин дахь донтолт, сэтгэл зүйн нөлөөлөл зэрэг сэдвийн хүрээнд мэдээлэл, зөвлөмж хүргэлээ.

## 1.2. Тоон гарын үсгийн олголтын талаарх тоон мэдээг харуулбал:



## **2.1.2. УБЕГ БОЛОН ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗРААС ИРҮҮЛСЭН ҮҮРЭГ ДААЛГАВАР, ЧИГЛЭЛИЙН ДАГУУ ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЛААР**

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаас ирүүлсэн үүрэг даалгавар чиглэлийн дагуу хийж хэрэгжүүлсэн ажлын талаар.

- **“Зөвлөмж хүргүүлэх тухай”** Тамгын газрын дарга бөгөөд ажлын хэсгийн ахлагчийн 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 2/10506 дугаартай албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу старлинк болон модемны сүлжээ холбох байршлыг үнэн зөв тогтоохтой холбоотой сонгуулийн хэсэг нэмэгдсэн, мөн санал авах байрны байршил өөрчлөгдсөнтэй холбоотойгоор сонгуулийн ирц бүртгэлийн мэдээ дамжуулах сүлжээ тестлэн шалгах, газар дээр нь очиж координат тогтоох ажиллагааг 9 цэг дээр хийхээр болсон судалгаа холбогдох зардал (явах км зам, шатахуун, хүн хүч, томилолт)-ын дүн, мэдээллийг хүргүүлж, шуурхай шийдвэрлүүлсэн байна.

-Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 1/12638 дугаарт албан бичгээр ирүүлсэн даалгаврын дагуу авсан арга хэмжээ, зохион байгуулсан ажлын талаар товч тайлагнаж байна.

**Нэг. Улсын бүртгэлийн хууль тогтоомжид үнэлгээ хийж, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журмуудыг судалж, хуулиас давсан зохицуулалт агуулсан журмууд байгаа эсэх талаар судлаж тайлагнах ажлын хүрээнд:**

Хэлтсийн зүгээс Улсын бүртгэлийн хуулиуд холбогдох журамтайгаа зөрчилдөж байгаа, мөн практикт хэрэглээнд хэрэгжих боломжгүй байгаатай холбоотойгоор нэмэлт өөрчлөлт оруулах, мөн хууль тогтоомжтой нийцүүлж иргэний улсын бүртгэлийн программд нэмэлт хөгжүүлэлт хийх зэрэг саналуудыг өмнө нь 2-3 удаа хүргүүлсэн байна.

Харин энэ удаад хууль, журамтай холбогдуулан 16 саналыг хавсралтаар хүргүүлж байна. /Хавсралт-1/

**Хоёр. Салбарын хүрээнд манлайлал, албан хаагчдын сахилга, хариуцлагыг өндөржүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд:**

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээ”-г нийт албан хаагчдад 2024 оны 10 дугаар

сарын 29-ны өглөө 08:00-09:00 цагт танилцуулж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин сахилга баттай хариуцлагатай байхыг анхааруулав. Уг сургалтанд хэлтсийн албан хаагчид танхимаар, сумдын улсын бүртгэгч нарт цахимаар хамрагдлаа.

Аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран “Авлигаас ангид төрийн үйлчилгээ” нээлттэй хаалганы өдөр арга хэмжээг 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр хэлтэс дээрээ зохион байгууллаа. Уг арга хэмжээний хүрээнд хэлтсийн нийт 40 албан хаагчдад “Нийтийн албан тушаалтан авилгаас ангид байх хэм хэмжээ” сэдвээр сургалт орохын зэрэгцээ Байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн талаар тайлагнаж арга зүйн зөвлөгөө мэдээллийг авлаа. Мөн үйлчилгээ авч буй иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, дүнг албан хаагч нарт танилцуулж, иргэдээс “Талархал” хүртсэн улсын бүртгэгч нарыг хамт олны өмнө сайшааж, анхаарах асуудлын талаар хэлэлцэж, чиглэл зөвлөмж өглөө.

**Гурав. Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин /киоск/, цахим машинаар /киоск/ үзүүлэх үйлчилгээний тоог нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд:**

2024 оны 01 дүгээр сарын 01-нээс 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн хооронд Хэлтсийн байранд байрласан киоск машинаар тоон гарын үсэг 4504, киоск машинаар иргэний улсын бүртгэлийн 4476 лавлагаа олгосон байна.

**2.1.3. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн /№19/ Удирдах ажилтны шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн талаар:**

- **Гадаад паспортын түгээлтийн процесс сайжруулах санал танилцуулах даалгаврын тухайд,** Иргэний улсын бүртгэлийн үндэсний энгийн болон цахим гадаад паспортын бүртгэл манай аймгийн хэмжээнд зөвхөн нэг нэгжид буюу хэлтэс дээр бүртгэл хөтлөгддөгтэй холбоотойгоор үндэсний гадаад паспортын бүртгэлийн олголтын ажиллагааг зөвхөн 1 цэг дээрээс /хэлтэс/ олголт хийдэг нь иргэдэд ихээхэн хүндрэл, чирэгдэл учруулдаг. Тодруулбал, хөдөө алслагдсан суманд амьдардаг, мал малладаг малчин иргэд захиалсан паспортоо авахад малаа хаяад аймаг орох боломжгүй байна, дахин дахин ойрхон хугацаатайгаар явж чадахгүй байна зэрэг шалтгааныг тоочин паспортоо ирж авахгүй байна. Мөн Итгэмжлэгдсэн хүнээр дамжуулан авч болохыг зөвлөж байгаа боловч хууль ёсны итгэмжлэл хийж явуулдаггүй төдийгүй ирсэн хүн нь хүний бичиг баримтыг авах гэж улиардаг, үүнээсээ болоод элдэв гомдол гаргах, улсын бүртгэгчийг хэл амаар доромжлох зэрэг үйлдлүүд удаа дараа гарч байна. Энэхүү олголтын процесс дээр

гарч байгаа уг доголдлыг арилгах, иргэдийн хүсэлт, гомдлыг шийдвэрлэх үүднээс гадаад паспортын бүртгэлийн программ дээр /21-ын олголтын бүртгэл шиг/ “**олголтын бүртгэл**” гэсэн нэмэлт үйлчилгээг нэмүүлэх саналыг ИУБГ болон МТГ-т хэлтсийн даргын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 13/745 дугаарт албан бичгээр хүргүүлсэн. Мөн ИУБГ болон МТГ-аас Гадаад паспортын бүртгэлийн программ дээр “гадаад паспортын олголтын бүртгэл” нэмж өгсөн ба зааврын дагуу “бар” кодыг уншуулан олголтын бүртгэлийг хөтлөж байна. 11 дүгээр сарын 14-ний өдрөөс “бар” кодыг уншуулан нэгж хүлээн авсан бүртгэл эхэлсэн ба өнөөдрийн байдлаар ИУБГ-аас жагсаалтаар ирүүлсэн 168 гадаад паспортыг “бар” кодоор бүртгэж хүлээн авсан байна.

**2.1.4.** Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.2 дахь хэсэг, “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны А/128 дугаар тушаал, Хяналт шалгалтын газар, Иргэний улсын бүртгэлийн газраас хамтран 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 6/9869 дугаарт албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу хийж хэрэгжүүлсэн ажлын талаар тайланг Илтгэх хуудсаар заасан хугацаанд нь [ts.bayarmaa@burtgel.gov.mn](mailto:ts.bayarmaa@burtgel.gov.mn) тайлагнасан байна. Ирүүлсэн хугацаатай үүрэг даалгавар, чиглэлийн хүрээнд дараах хоёр асуудлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлыг товч танилцуулахад; Үүнд:

**Нэг. Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн талаар:**

1.1. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдрийг хүртэлх хугацаанд Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл нийт 1874, харин 2024 оны 06 дугаар сарын 29-ний өдрөөс 2024 оны 8 дугаар сарын 09-ний өдрийг дуусталх хугацаанд 934 бүртгэл бүртгэн, баталгаажуулсан байна. Шилжилт хөдөлгөөний бүртгэлийн тоон мэдээг ИУБГ-аас ирүүлсэн хүснэгтийн дагуу гарган [ts.bayarmaa@burtgel.gov.mn](mailto:ts.bayarmaa@burtgel.gov.mn) хаягаар хүргүүлсэн болно. Шилжилт хөдөлгөөний бүртгэлийн тоон мэдээг 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс 2024 оны 08 дугаар сарын 09-нийг дуусталх, мөн 2024 оны 06 дугаар сарын 29-ний өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдрийг дуусталх гэсэн хоёр хугацаатайгаар гаргасан.

Бүртгэлийн үйл ажиллагаанд өдөр тутам хяналт тавьж, улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд нягтлан шалгаж цахимжуулалт, баталгаажуулалт хийгээгүй улсын бүртгэгчтэй холбогдож түргэн шуурхай баталгаажуулж, цахимжуулахыг шаардаж ажилласны дүнд Иргэний шилжилт хөдөлгөөний 1874 бүртгэлийг 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдөр багтаан баталгаажуулж, цахимжуулалтыг бүрэн хийж дуусгав.

1.2. Улсын ахлах бүртгэгчийн зүгээс улсын бүртгэгч нарт иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл хөтлөхөд анхаарах асуудлын талаар урьдчилан хэдэн хэдэн удаагийн зөвлөмж, чиглэлийг хүргүүлж мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж, Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл зогсох өдөр иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтэрт “шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоосон” тухай тэмдэглээг хийлгүүлэхийн зэрэгцээ ИУБ-22 маягтын үлдэгдлийг хүлээлгэн өгсөн актыг улсын бүртгэгч бүрээр үйлдүүлж, 2024 оны 08 дугаар сарын 10-нд эх хувиар нь бүрэн хүлээн авч лацдан, хадгалах ажлыг зохион байгуулав.

**Хоёр. Шилжилт хөдөлгөөний бүртгэлд хяналт шалгалт хийсэн талаар:**

Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлд хяналт шалгалтыг дараах байдлаар хийлээ. Үүнд:

1. Иргэний улсын бүртгэлийн тухай хууль болон “Монгол улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээллэх журам”-д заасан нотлох баримтуудыг бүрэн, үнэн, зөв бүрдүүлсэн эсэх; шилжилт хөдөлгөөний бүртгэлд өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрлийг зохих журмын дагуу авсан, Итгэмжлэл нь Иргэний хуульд заасан шаардлагыг хагасан эсэх; эрхийн улсын бүртгэлд бүртгэлтэй газар, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн хаяг, өмчлөгчийн мэдээллийг санд шалгаж мэдээллийг зөрүүгүй бүртгэл хийсэн эсэх; ИУБ-22 маягтад улсын бүртгэгч болон бүртгүүлсэн иргэн, итгэмжлэгдсэн төлөөлөгч нар гарын үсэг зурсан эсэх; мэдээллийн цахим санд нотлох баримтыг бүрэн цахимжуулсан эсэх, шилжилт хөдөлгөөний бүртгэлийг тухай бүрт баталгаажуулсан эсэх зэрэгт хяналт шалгалтыг хийлээ.

2. 2024 оны 06 дугаар сарын 29-ний өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдрийг дуусталх хугацаанд хийсэн шилжилт хөдөлгөөний 934 бүртгэлд хяналт шалгалтыг хийхэд хууль, журам зөрчсөн зөрчил илрээгүй болно.

**2.2. Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн үүрэг даалгавар, чиглэл түүний хэрэгжиилтийн талаар:**

**2.2.1.** Иргэний бүртгэлийн цахим мэдээллийн санг цэгцлэх, үнэлэлт дүгнэлт өгөх ажлын хүрээнд иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд нэгээс дээш бүртгэгдсэн, эсхүл бүртгэлийн аль нэг талбарын мэдээлэл зөрүүтэй, бүртгэлийн дугаар, бүртгэсэн он, сар, өдөр, нас барсан газар зэрэг мэдээлэл нь зөрүүтэй давхардсан тоогоор нас барсны 6689 бичилт байгаагаас өөрийн нэгжид харъяалах 237 бичвэрийг шалгахтай холбоотой “Нас барсны бүртгэл шалгах тухай” Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 3/12305 дугаарт албан бичгээр ирүүлсэн хугацаатай үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган

ажиллаж, хэрэгжилтийг 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр, мөн 2024 оны 03 дугаар сарын 13-ний өдөр тус тус Илтгэх хуудсаар тайлагнасан байна.

1.Жагсаалтаар ирүүлсэн 237 иргэний мэдээллийг харъяалах сум сумаар нь ангилж, сумын улсын бүртгэгч нарт Хэлтсийн даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 1/900 дугаарт албан бичгээр хугацаатай даалгавар өгч, нэг бүрчлэн тулган шалгуулсны дараа улсын ахлах бүртгэгч дахин шалгахад “нас барсны бүртгэл” нь хөрвүүлэлтийн явцад бүртгэсэн он сар өдөр цахим санд буруу орсон, 2 өөр газар давхардуулж бүртгэсэн, нэг газар 2 удаа бүртгэсэн, нэг бүртгэл 2-4 удаа бүртгэгдсэн, нас барсан өвчний онош ХААТР маягтад бичигдсэнээс цахим санд зөрүүтэй орсон, 2-3 удаа давхар бүртгэгдсэн ХААТР-22 маягтад нас барсан он, сар, өдөр, нас барсан газрын болоод нас барсан шалтгаан, оношийн мэдээлэл зөрүүтэй бичигдсэн, цахим санд бүртгэсэн нэгжийн мэдээлэл, нас барсан он, сар, өдөр зөрүүтэй орсон гэх мэт мэдээллийн асар зөрүүтэй бүртгэгдсэн бүртгэлүүд байв.

2.Улсын бүртгэгч нараас шалгаад ирүүлсэн мэдээллийг улсын ахлах бүртгэгч нэг бүрчлэн дахин шалгаж, холбогдох дүгнэлт гаргуулахаар Хяналтын улсын байцаагчид танилцуулаад, Хяналтын улсын байцаагчийн 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 801, 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 818 дугаарт дүгнэлтүүдийг гаргуулж, Хяналтын улсын байцаагчийн 801 дугаарт дүгнэлтийг Хэлтсийн даргын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 1/96 дугаарт албан бичгээр, харин 818 дугаарт дүгнэлтийг Хэлтсийн даргын 2024 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 1/111 дугаарт албан бичгээр тус тус хүргүүлсэн байна.

**2.2.2.** Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 3/3362 дугаарт албан бичгийн хавсралт жагсаалтаар ирүүлсэн 2262 иргэнээс өөрийн нэгжид хамаарах 53 иргэний мэдээллийг нягтлан шалгахад зөрчилгүй 39 бүртгэл, эцэг эхийн нэр, регистрийн дугаарыг ХААТР-11 маягтад буруу бичигдсэний улмаас цахим санд төрсний бүртгэлд эцэг, эхийн мэдээлэл ороогүй, овог нэр өөрчлөлтийн болон эцэг /эх/ тогтоолтын бүртгэлд өмнөх мэдээлэл ороогүй зэрэг зөрчилтэй 9 бүртгэл, төрсний бүртгэл **“алдаатай”** төлөвтэй 1 бүртгэл, 2 ба түүнээс дээш давхар регистрийн дугаарт 2 иргэний бүртгэл байв. Илэрсэн зөрчлийг Хяналтын улсын ахлах байцаагчийн 2023/004865 дугаарт дүгнэлтийг үндэслэн төрсний бүртгэлд ургийн овог ороогүй, эцэг /эх/ тогтоосны бүртгэлд ургийн овог ороогүй, төрсний бүртгэлд эцэг эхийн мэдээлэл ороогүй зэрэг зөрчлүүдийг арилгаж цахим санд нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийг бүртгэхийн зэрэгцээ ХААТР-11 маягтад эцэг, эхийн нэрийг буруу бичсэн, эцэг эхийн регистрийн дугаар буруу бичсэн 10

бүртгэлд Засвар өөрчлөлтийн мэдэгдэх хуудас буюу ИБЗ-1 маягт бичүүлж, цахимжуулав.

**2.2.3. “Зөвлөмж, мэдээлэл хүргүүлэх тухай”** Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 3/4273 дугаартай албан бичгээр ирүүлсэн зөвлөмж, мэдээллийн дагуу улсын бүртгэгч нарт e-mongolia.mn системээр дамжуулан шилжилт хөдөлгөөний бүртгэлийг бүртгэхэд анхаарах асуудал, тус системээр ирүүлсэн иргэний хүсэлт, хаяг нотолсон баримтыг хэрхэн шалгах талаар холбогдох зөвлөгөө зааврыг өгч, бүртгэл баталгаажуулалтад хяналт тавьж, тухай бүрт нь зөвлөж ажиллав. Тайлант хугацаанд e-mongolia.mn системээр 136 иргэний хүсэлт ирснийг 58 бүртгэж, 78 бүртгэлийг татгалзаж шийдвэрлэсэн байна.

**2.2.4. “Зөвлөмж хүргүүлэх тухай”** Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 3/4861 дугаартай албан бичгийн дагуу дараах ажлыг хэрэгжүүлж, тайлагналтыг заасан хугацаанд буюу 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Илтгэх хуудсаар тайлагнасан байна. Хийж хэрэгжүүлсэн ажлын талаар дурьдвал;

1. 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 25-ны хүртэлх хугацаанд Үндэсний гадаад паспортын 487 бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.

Мөн хэвлэлтээс ирсэн паспортыг иргэн болгоны утсанд мэссэж илгээх болон аймаг орон нутгийн зарын болон мэдээллийн нэгдсэн группээр захиалсан паспорт хэвлэлтээс ирсэн тухай тогтмол мэдээллэж, олголтыг шуурхай зохион байгуулж байна.

2. Гадаад паспортын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хийх дотоод хяналтыг гадаад паспортын баталгаажуулалтын бүртгэлээр дамжуулан өдөр тутамдаа тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч хийж байна. Баталгаажуулалтын бүртгэл хийхдээ иргэний мэдээлэл иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим санд бүртгэгдсэн Иргэний үнэмлэхний бүртгэл, Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл, гадаад папортын бүртгэл, төрсний бүртгэл болон бусад бүртгэл, нэрийн санд бүртгэгдсэн мэдээлэл хоорондоо зөрүүтэй байгаа эсэх талаар тогтмол шалгаж, нэрийн галиг, овог нэр зөрүүтэй байвал зөрүүтэй мэдээллийг иргэнээс өргөдөл, тайлбар авч тодруулан мэдээллийн зөрүүг мэдээллийн цахим санд засаж залруулсны дараа баталгаажуулалтын бүртгэлийг хийж байгаа болно.

Жишээлбэл, 2024 оны 04 сарын үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлийн тухайд вк01232232 регистрийн дугаартай иргэн Мөнгөнхуягийн

Баатархуягийн овог Мөнгөнхуяг нэрийн санд галиг “Mongonkhuyag”, харин иргэний үнэмлэхний бүртгэлд галиг “Mungonkhuyag” гэж зөрүүтэй бүртгэгдсэний улмаас гадаад паспортын бүртгэл овгийн галиг нэрийн санд бүртгэгдсэн “Mongonkhuyag” галигаар бүртгэгдсэнийг Хяналтын улсын байцаагчийн 2023/004865 дугаарт дүгнэлтээр нэрийн санд галигийг зөв болгож, засаж залруулсны дараа баталгаажуулалтыг хийсэн болно. Онцлог нь, ийм тохиолдол хааяа нэг гарч байна, гарч ирсэн тохиолдол бүрт мэдээллийг залруулах, бүртгэл алдаатай, буруу бүртгэгдэх эрсдлээс сэргийлэн ажиллаж байна.

3. Тасгийн тухайд үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлийг 2 улсын бүртгэгч хөтлөж байгаа ба тус улсын бүртгэгч нарт 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 3/4861 дугаарт албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийг танилцуулж, учирч болох эрсдэл, гаргаж болохгүй алдаа, зөрчилтэй баримт бичгийг иргэнд олгож болохгүй, зөрчилтэй бүртгэлэс иргэнд учирсан хохирлыг улсын бүртгэгч өөрөө хариуцах зэргийг тайлбарлан таниулах ажлыг 4 сарын 19-ны өдрийн сургалтаар зохион байгууллаа.

4. Үндэсний энгийн гадаад паспорт хэвлэлтээс ирмэгц, цахимжуулах ажлыг шуурхай хийж байхыг улсын бүртгэгч нарт танилцуулж, цахимжуулалтад тогтмол хяналт тавьж байна.

5. Өнөөдрийн байдлаар Үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлийн хураамжтай холбоотой зөрчил илрээгүй байна.

**2.2.5. “Чиглэл хүргүүлэх тухай”** Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 3/10321 дугаартай албан бичгээр ирүүлсэн Чиглэлийг танилцуулах, улсын бүртгэгч нарыг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах чиг үүргийн дагуу дараахь ажлыг хийж гүйцэтгэн, 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдөр Илтгэх хуудсаар тайлагнасан байна. Үүнд:

### **1. Сургалтын талаар:**

1.1. Дээр дурьдагдсан чиглэл болоод УБЕГ-ын даргаас 2024 оны 08 дугаар сарын 21-ий өдөр иргэний улсын бүртгэлд гарч байгаа алдаа, зөрчилд онцгой анхаарч арга хэмжээ авч ажиллах хугацаатай үүрэг даалгаврын хүрээнд ИУБГ-аас Иргэний улсын ахлах бүртгэгч нарт зориулсан 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн цахим “Зүүм” сургалтанд оролцож, одоо үүсээд буй гэмт хэргийн шинжтэй бүртгэл хөтөлсөн талаарх мэдээллийг, мөн бүртгэлийн зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх, зөрчилтэй бүртгэл хийхгүй байх талаар мэргэжлийн арга зүйн зөвлөгөө мэдээллийг авч, улсын бүртгэгчдийг мэргэжлийн арга зүйгээр хангаж ажиллах үүргийг авсан үүрэг даалгаврын дагуу хэлтсийн даргатай хамтран улсын




бүртгэгч нарт цахим зүүм сургалтыг 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 17 цагт зохион байгуулж, холбогдох мэдээллийг дамжуулж, арга зүйн зөвлөгөө зааврыг өгөв. Тус цахим сургалтанд хэлтсийн 6 албан хаагчид танхимаар, сумдын улсын бүртгэгч нараас 14 улсын бүртгэгч цахимаар оролцлоо.

Тус сургалтаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн /№13/ удирдах ажилтны шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгавар болон 3/10321 дугаарт албан бичгээр ирүүлсэн Чиглэлийг танилцуулж, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Улсын бүртгэлийн багц хууль тогтоомжийг чанд мөрдөж ажиллах, иргэний улсын бүртгэлийг хөтлөхдөө заавал хурууны хээгээр бүртгэл хөтлөх, аливаа гарч болох эрсдлээс урьдчилан сэргийлж ажиллах, хэн нэгний шахалт дарамтанд өртөхгүй, танил талын гуйлга хүсэлтэнд болгоомжтой, сэрэмжтэй хандах, цахим залиланх гэмт хэргээс сэргийлж ажиллах зэрэг мэдээллийг өгч, арга зүйн зөвлөгөө зааврыг өглөө.

## 2. Сурталчилгаа, хамтын ажлын талаар:

2.1. Тоон гарын үсэг болоод бичиг баримт ашиглан цахим гэмт хэрэг, залилах гэмт хэрэг гарч байгаатай холбогдуулан эдгээр гэмт хэргээс иргэд өөрсдийгөө хэрхэн хамгаалах, урьдчилан сэргийлэх, болгоомжлуулсан, анхааруулсан контент бэлтгэх сурталчлах талаар Баацагаан сумын улсын бүртгэгч Ж.Оргилмаа, Өлзийт сумын улсын бүртгэгч Ц.Эрдэнэчимэг, Баянхонгор сумын улсын бүртгэгч Г.Бадамханд, хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Э.Адъяабаяр, З.Дуламсүрэн нарт хугацаатай үүрэг өгч, цахим залилангаас сэргийлсэн 3 төрлийн контентыг нийтэд түгээлээ. Мөн тоон гарын үсгийг хурууны хээгээр олгох болсонтой холбоотой анхаарах асуудлын талаар улсын бүртгэгч нарт санамж, чиглэлийг өгөв.




2.2. Аймгийн ИТХ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон аймгийн Цагдаагийн газартай цахим залилангийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах талаар зөвлөлдөх уулзалтыг хийсний дүнд аймгийн ГХУСАЗЗ –өөс өмчийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, өмчийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хэсэг байгуулагдсан ба уг ажлын хэсэгт улсын бүртгэлийн байгууллагын төлөөлөл хэлтсийн дарга орсон нь энэ

чиглэлийн ажилд хуулийн хэрэгжилтийг хангах хамтын ажиллагааг өргөжүүлэх боломж бий боллоо.


### 3. Мэргэжил арга зүйгээр хангах арга хэмжээний хүрээнд:

3.1. Иргэний улсын бүртгэлийн дугаар эсхүл, регистрийн дугаараар бүртгэл хөтөлсөн тухай тэмдэглэлийг тогтмол хөтөлж, уг тэмдэглэлийг 7 хоног бүрийн 5 дахь өдөр улсын ахлах бүртгэгчид мэдээллэж байх



үүргийг өгсөн ба тэмдэглэлийн загварыг 100 шэйр дээр байршуулж улсын бүртгэгч нарт хүргэж, 7 хоног бүрийн 4 дэх өдөр регистрийн дугаараар бүртгэл хийсэн бүртгэлийн мэдээг авч, ИУБГ-т тогтмол хүргэн ажиллалаа.

3.2. Тоон гарын үсгийг заавал хурууны хээгээр олгохтой холбоотойгоор программд оруулсан өөрчлөлтийг танилцуулж, программд “Tool” системийг хэрхэн уншуулж ажиллагааг



хангах талаар видео зааварчлагыг бэлтгэн сумдын улсын бүртгэгч хүргэж, бүртгэлийн үйл ажиллагаа саадгүй явуулах арга хэмжээг өөрсдийн хэмжээндээ авч хэрэгжүүлж, программтай холбоотой мэдээллийг Мэдээлэл технологий газар болоод улсын бүртгэгч нарт шуурхай дамжуулж, зохих асуудлыг дор бүрт нь шийдвэрлэх, шийдвэрлүүлэх ажлыг цаг тухай бүрт нь зохион байгуулж бүртгэлийн үйл ажиллагааг чирэгдэлгүй, саадгүй явуулж ирлээ.

3.3. “Чиглэл хүргүүлэх тухай” Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 3/10321 дугаарт албан бичгээр ирүүлсэн Чиглэлийг хэлтсийн нийт албан хаагчдад цахим сургалт хийхээс өмнө хэлтийн фэйж хуудсаар танилцуулсан бөгөөд заавал хэвлэж авч байнга уншиж, мөрдөж ажиллахыг чиглэл болгов.

## ЦАХИМ ШИЛЖИЛТ- ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЦАХИМ САНГ ЦЭГЦЛЭХ АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР

3.1. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим сангийн талбарын мэдээллийн зөрүүтэй мэдээллийг арилгах, цэгцлэх ажлын хүрээнд:

**3.1.1.** Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 3/3362 дугаарт албан бичгийн хавсралт жагсаалтаар ирүүлсэн 2262 иргэнээс өөрийн нэгжид хамаарах 53 иргэний мэдээллийг нягтлан шалгахад зөрчилгүй 39 бүртгэл, эцэг эхийн нэр, регистрийн дугаарыг ХААТР-11 маягтад буруу бичигдсэний улмаас цахим санд төрсний бүртгэлд эцэг, эхийн мэдээлэл ороогүй, овог нэр өөрчлөлтийн болон эцэг /эх/ тогтоолтын бүртгэлд өмнөх мэдээлэл ороогүй зэрэг зөрчилтэй 9 бүртгэл, төрсний бүртгэл **“алдаатай”** төлөвтэй 1 бүртгэл, 2 ба түүнээс дээш давхар регистрийн дугаарт 2 иргэний бүртгэл илэрсэн ба илэрсэн зөрчлийг арилгасан талаар:

- Хяналтын улсын ахлах байцаагчийн 2023/004865 дугаарт дүгнэлтийг үндэслэн төрсний бүртгэлд ургийн овог ороогүй, эцэг /эх/ тогтоосны бүртгэлд ургийн овог ороогүй, төрсний бүртгэлд эцэг эхийн мэдээлэл ороогүй зэрэг зөрчлүүдийг арилгаж цахим санд нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийг бүртгэв.

- ХААТР-11 маягтад эцэг эхийн нэрийг буруу бичсэн, эцэг эхийн регистрийн дугаар буруу бичсэн 10 бүртгэлд Засвар өөрчлөлтийн мэдэгдэх хуудас буюу ИБЗ-1 маягт бичүүлж, цахимжуулав.

**3.1.2.** Иргэний бүртгэлийн цахим мэдээллийн санг цэгцлэх, үнэлэлт дүгнэлт өгөх ажлын хүрээнд иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд нэгээс дээш бүртгэгдсэн, эсхүл бүртгэлийн аль нэг талбарын мэдээлэл зөрүүтэй, бүртгэлийн дугаар, бүртгэсэн он, сар, өдөр, нас барсан газар зэрэг мэдээлэл нь зөрүүтэй давхардсан тоогоор нас барсны 6689 бичилт байгаагаас өөрийн нэгжид харъяалах 237 бичвэрийг шалгахтай холбоотой **“Нас барсны бүртгэл шалгах тухай”** Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 3/12305 дугаарт албан бичгээр ирүүлсэн хугацаатай үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж тайлагнасан болно. Жагсаалтаар ирүүлсэн 237 иргэний мэдээллийг шалгахад “нас барсны бүртгэл” нь хөрвүүлэлтийн явцад бүртгэсэн он сар өдөр цахим санд буруу орсон, 2 өөр газар давхардуулж бүртгэсэн, нэг газар 2 удаа бүртгэсэн, нэг бүртгэл 2-4 удаа бүртгэгдсэн, нас барсан өвчний онош ХААТР маягтад бичигдсэнээс цахим санд зөрүүтэй орсон, 2-3 удаа давхар бүртгэгдсэн ХААРТ-22 маягтад нас барсан он, сар, өдөр, нас барсан газрын болоод нас барсан шалтгаан, оношийн мэдээлэл зөрүүтэй бичигдсэн, цахим санд бүртгэсэн нэгжийн мэдээлэл, нас барсан он, сар, өдөр зөрүүтэй орсон гэх мэт мэдээллийн асар зөрүүтэй бүртгэгдсэн бүртгэлүүд байсан. Тодруулбал, 237 бичвэр нь 117 иргэний бүртгэл байх ба үүнээс 2 өөр газар давхардуулж бүртгэсэн бүртгэл 31, нэг газар 2 удаа бүртгэсэн 86 бүртгэл, нэг бүртгэлийг 2 удаа бүртгэсэн бүртгэл 112, нэг бүртгэл

3 удаа бүртгэгдсэн бүртгэл 3, нэг бүртгэл 4 удаа бүртгэгдсэн бүртгэл 1 тус тус байв. Нэг бүртгэл 3 ба 4 удаа бүртгэгдсэн бүртгэлтэй холбоотойгоор 237 бичвэр 240 болж нэмэгдсэн ба Хяналтын улсын байцаагчийн 801 дугаарт дүгнэлтээр Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд давхардуулан бүртгэсэн 33 бүртгэл, нэг бүртгэлийг давхар бүртгэсэн 22 бүртгэлийг, Хяналтын улсын байцаагчийн 818 дугаарт дүгнэлтээр мэдээллийн санд давхардуулан бүртгэсэн 42 бүртгэл, нэг бүртгэлийг давхар бүртгэсэн 17 бүртгэлийг, нийт 114 бүртгэлийг хүчингүй болгуулсан байна. Нас барсны бүртгэлийн талбар болгоны мэдээллийг шалгаж Хяналтын улсын байцаагчийн 2023/004865 дугаарт дүгнэлтийг үндэслэн цахим санд 114 бүртгэлийн “нас барсан газар”, “нас барсан шалтгаан”-ы талаарх мэдээллийг нөхөн оруулж, зөрүүтэй байсныг залруулж, нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийг бүртгэв.

**3.1.3.** Иргэний бүртгэлийн цахим мэдээллийн санг цэгцлэх, үнэлэлт дүгнэлт өгөх, сонгогчийн нэрсийн жагсаалт гаргахаас өмнө зөрүүтэй, алдаатай мэдээллийг цэгцлэх ажлын хүрээнд Хэлтсийн даргын 2023 оны 10 сарын 13-ны өдрийн 1/738 дугаарт албан бичгээр Нас барсан боловч иргэний улсын бүртгэлийн **“нас барсны бүртгэл”-д** хамрагдаагүй иргэдийн судалгааг гарган ирүүлэх үүрэг даалгаврыг сумдын улсын бүртгэгч нарт өгсөн. Уг даалгаврын хүрээнд Нас барсан боловч нас барсны бүртгэлд хамрагдаагүй 15 иргэний мэдээлэл илрүүлэв. **“Нас барсны бүртгэл”-д** хамрагдаагүй иргэдийн зөрчлийг арилгах арга хэмжээг шуурхай авахыг Хэлтсийн даргын 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 1/787 дугаарт албан бичгээр үүрэг болгосон бө өнөөдрийн байдлаар **5 иргэний мэдээллийг** нас барсны бүртгэлд нөхөн бүртгэсэн байна. Нас барсны бүртгэлд бүртгүүлж чадаагүй шалтгааныг тодруулахад Эмнэлэгийн байгууллагаас бичгээ авч чадаагүй, нас барсан бичгийг авахад эмнэлгийн байгууллагаас гаргаж өгөхгүй байна гэсэн тайлбарыг иргэд хэлж байна. Нас барсны бүртгэлд бүртгүүлээгүй иргэдийн ар гэрийнхэнтэйн холбогдож, иргэний улсын бүртгэлд “нас барсны бүртгэл”-ийг нөхөн бүртгэх ажлыг 2, 3 дугаар сард дахин зохион байгуулахаар төлөвлөн, Эрүүл мэндийн байгууллагуудыг энэ чиглэлээр дэмжлэг үзүүлэн, хамтран ажиллахыг хүссэн хүсэлтийг хүргүүлээд байна.

**3.1.4.** Цахим сан дахь зөрчлийг арилгах ажлын хүрээнд 1 бүртгэл 2 удаа бүртгэгдсэн “нас барсны бүртгэл”-ийн 23 мэдээллийг шалгаж, хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг гаргуулан заасан хугацаанд нь Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлж холбогдох бүртгэлүүдийг хүчингүй болгуулах ажлыг зохион байгуулав.

**3.1.5.** Иргэний бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь талбарын мэдээллийн зөрүүтэй, зөрчилтэй байдлыг арилгахад өдөр тутамдаа анхаарч ажиллаж байгаа ба өдөр тутамдаа бүртгэгддэг төрсний бүртгэл, эцэг тогтоолтын бүртгэл, ургийн овог, овог, нэр өөрчлөлтийн бүртгэл, гадаад паспортын бүртгэл, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд анх удаа бүртгэх бүртгэл зэрэг бүртгэлүүдийг бүртгэн, баталгаажуулахдаа талбарын мэдээллийг зөрүүтэй, алдаатай мэдээллүүдийг засах, залруулах ажлыг тогтмол хийж байна.

Тайлант хугацаанд ургийн овог ороогүй, төрсний бүртгэл алдаатай, эцэг тогтоолтын болон ургийн овог, овог, нэр өөрчлөлтийн бүртгэлд өмнөх мэдээлэл ороогүй, төрсний бүртгэлд эцэг, эхийн мэдээлэл ороогүй, эцэг эхийн мэдээлэл буруу орсон зэрэг алдаатай, зөрүүтэй 350 гаруй иргэний мэдээллийг засварласан байна.

## **2.1. Цахим архивын баяжилтыг хийх чиглэлээр:**

**2.1.1.** Нэг талаас цахим архивын баяжилтыг хийх, нөгөө талаас архивын ажлын ачааллыг бууруулах зорилгоор 2007-2021 онуудад төрсөн иргэдийн ХААТР-11, ХААТР-13, ХААТР-14 маягтуудыг цахимжуулах ажлыг 2024 оны 12 сараас эхлүүлсэн ба өнөөдрийн байдлаар Баацагаан, Баянцагаан, Бөмбөгөр, Богд, Галуут, Баян-өндөр, Баян-Овоо, Гурванбулаг, Баянбулаг, Заг, Өлзийт, Эрдэнэцогт, Хүрээмарал, Бууцагаан, Баянговь, Баянлиг, Жинст зэрэг 17 сум бүрэн цахимжуулж дууссан, харин Жаргалант сум 2007-2010 он, Шинэжинст сум 2017-2021, Баянхонгор сум онуудын маягтуудыг 12 сардаа багтаан цахимжуулж дуусахаар ажиллаж байна.

**2.1.2.** Мөн Иргэний улсын бүртгэлийн мэдээлэл лавлах системд цахимжаагүй 1963-1998 оны ХААТР-15-ыг цахимжуулах, иргэний улсын бүртгэлийн цахим санд бүртгэгдээгүй гэрлэлтийн бүртгэлийг нөхөн оруулах ажлыг тасгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2024 оны 2, 3 сард багтаан хийхээр төлөвлөсөн байсан боловч сонгуулийн ажилтай холбогдуулан хугацааг хойшлуулсан байсан ба одоогийн байдлаар сумдын улсын бүртгэгч нар өөрийн нэгжид хамаарах /одоогийн байдлаар 14 нэгж/ гэрлэлтийн бүртгэлийг нэг бүрчлэн шүүгээд дуусгасан, харин 12 сардаа багтаан үлдсэн нэгжид хамаарах гэрлэлтийн бүртгэлээ шүүх, мөн бүгд бүрэн цахимжуулж дуусгахаар хуваарийн дагуу ажиллаж байна.

**2.1.3.** Иргэний улсын бүртгэллийн цахим архивт цахимжаагүй Нас барсны бүртгэлийн 2020-2021 оны 976 ширхэг ХААТР-18 маягтыг бүрэн цахимжуулж дуусгалаа.

## **УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЯВУУЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР**

#### **4.1.Алслагдсан сум, багийн иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг хүргэх ажлын хүрээнд:**

4.1.1.Анхан шатны нэгжид болон зорилтод бүлэгт улсын бүртгэлийн явуулын төхөөрөмжийг ашиглан улсын бүртгэлийн үйлчилгээг газар дээр нь хүргэж, үйлчилгээний хүртээмжтэй, шуурхай байдлыг нэмэгдүүлэх, хуулийн хэрэгжилт, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилтыг хангах арга хэмжээний хүрээнд **“Улсын бүртгэлийн явуулын үйлчилгээ үзүүлэх өдөрлөг”**-ийг **“Иргэнд ойрхон төрийн үйлчилгээ”** уриатайгаар сумуудад ажиллахдаа засаг захиргааны анхан шатны нэгж сумын ЗДТГ-ууд болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллалаа. Тодруулбал,

Жаргалант сумын сумын ЗДТГ, улсын бүртгэгч Т.Алтаншагайгийн ангийн 1994 оны төгсөгчид болон аймгийн Нэгдсэн эмнэлэгийн эмч нараас бүрдсэн нарийн мэргэжлийн эмч нарын баг, аймгийн Цагдаагийн газар болон төгсөгчдөөс бүрдсэн хуулийн зөвлөгөө өгөх мэргэжлийн багтай хамтран **“Иргэнд ойрхон төрийн үйлчилгээ”** уриатайгаар **"НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ"** арга хэмжээг 2024 оны 03 дугаар сарын 09-нөөс 03 дугаар сарын 10-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Тус арга хэмжээний хүрээнд Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр Төрсний бүртгэл 1, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд 3, лавлагаа 3, гадаад паспорт 49 нийт 57 бүртгэл, давхардсан тоогоор 56 иргэнд зөвлөгөө өгөв.

- Баянговь сумын Засаг даргын Тамгын газартай хамтран тус суманд **"Төрийн үйлчилгээ иргэдэд ойрхон"** уриатай Улсын бүртгэлийн явуулын үйлчилгээг 2024 оны 5 дугаар сарын 6, 7-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Тус явуулын үйлчилгээгээр үндэсний цахим гадаад паспортын 76 бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 24 бүртгэлийн үйлчилгээг үзүүлж, улсын бүртгэл (иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл)-тэй холбоотой асуудлаар 30 иргэнд эрх зүйн зөвлөгөө өгсөн байна. Баянговь сум нь аймгийн төвөөс 230 км зайтай алслагдсан бөгөөд тус сумын иргэд, малчид хавар цагийн их ажлын үед газар дээрээ улсын бүртгэлийн үйлчилгээг авсан нь бидний цаг, зардлыг хэмнэсэн чухал арга хэмжээ боллоо гэж талархав.

- Богд, Жинст сумын иргэдийн захиалгын дагуу гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг хүргэхээр Жинст, Богд суманд ЗДТГ-тай хамтран суманд нь очиж улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн ба тус арга хэмжээний хүрээнд 100 гаруй иргэдэд гадаад паспортын олголтын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна.

- Улсын бүртгэгч томилогдоогүй байсантай холбогдуулан Хүрээмарал сумын иргэдэд улсын бүртгэлийн явуулын үйлчилгээ үзүүлэх ажлыг 2024 оны 1

сарын 2-наас 01 сарын 12-ныг хүртэлх хугацаанд улсын бүртгэгч С.Авирмэдийг томилон ажиллуулсан ба тус хугацаанд 14 иргэнд тоон гарын үсэг олгож, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 4, төрсний бүртгэл 3, эцэг тогтоолтын бүртгэл 1, иргэний үнэмлэхний дахин 5, нийт 27 бүртгэл бүртгэсэн байна.

#### **4.2 Зорилтод бүлгийн иргэдэд улсын бүртгэлийн явуулын үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд:**

- Хөгжлийн бэрхшээлтэй 4 иргэнд иргэний үнэмлэх дахин авах, шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгүүлэх хүсэлтийн дагуу гэрээр нь очиж иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж, бичиг баримттай болголоо.

- Төрийн үйлчилгээг хүртээмжтэйгээр хүргэх зорилтын хүрээнд ажлын цагаар ажлаасаа гарч чадахгүйн улмаас төрийн үйлчилгээ авч чаддаггүй сургууль, цэцэрлэг, цагдаа, цэргийн байгууллагуудын албан хаагч нарт байгаа байршил буюу ажлын байран дээр нь очиж улсын бүртгэлийн зөөврийн төхөөрөмжийг ашиглан явуулын үйлчилгээг үзүүлэх ажлыг 2024 оны 05 дугаар сараас эхлэн зохион байгуулсан ба аймгийн төвийн нийт 6 сургууль, 17 цэцэрлэг, аймгийн Цагдаагийн газар, Зэвсэгт хүчний 339 дүгээр анги зэрэг нийт 25 байгууллагад албан бичиг хүргүүлэн, тухайн байгууллагын өөрсдийн захиалсан өдөр цагт нь тохируулан хуваарь гарган хуваарийн дагуу очиж улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүллээ. Өнөөдрийн байдлаар 3, 4, 5 дугаар цэцэрлэг, Цагдаагийн газар, 2, 4 дүгээр 10 жил зэрэг нийт 6 байгууллагууд улсын бүртгэлийн үйлчилгээ аваад байна. Дээрх байгууллагуудад очиж үзүүлсэн иргэний улсын бүртгэлийн үйлчилгээнээс тоон гарын үсэг олголт 20, гадаад паспортын бүртгэл 19, иргэний үнэмлэхний дахин 1, нийт 40 бүртгэл хийгдсэн байна.

- Улсын бүртгэлийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд ажлын цагаар улсын бүртгэлийн үйлчилгээ авч чадахгүй байгаа төрийн албан хаагчдаас гадна мөн ажлын өдрүүдээр улсын бүртгэлийн үйлчилгээгээр бүрэн авч дуусаагүй байгаа болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан “Иргэнд ойрхон **Төрийн үйлчилгээ**” уриатай “**Бүртгэлийн үйлчилгээг Бямба гарагт**” төлөвлөгөөт ажлыг 2024 оны 09 сараас эхлүүлэн 7 хоног бүрийн хагас сайн өдөр өглөөний 11 цагаас 16 цаг хүртэлх хугацаанд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна. Тус төлөвлөгөөт ажлын хүрээнд өнөөдрийн байдлаар иргэний улсын бүртгэлийн 82 удаагийн бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.

- Эрдэнэцогт сумын ЗДТГ-тай хамтран Баянхонгор сумын Шаргалжуут 8 багийн /алслагдсан аймгийн төвөөс 60 гаруй км зайтай/ иргэд зөөврийн

төхөөрөмжийг ашиглан иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг 50 гаруй иргэдэд улсын бүртгэгч М.Энхцэцэг үзүүллээ.

## **СОНГУУЛИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР**

Улсын бүртгэлийн байгууллагын Сонгуулийн хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу хуваарьт болон цаг үеийн ажлыг шуурхай зохион байгуулж, тайланг хуулийн хугацаанд нь багтаан Илтгэх хуудсаар тайлагнаж, эргэх холбоотой ажиллаж, цаг үеийн чухал ажлыг амжилттай дуусгалаа.

**5.1. Улсын Их Хурлын Сонгуулийн хуулийн хэрэгжилтийг хангах, Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэхэд бэлэн байдлыг хангах бэлтгэл ажлын хүрээнд:**

### **5.1.1. Мэдээллийн сангийн мэдээллийн зөрүүг арилгах чиглэлээр:**

- “Иргэний улсын бүртгэлийн санд **“нөхөн шивэлт”** төлөвтэй гэх төрсний бүртгэл 7, “нөхөн шивэлт” төлөвтэй гэх эцэг /эх/ тогтоосны бүртгэл 21, “нөхөн шивэлт” төлөвтэй үрчлэлтийн бүртгэл 1, нийт 29 бүртгэл жагсаалтаар ирүүлснийг цахим сан болон Лавлах мэдээллийн сан, цаасан суурьт эх баримттай нэг бүрчлэн тулган шалгаж, холбогдох нэмэлт өөрчлөлтийн бүртгэлүүдийг бүртгэж, хяналтын улсын байцаагчаар дүгнэлт гаргуулан шийдвэрлүүлсэн байна. Үүнд:

- Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд нэгээс дээш бүртгэгдсэн, эсхүл бүртгэлийн аль нэг талбарын мэдээлэл зөрүүтэй, бүртгэлийн дугаар, бүртгэсэн он, сар, өдөр, нас барсан газар зэрэг мэдээлэл нь зөрүүтэй гэх нас барсны 237 бичвэрийг нэг бүрчлэн шалгаж, шийдвэрлэн тайланг Илтгэх хуудсаар Иргэний улсын бүртгэлийн газарт заасан хугацаанд тайлагнасан болно.

- Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 3/3362 дугаарт албан бичгийн хавсралт жагсаалтаар ирүүлсэн 2262 иргэнээс өөрийн нэгжид хамаарах 53 иргэний мэдээллийг нягтлан шалгахад зөрчилгүй 39 бүртгэл, эцэг эхийн нэр, регистрийн дугаарыг ХААТР-11 маягтад буруу бичигдсэний улмаас цахим санд төрсний бүртгэлд эцэг, эхийн мэдээлэл ороогүй, овог нэр өөрчлөлтийн болон эцэг /эх/ тогтоолтын бүртгэлд өмнөх мэдээлэл ороогүй зэрэг зөрчилтэй 9 бүртгэл, төрсний бүртгэл **“алдаатай”** төлөвтэй 1 бүртгэл, 2 ба түүнээс дээш давхар регистрийн дугаарт 2 иргэний бүртгэл байсныг зохих журмын дагуу шийдвэрлэн, тайланг Илтгэх хуудсаар тайлагналаа.



- Иргэний бүртгэлийн цахим мэдээллийн санг цэгцлэх, үнэлэлт дүгнэлт өгөх ажлын хүрээнд иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд төрсөн он, сар, өдөр, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, ижил 3876 иргэний мэдээллээс өөрийн нэгжид хамаарах иргэдийн мэдээллийг мэдээллийн сан, эх нотлох баримттай тулган нягтлаж, холбогдох арга хэмжээг авч ажиллахтай холбоотойгоор “Бүртгэл шалгах тухай” Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 3/1319 дугаарт албан бичгээр ирүүлсэн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллав.

Тус ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- “Бүртгэл шалгах тухай” Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 3/1319 дугаарт албан бичгийн хавсралт жагсаалтаар ирүүлсэн 3876 иргэнээс өөрийн нэгжид хамаарах 65 иргэний мэдээллийг нягтлан шалгуулахаар Тасгийн даргын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дугаарт албан даалгавраар хугацаатай үүрэг өгч, мэдээллийн цахим сан, мэдээллэл лавлах сантай нэг бүрчлэн тулган шалгуулав.

- Улсын бүртгэгч нараас шалгаад ирүүлсэн мэдээллийг улсын ахлах бүртгэгч мэдээллийн цахим сан, мэдээллэл лавлах системд цахимжсан баримт болон цаасан суурьт баримттай нэг бүрчлэн тулган дахин нягтлахын зэрэгцээ цахимжаагүй ХААТР маягт, баримт бичгийг цахимжуулах, талбарын зөрүүтэй мэдээлэлд нэмэлт өөрчлөлт оруулах, зөрчилтэй давхар бүртгэгдсэн бүртгэлийг дахин шалгуулж, хүчингүй болгуулахтай холбоотойгоор холбогдох дүгнэлт гаргуулахаар Хяналтын улсын байцаагчид албан хүсэлт гаргах зэрэг ажлыг гүйцэтгэв. Тодруулбал,

- Үндсэн санд “**тодорхойгүй**” төлөвтэй 4 иргэний мэдээллийг Хяналтын улсын ахлах байцаагчийн 2023/004865 дугаарт дүгнэлтийг үндэслэн “**одоо байгаа**” гэсэн төлөвт шилжүүлж, алдааг залруулав.

- Төрсний бүртгэлд болон эцэг /эх/ тогтоосны бүртгэлд ургийн овог, эцгийн болон эхийн мэдээлэл ороогүй зэрэг зөрүүтэй мэдээллийг зөв болгож залруулах ажлын хүрээнд Хяналтын улсын ахлах байцаагчийн 2023/004865 дугаарт дүгнэлтийг үндэслэн 8 иргэний төрсний бүртгэлд, 1 иргэний эцэг /эх/ тогтоосны бүртгэлд нэмэлт өөрчлөлтийг бүртгэв.

- Цаасан суурьт эх баримт болон Мэдээлэл лавлах системд цахимжиж орсон баримтыг иргэний улсын бүртгэлийн цахим санд орсон бүртгэл бүртэй нэг бүрчлэн тулгаж нягтлан мэдээлэл лавлах системд цахимжиж ороогүй 76 баримтыг цахимжуулав.

- Нэг иргэн 2 ба түүнээс дээш регистрийн дугаартай 6 иргэний 13 бүртгэлийг шалгуулж, дүгнэлт гаргуулахаар Хяналтын улсын байцаагч Л.Мэндбаярт шилжүүлэв. Заавал утсаар холбогдож бүртгэлийн мэдээллийн зөрүүг арилгуулах шаардлагатай 7 иргэнтэй утсаар холбогдож холбогдох зөвлөгөөг өгөхийн зэрэгцээ харъяалагдах сумын улсын бүртгэгчид давхар зөвлөгөөг өглөө.

- **“Иргэний байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн зөрчилтэй иргэдийн зөрчлийг арилгах арга хэмжээг авч ажиллах” болон Шилжилт хөдөлгөөний бүртгэлд хяналт тавих ажлын хүрээнд “Зөвлөмж, чиглэл хүргүүлэх тухай”** Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 3/10685 дугаарт албан бичгээр ирүүлсэн зөвлөмж чиглэлийг улсын бүртгэгч нарт сургалтын болон мэдээллийн хэлбэрээр, мөн Хэлтсийн даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 1/900 дугаарт албан бичгээр уламжлан танилцуулж арга зүйн зөвлөгөөг өдөр тутамдаа өгч, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж байна.

Шилжилт хөдөлгөөний бүртгэлийг алдаагүй бүртгэх, шилжилт хөдөлгөөний бүртгэлтэй холбоотойгоор гарч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хаягийн мэдээллийг [www.eprs.mn:7001/eprs2](http://www.eprs.mn:7001/eprs2) болон [eprs-land.gazr.mn](http://eprs-land.gazr.mn) цахим сангуудад тулган шалгаж, нягтлаж үнэн зөв бүртгэл хийлгүүлэхээр тус сангуудыг **“ашиглаж харах”** эрхийг улсын бүртгэгч нарт нээлгүүлсэн болно.

Шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хөтлөхдөө анхаарах зүйл, хууль тогтоомжийн нэг мөр ойлгож зөв хэрэглэх, багаас багт, сумаас сумд шилжин суурьшсан боловч шилжилт хөдөлгөөний бүртгэлээ хийлгүүлээгүй иргэдтэйгээ холбогдож шилжилт хөдөлгөөний бүртгэлээ хийлгүүлэх талаар мэдээлэл өгч, бүртгэлд хамруулах, мөн шинээр үүссэн гудамж, хорооллын хаягт амьдарч байгаа боловч хаягийн шилжилт хөдөлгөөний бүртгэлээ хийлгүүлээгүй иргэдтэй холбогдож бүртгэлд хамруулах чиглэлээр удаа дараа чиглэл зөвлөмжийг өгөхийн зэрэгцээ хаягийн зөрчилтэй иргэнийн зөрчлийг арилгуулах арга хэмжээг шуурхай зохион байгуулах чиглэлээр Хэлтсийн даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 1/888 дугаарт албан бичгээр хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг тухай бүрд нь шаардан хаягийн зөрчлийг арилгуулав. .

Хаягийн зөрчлийг хянан шалгах ажлын хүрээнд хөдөө сумдаас байнга оршин суух хаягийн зөрчилтэй 40 иргэний бүртгэл илэрсэн ба өнөөдрийн байдлаар 15 иргэний зөрчил арилгаад байна.

Шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу хөтөлж байгаа эсэхэд хяналтын улсын байцаагч, улсын ахлах бүртгэгч нар өдөр тутамдаа хяналтыг тавьж байна. Мөн 2023 оны 10 дугаар сарын 01-нээс 2024 оны 04 дүгээр

сарын 28-ны өдрийг дуусталх хугацаанд бүртгэгдсэн нийт 1358 шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хяналтын улсын байцаагчтай хамтран шалгаж, тухай бүрт нь арга зүйн зөвлөмж, чиглэлээр хангаж ажиллалаа.

Иргэний улсын бүртгэлийн газраас өгсөн “Сонгуулийн хуулийн хэрэгжүүлэхэд учирч болох эрсдлийг тодорхойлох” үүрэг даалгаврын дагуу Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд учирч болох эрсдлийг тодорхойлж, Хэлтсийн даргын албан бичгээр [otgon@burtgel.gov.mn](mailto:otgon@burtgel.gov.mn) хаягаар хүргүүлсэн байна.

#### **5.1.2. Сонгуулийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийн талаар:**

- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар улсын бүртгэлийн байгууллагын хүлээсэн үүрэг, чиглэлийн дагуу хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд туссан Сонгуулийн хэсэг байгуулсан ИТХ-ын тогтоолыг болон сонгуулийн санал авах байрны мэдээллийг шивж оруулах, цахимжуулах, хаягийг тулгах ажлын хүрээнд “Сонгуулийн хэсэг байгуулах” Баянхонгор аймгийн 20 сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын “Сонгуулийн хэсэг байгуулах” тогтоолыг хүлээн авч, хүлээн авсны даруйд Иргэний улсын бүртгэлийн газарт бичиг хэргийн E-Дос системээр болон шуудангаар хүргүүлэхийн зэрэгцээ Сумдын ИТХ-ын тогтоолуудыг хүлээн авсан, хүргүүлсэн, [election.gazr.mn](http://election.gazr.mn) программд цахимжуулсан зэрэг бүртгэл, мэдээллийг Хэлтсийн даргын 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дугаарт албан бичгээр хавсралтын хамт хүргүүлсэн.

- “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн Сонгогчийн нэрийн жагсаалтад “түр хасав” тэмдэглэгээтэй бүртгэгдсэн иргэдийн мэдээлэл шалгасан тухай” Сонгогчдын нэрийн жагсаалтад **“түр хасав”** тэмдэглэгээтэй сонгогчийн мэдээллийг шалгаж, авч хэрэгжүүлж байгаа ажлын талаарх тайланг заасан хугацаанд багтаан Илтгэх хуудсаар тайлагнав.

- Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн Сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэх ажиллагааг хэлтсийн Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх ажлын хэсэг хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч, Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч, Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч нар, мэдээлэл технологийн ажилтан, ахлах нягтлан бодогч, бичиг хэрэг, архивч гэсэн бүрэлдэхүүнтэйгээр Тагнуулын Ерөнхий газрын Баянхонгор аймаг дахь хэлтсийн ахлах ажилтан Д.Мөнх-Эрдэнийн хяналтын дор хэлтсийн 102 дугаарт тоот өрөөнд 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн өглөөний 09 цаг 30

минутад эхлэж, 15 цаг 40 минутад хэвлэж дуусган, ажлын тайланг ИУБГ-т Илтгэх хуудсаар тайлагнав.

Баянхонгор аймгийн Сонгуулийн 104 хэсгийн нийт 56190 сонгогчдын жагсаалтыг 2, 2 хувь хэвлэж актыг бэлтгэн дугтуйлан лацадлаа.


**5.1.3. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн “Сонгогч шилжилт”-ийн бүртгэлийг бүртгэж, лавлагаа хэвлэсэн тухай**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай 24 дүгээр зүйлийн 24.1, 24.2-д заасан сонгогч шилжилтийн бүртгэлийг энэ зүйлийн 24.3-д заасан хугацаанд багтаан бүртгэлийг цаасан буюу цахим хэлбэрээр бүртгэж, баталгаажуулан, холбогдох лавлагааг үүсгэн, хэвлэх ажиллагааг хийж гүйцэтгэсэн талаар тайлагнахад; Үүнд:



1. МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн цаглабарын дагуу 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс өмнө хуулийн хугацаандаа багтаан “Сонгогчдын нэрийн жагсаалт”-ыг хүргүүлсэн боловч Сонгогч өөрийн болон гэр бүлийн гишүүдийн мэдээлэлтэй танилцах боломжоор хангах ажлыг хуульд заасан хугацаанд эхлүүлэх, зохион байгуулах ажилд сумдын сонгуулийн хороо, хэсгийн хороод туйлын хариуцлагагүй хандаж байсан тул “Сонгогч шилжилтийг бүртгэх ажлыг шуурхай зохион байгуулж Сонгогчийн эрхийг хангах, сонгогч Сонгох эрхээ эдлэж хууль зүйн боломжийг бүрдүүлж, Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний заяамал эрх болох Сонгох эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, сонгогч шилжилтийн бүртгэлтэй холбоотой аливаа гомдол гаргуулахгүй байх зорилгоор аймгийн Сонгуулийн хороонд Хэлтсийн даргын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 1/358 дугаарт албан бичгийг хүргүүлсэн ба үүгээр сонгуулийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах, хамтын ажиллагааг чухалчлахад уриалсан, мөн анхааруулсан болно.

2. Мөн “Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, давхардал зөрчлийг арилгах, танилцуулах, сонгогч шилжих журам”-ын 4.8-д заасан чиг үүргийн дагуу аймгийн Сонгуулийн хорооноос сонгогчийн бүртгэл, мэдээллийг гаргуулах авахын тулд хэлтсийн даргын зүгээс аймгийн Сонгуулийн хорооны хуралд оролцон



мэдээлэл өгч, яаралтай гарган өгөхийг удаа дараа сануулсан боловч Сонгогчийн мэдээллийг гаргаж өгөхгүй хугацаа их алдаж байсан тул Хэлтсийн даргын 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 1/376 дугаарт албан бичиг хүргүүлэн шуурхай гаргуулах арга хэмжээг авахыг ихээхэн эрмэлзлээ. Гэвч аймгийн сонгуулийн хороо сонгогчийн бүртгэлийг заасан хугацаанд гаргаж өгөөгүй буюу 2024 оны 06 дугаар сарын 12-нд сонгуулийн байгууллагын ажилтны сонгогч шилжих бүртгэлийн мэдээллийг 12-нд, нэр дэвшигч, түүний менежер, шадар туслагч нарын бүртгэлийг 6 дугаар сарын 13-ны үдээс хойш өгснөөр манай байгууллагын ажилд ихээхэн хүндрэл учрууллаа. Гэхдээ хэлтсийн нийт хамт олны хүчин чармайлтын үр дүнд Сонгогч шилжих бүртгэлийг хуулийн хугацаандаа багтаан бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотойгоор аливаа гомдол саналгүй амжилттай хийж дуусгалаа.

МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн 24.1-д заасан сонгогчдоос Сонгуулийн байгууллагын ажилтан 665, итгэмжлэгдсэн ажилтан 70, мэдээлэл технологийн ажилтан, даамал 70, сонгуулийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий цагдаагийн албан хаагч 99, нийт 904 сонгогч сонгогч шилжилтийн бүртгэл хийлгүүлсэн байна. Харин МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн 24.2-д заасан сонгогчидоос 129 сонгогч Сонгогч шилжилтийн бүртгэл хийлгүүлсэн байна.

Сонгогч шилжин ирсэн бүртгэлийн лавлагаа 1033, шилжин явсан бүртгэлийн лавлагаа 923, нас барсны бүртгэлийн лавлагаа 23, эрх сэргээсэн бүртгэлийн лавлагаа 149, нийт 2128 лавлагаа үүсгэж, хэвлэсэн байна.

#### **5.1.4.Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтны хууль эрх зүй, программ хангамж, технологийн сургалт зохион байгуулсан тухай**

МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний 1 дэх /МУИХСТХ-ийн 20.1 дэх хэсэг/ ажил болох Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, түүнтэй холбоотой хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх, санал авах өдөр сонгогчийн бүртгэлийг нягтлан шалгахтай холбоотой анхаарах асуудлууд, сонгогчийн бүртгэлийн программ хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар программын болон сонгогчийн бүртгэлийн сургалтыг УБЕГ-ын Тамгын газрын даргаар батлуулсан сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, тайланг 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдөр Илтгэх хуудсаар ИУБГ-т тайлагнасан байна.

Сургалтын явцад гарсан аливаа асуудлыг тухай бүрт нь ажлын хэсгийн ахлагчаар дамжуулан УБЕГ-т хандан шуурхай шийдвэрлүүлж, сургалтыг амжилттай зохион байгуулж, сонгогчдын нэрийн жагсаалтыг 104 хэсэг тус бүрээр хэвлэж, улсын

бүртгэгч нарт хүлээлгэн өгч, хуульд заасан хугацаанд Сонгогчдын нэрийн жагсаалтыг хүргүүллээ.

## **5.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчийн хурлын 2024 оны ээлжит сонгуулийн ажлыг талаар:**

5.2.1. Орон нутгийн сонгуультай холбогдуулан орон унтгийн сонгуулийн хэсэг байгуулсан сумын ИТХ-ын тогтоолуудыг хүлээн авч байна. Журмын дагуу хуулийн хугацаанд нь багтаан ИУБГ-т хүргүүлж, сонгуулийн программд цахимжуулж, мэдээллийг оруулав.

### **5.2.2. Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад эрх зүйн сургалт зохион байгуулж, Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, хүргүүлэх ажлыг зохион байгуулсан тухай**

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд Итгэмжлэгдсэн ажилтанд зариулсан хууль, эрх зүйн болон мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зорилго бүхий сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр батлагдсан хөтөлбөрийн дагуу улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад зохион байгуулав.

- Сургалтанд танхимаар 6, цахимаар 108 итгэмжлэгдсэн ажилтан хамрагдаж, “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн танилцуулга, анхаарах асуудал” сэдвээр тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхам, “Сонгогчдын нэрийн жагсаалт дахь сонгогчийн мэдээллийг шалгуулах, гомдлыг шийдвэрлэхэд итгэмжлэгдсэн ажилтны анхаарах асуудал” сэдвээр улсын бүртгэгч Э.Адъяабаяр тус тус сургалт хийв. Мөн нийт итгэмжлэгдсэн ажилтнуудад итгэмжлэгдсэн ажилтны эрх, үүрэг, одоо болон цаашид зохион байгуулах ажлын талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг хэлтсийн дарга Ц.Мөнхжаргал хийлээ.

### **5.2.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгуулийн Сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, хэвлэх, танилцуулах, хүргүүлэх ажлын хүрээнд:**

- Сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэх ажиллагааг хэлтсийн Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх ажлын хэсэг хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч, Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч, Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч нар, мэдээлэл технологийн ажилтан, ахлах нягтлан бодогч, бичиг хэрэг гэсэн бүрэлдэхүүнтэйгээр Тагнуулын Ерөнхий газрын Баянхонгор аймаг дахь хэлтсийн ахлах ажилтан Д.Мөнх-Эрдэнийн хяналтын дор хэлтсийн 202 дугаарт тоот өрөөнд 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн

өглөөний 09 цаг 00 минутад эхлэж, 15 цаг 30 минутад хэвлэж дуусгасан ба Баянхонгор аймгийн Сонгуулийн 106 хэсгийн нийт 56447 сонгогчдын жагсаалтыг 2, 2 хувь хэвлэж актыг бэлтгэн дугтуйлан лацадлаа. Сонгогчдын нэрийн жагсаалтад үндсэн сонгогч 55121, “түр хасав” төлөвтэй 1326 сонгогч бүртгэгдсэн байв.

- Сонгуулийн хууль тогтоомжоор улсын бүртгэлийн байгууллага Сонгогчдын нэрийн жагсаалтыг цаасан хэлбэрээр 2 удаа үйлдэж, хүргүүлэх үүргийн дагуу Сонгогчдын нэрийн жагсаалтад орсон өөрчлөлтийг тусган хэвлэх, үйлдэх ажлыг 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан.

Сонгогчдын нэрийн жагсаалтанд өөрчлөлт орсонтой холбоотойгоор үүссэн 28 лавлагааг хэвлэж, Тагнуулын Ерөнхий газрын Баянхонгор аймаг дахь хэлтсийн ахлах ажилтан Д.Мөнх-Эрдэнэд танилцуулан шалгуулсны дараа лавлагаа үүссэн 22 хэсгийн Итгэмжлэгдсэн ажилтанд тэмдэглэл үйлдэн хүлээлгэн өгч, өөрчлөлтийн лавлагааг Сонгогчдын нэрийн жагсаалтад тусгуулав. Сонгогчдын нэрийн жагсаалтын эцсийн тайлангаар Баянхонгор аймгийн 106 хэсгийн Сонгогчдын нэрийн жагсаалтад 56448 сонгогч бүртгэгдсэнээс нэмэгдсэн 1, хасагдсан 1344, иргэний улсын бүртгэлтэй холбоотой өөрчлөлт 6, лавлагаа тусгагдсан байдлаар сонгогчийн тоо 55105 бүртгэгдсэн байна.

Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх ажлын явцад хөдөлмөрийн аюулгүй байдал зөрчигдөөгүй, ямар нэгэн алдаа, зөрчил гараагүй болно.

- **Сонгогчдын нэрийн жагсаалт хуульд заасан хугацаандаа багтаан хүргүүлэх ажлыг зохион байгуулсан ба** Баянхонгор сумын 11 хэсгийн Сонгогчдын нэрийн жагсаалтыг Хэлтсийн дарга Баянхонгор сумын сонгуулийн хорооны байранд хэсгийн хорооны дарга нарт хүлээлгэн өгөв. Харин хөдөөгийн 19 сумын 95 хэсгийн Сонгогчдын нэрийн жагсаалтыг говь, хангай бүсээр хуваагдан 2 чиглэлийн маршрутаар ажлын 2 хэсгийг 2024 оны 09 дүгээр сарын 12-ны орой гарган 2024 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн дотор хүлээлгэн өгөх ажлыг зохион байгууллаа. Говийн чиглэлд аймгийн Засаг даргын Тамгын газраас Ланд-76 маркийн автомашинаар, харин хангай чиглэлд хэлтсийн ланд-80 автомашинаар явлаа.

Харин өөрчлөлт оруулсан Сонгогчдын нэрийн жагсаалтыг 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр үйлдэж, хэсэг тус бүрийн итгэмжлэгдсэн ажилтан болон сумын улсын бүртгэгч нараар дамжуулан хэсгийн хороодод Сонгогчдын нэрийн жагсаалтыг хүргүүлэв. Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх ажлын явцад хөдөлмөрийн аюулгүй байдал зөрчигдөөгүй, ямар нэгэн алдаа, зөрчил гараагүй болно.

#### **5.2.4. Сүлжээ тестлэж шалгасан ажлын талаар:**

Шинээр хэсэг нэмэгдсэн, санал авах байрны байршил өөрчлөгдсөнтэй холбоотой сүлжээ тестлэх, шалгах ажлыг Сонгогчдын нэрийн жагсаалт хүргэх ажилтайгаа хамтатган хийсэн ба 9 байршилд сүлжээ тестлэх шалгах ажлыг хийлээ. Сүлжээ тестлэж, шалгасан ажлын дэлгэрэнгүй мэдээллийг Мэдээлэл технологийн газарт хүргүүлсэн болно.

5.2.5. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-д заасан чиг үүргийн дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газраас санал авах өдрөөс 90-ээс доошгүй хоногийн өмнө буюу 2024 оны 07 дугаар сарын 13-нд өөрийн цахим хуудаст Сонгогчдын нэрийн жагсаалтыг байршуулсан ба уг цахим хуудаст байршуулсан Сонгогчдын нэрийн жагсаалттай сонгогчдыг танилцуулах, улмаар сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гомдлыг хуулийн хугацаанд багтаан хүлээн авч, шийдвэрлэх ажлыг зохион байгуулав. Санал авах өдөр дуусталх хугацаанд цахим хуудаст байршуулсан Сонгогчдын нэрийн жагсаалттай 745 сонгогч өөрийн болон гэр бүлийн гишүүдийн мэдээлэлтэйгээ танилцсан байх ба энэ хугацаанд 7 сонгогч мэдээлэл зөрүүтэй /хаяг зөрүүтэй/ талаар гомдол гаргасныг шийдвэрлэж хариуг өгсөн байна.

#### **БУСАД АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:**

##### **6.1. Улсын бүртгэгч нарыг мэргэжлийн арга зүйгээр хангаж ажилласан талаар:**

6.1.1. Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэл, зөвлөмж бүрийг цаг тухайд нь улсын бүртгэгч нартаа дамжуулан мэдээллэж, арга зүйгээр ханган ажиллаж байна. Мөн төрсний бүртгэлийг бүртгэхдээ нэрийн толийг бүрэн дүүрэн ашиглаж байх, нэрийг сонгохдоо нэрийн галигийг давхар харж хянаж байж нэрийг сонгох талаар өдөр тутамдаа зөвлөгөө өгч, гарсан алдаа бүрийг даруй засуулж баталгаажилтыг хийж байна.

6.1.2. Шилжилт хөдөлгөөний бүртгэлийг бүртгэхэд анхаарах асуудлын талаар хяналтын улсын байцаагчтай хамтран арга зүйн сургалтыг 2 удаа зохион байгуулсан, мөн албан бичгээр 2 удаа чиглэл, хэлтсийн ажилтнуудын хаалттай facebook группээр 4 удаагийн чиглэлийг өгч, мэргэжил арга зүйгээр хангаж, арга зүйн туслалцаа үзүүлэв.

6.1.3. Иргэний улсын бүртгэл хөтлөхөд анхаарах асуудал, бүртгэлийн эх нотлох баримтыг үнэлэх, хуулийг зөв ойлгож хэрэглэх чиглэлээр улсын бүртгэгч нарт танхимын нэгдсэн сургалтыг 2 удаа хийсэн.



6.1.4. 2023 оны 12 дугаар сарын 18-ны өглөөний шуурхай онлайн хурлаас Улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотойгоор үүсч байгаа эрсдлийг бууруулах, эрсдлээс урьдчилан сэргийлэх, эрсдлийг боломж болгон ашиглах тал дээр хэлтэс, нэгж, хүн бүр идэвхи санаачлагатай ажиллахыг үүрэг болгохын зэрэгцээ зарим нэг онцгой төрлийн бүртгэл болон бүртгэлийн үйл ажиллагаатай холбогдуулан аливаа эрсдлээс сэргийлж, хариуцлагатай ажиллахыг үүрэг болгосныг хэлтсийн нийт албан хаагчдад танилцуулахын зэрэгцээ, холбогдох зөвлөмжийг боловсруулан хэлтсийн даргаар гарын үсэг зуруулан албажуулж албан бичгээр мэдэгдэж хүргүүлэв. Уг зөвлөмжөөр бүртгэлтэй холбоотой асуудлаар, тодруулбал, "Гадаад паспортын бүртгэл"-ын талаар, гадаад паспортын үйлдвэрээс паспорт сугалж авах асуудлыг бүр мөсөн хориглохын зэрэгцээ гадаад паспорт авахтай холбоотойгоор утсаар ярьж, хүнээр яриулж албан хаагч, нэгжүүдэд дарамт асуудал үүсгэхгүй байхыг анхааруулж, хэрэв гадаад паспорттой асуудлаар ярих хэрэг, уламжлах хүсэлт гарвал Хэлтсийн дарга, Иргэний тасгийн дарга нарт уламжлан танилцуулж байхыг, Бүртгэлтэй холбоотойгоор хувь хүний мэдээллийг хамгаалах талаар, хуульд зааснаар хуулиар тусгайлан эрх олгогдсон эрх бүхий байгууллагуудад улсын бүртгэлийн байгууллагаас холбогдох мэдээллийг өгнө. Албан бичиг ирүүлсэн, хүсэлт тавьсан байгууллага, хувь хүн бүрд мэдээлэл өгөхгүй байх үүрэгтэйг хатуу анхааруулсан, мөн албан хаагч бүр өөрсдийн эзэмшдэг техник тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах, компьютерийн нууц кодоо сар тутам сольж хэвших, улмаар улсын бүртгэгч бүр тог тасарсан, сүлжээ тасарсан тохиолдол бүрд хувийн тэмдэглэл хөтлөх, мөн тухай бүрд нь улсын ахлах бүртгэгч болон мэдээлэл технологийн ажилтанд тогтмол мэдэгдэж байх ажлыг хэвшүүлэх, улсын бүртгэгч бүр 2024 оны үр дүнгийн гэрээнд болон үйл ажиллагааны төлөвлөгөөндөө мэдээлэл технологийн чиглэлээр суралцах чиглэлээ сайтар сонгож, судлаж оруулсан байхыг үүрэг болгож, үр дүнгийн гэрээнд контент, постер бэлтгэж сурах ур чадварт суралцах арга хэмжээг тусгуулав.

6.1.5. Тайлан хугацаанд сумдын улсын бүртгэгч нарт 6 удаагийн хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг гаргуулан авсан ба энэ нь улсын бүртгэгч иргэний улсын бүртгэлийн цахим архив, цахим сантай бүрэн ажиллаж, бүрэн ашиглаж сурах чадварыг сайжруулах, улмаар аливаа тоо дүн мэдээнд дүгнэлт хийх, харьцуулалт хийх чадварыг суулгах, албан бичиг зөв, стандартын дагуу боловсруулж сургах, асуудалд бодитой хандаж, асуудлыг зөв гаргаж тавьдаг чадвартай болгох гэх зэрэг олон талын ач холбогдлыг эрэлхийлсэн улсын бүртгэгч нарыг чадварыг сайжруулахад чиглэгдсэн ажлуудын нэг байв.

6.1.6. Шилжилт хөдөлгөөний бүртгэл бүртгүүлэх иргэний хаягийг нотлох гол нотлох баримт болох эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний холбогдох мэдээллийг шалгах зорилгоор эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн [www.eprs.mn:7001/eprs2](http://www.eprs.mn:7001/eprs2) болон [eprs-land.gasr.mn](http://eprs-land.gasr.mn) сангуудыг албан хэрэгцээнд ашиглахдаа Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг ажлын шаардлагаар ашиглаж байгаа этгээд тухайн мэдээлэлтэй холбоотой хуулиар тогтоосон нууцыг хадгалах үүрэгтэй.; 9.4.12.улсын бүртгэлтэй холбоотой төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг задруулахгүй байх; Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1.хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх; 5.1.2.хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх; гэж, мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны А/1306 дугаар тушаалаар батлагдсан “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг ашиглах, түүний хадгалалт, хамгаалалт, нууцлалын аюулгүй байдлыг хангаж ажиллах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.9 дэхь заалтыг тус тус ягштал мөрдөж, аливаа гарч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж ажиллахыг анхааруулсан зөвлөмж, чиглэлийг хүргүүлсэн байна.

6.1.6.Баянхонгор аймгийн Нотариатын танхимын нотариатуудтай 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өглөөний 08:00 цагт “Өглөөний цай” зөвлөлдөх уулзалтыг хийгээд дараах хэд хэдэн асууддыг зөвшилцөн нэг мөр шийдэлд хүрсэн шийдэлтэй холбогдуулан улсын бүртгэгч нарт холбогдох зөвлөгөө, чиглэлийг хүргүүлсэн байна. Тодруулбал, 1/.улсын бүртгэгч нар Итгэмжлэл дээр улсын бүртгэл хийлгүүлэх гэсэн ерөнхий агуулга бичсэн, аль эсвэл ямар төрлийн бүртгэл хийлгүүлэхээр төлөөлж байгаа нь тодорхой бус итгэмжлэлийг хүлээж авахгүй байхыг, 2/.нотариатын гэрчилсэн Итгэмжлэлийн бар кодыг хуурамчаар үйлдсэн кэйс гарсан байна. Иймд шилжилт хөдөлгөөний бүртгэлтэй холбоотой Улаанбаатар хот болон бусад аймгуудад хийгдсэн Итгэмжлэлийг хуулбарлан хийхгүй байх, заавал эх хувийг нь шаардаж байхаар тохиролцсон тул шилжилт хөдөлгөөний бүртгэл хийхдээ улсын бүртгэгч нар өөр аймаг, хотоос ирсэн Итгэмжлэлийн эх хувийг авч, бүртгэл хийх; 3/.шилжилт хөдөлгөөний болон сонгогч шилжилтийн бүртгэлтэй холбоотойгоор гарч байгаа асуудлыг тухайн цаг үед нь харилцан ярилцаж, зөвшилцөж байх; 4/.мөн нотариатын үүрэг гүйцэтгэгч нараас ирүүлсэн Итгэмжлэлд дээрхийн адил шаардлага тавьж, шаардлага хангасан Итгэмжлэлийг үндэслэн бүртгэлээ хөтлөх; 5/. итгэмжлэл гэрчилсэн нотариатын хувийн дугаар, тэмдэг, нэр, гарын үсгийг

[notary.mn](http://notary.mn) цахим хаягаар орж давхар шалгах, нягтлах зэрэг анхаарвал зохих зөвлөмжийг өгсөн байна.

6.1.7. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Бүртгэлийн цахим программд ажиллах чадварыг нэмэгдүүлэх, хууль хэрэглэх чадварыг сайжруулахад чиглэгдсэн Сургалтын хөтөлбөрын дагуу Иргэний улсын бүртгэгч нарт хийж хэрэгжүүлсэн ажлыг тайлагнахтай холбоотой албан бичиг боловсруулах арга зүйн практик сургалт (Тайлан, илтгэх хуудас, мэдээ, мэдээлэл бичих), Бүртгэлийн мэдээ гаргалтын байдал, анхаарах асуудал /практик сургалт/, Цахим системээс лавлагаа гаргах, анхаарах асуудал (практик сургалт), И-монгол-оор ирсэн хүсэлтийг шийдвэрлэхэд анхаарах асуудал (практик сургалт), Шилжилт хөдөлгөөний бүртгэлтэй холбогдуулан эд хөрөнгийн мэдээллийг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим системд шалгах зааварчилгаа (практик сургалт) зэрэг сэдэвт сургалтыг орлоо.

6.1.8. Сонгуулийн жилтэй холбогдуулан улсын бүртгэгч нарыг сонгуулийн хууль тогтоомжийн мэдлэгийг дээшлүүлэх, сонгуулийн хуулийг хэрэглэх хэрэглээний чадварыг сайжруулах, улмаар улсын бүртгэгч нараар дамжуулан сонгуулийн хууль тогтоомжийг сурталчлан таниулах зорилго бүхий “Сургагч багш” бэлтгэх сургалтыг зохион байгуулж, 21 улсын бүртгэгчид “Сургагч багш” сертификат олгов.

## **6.2. Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн талаар:**

Тайлант хугацаанд иргэний улсын бүртгэлийн мэдээллийг зөв болгуулах, цахим санд ороогүй мэдээллийг нөхөн оруулуулах, алдаатай бүртгэлийг засуулах гэх мэт иргэний улсын бүртгэлтэй холбоотой 356 өргөдөл хүлээн авч, хуулийн хугацаанд нь багтаан шийдвэрлэсэн 322, шийдвэрлэхээр судлагдаж байгаа 34 өргөдөл байна.

## **6.3. Хууль тогтоомжийн болон бусад асуудлаар холбогдох санал өгсөн талаар:**

Тайлант хугацаанд хууль тогтоомж болон бодлогын баримт, мөн программ хөгжүүлэлт зэрэгт олон удаа саналаа хүргүүлсэн байна. Үүнд:

1. 2024 оны 05 дугаар сарын 24-нд Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3. Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл болон 13 дугаар зүйлийн 13.1. Нас барсны бүртгэл, энэ 2 төрлийн бүртгэлийг бүртгэх хуулийн хугацааг өөрчлөх; харин “Улсын бүртгэлийн байгууллагаас монгол улсын 16 насанд

хүрсэн иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журам”-д Тоон гарын үсгийг өмнө нь олгосон бол таньд тоон гарын үсэг олгосон байна гэсэн “мэдэгдэл” мессэжээр очдог, аль эсвэл автомаар хариулдаг, тоон гарын үсгийн PIN болон PUK кодыг сэргээх үйлчилгээ үзүүлэх байнгын оператор ажиллуулахтай холоотой харилцааг журамд нэмэлтээр оруулах; Иргэний улсын бүртгэлийг цахим санд хөтлөхтэй холбоотой бүртгэлийн программд сайжруулалт, хөгжүүлэлт хийхтэй холбоотойгоор программд “Иргэний үнэмлэхний олголтын бүртгэлд **“Итгэмжлэл”** гэсэн сонголтыг нэмэх; шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хурууны хээгээр бүртгэхэд эхийн шилжилт хөдөлгөөний бүртгэлд хүүхдийн мэдээлэл программаас шууд бууж ирдэггүй, заавал гараар бичиж оруулдаг болсон тул автоматаар бууж ирдэг болгож өөрчлөх; “тоон гарын үсэг” ашиглалтыг бүртгэлд /хэрэглээнд/ нэвтрүүлэх зэрэг саналуудыг хүргүүлсэн байна.

2. 2024 оны 08 дугаар сарын 30-нд Иргэний улсын бүртгэл хөтлөхтэй холбоотой хүчин төгөлдөр даган мөрдөж байгаа журмуудад нэмэлт өөрчлөлт оруулах 1 санал, Иргэний улсын бүртгэлийг цахим санд хөтлөхтэй холбоотой бүртгэлийн программд сайжруулалт, хөгжүүлэлт хийхтэй холбоотой 4 санал, бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх бүртгэлийн маягтад 1 санал, нийт 6 саналыг хүргүүлсэн байна.

3. 2024 оны 09 дүгээр сарын 17-нд улсын бүртгэлийн байгууллагын 2024 оны үйл ажиллагааны Эрсдэлийн төлөвлөгөөнд Эрсдэлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээг эрчимжүүлэн ажиллахад үүсэж буй саад, бэрхшээлд 1 санал, шинээр үүссэн эрсдэлд 4 санал, нийт 5 саналыг хүргүүлэв.

4. Улсын бүртгэлийн хууль тогтоомжид үнэлгээ хийж, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгахад чиглэсэн арга хэмжээний хүрээнд улсын бүртгэлийн хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотойгоор 1).Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах 2 санал; 2). Бусад хуулиудтай зөрчилдөж байгаа хуулийн заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах хүчингүй болгохтой холбоотой 10 санал; 3).Улсын бүртгэл хөтлөхтэй холбоотой хүчин төгөлдөр даган мөрдөж байгаа журмуудад нэмэлт өөрчлөлт оруулах 2 санал; 4).хуулиас давсан зохицуулалтыг хасах, эсвэл өөрлөн найруулахтай холбоотой 2 санал, нийт 16 саналыг 2024 оны 10 дугаар сарын 30-нд хүргүүлсэн байна.

5. Ерөнхий газрын Тамгын газраас Өргөдөл, гомдол, санал, мэдэгдлийг хүлээн авах, шийдвэрлэх, хяналт тавих, тайлан гаргах зааварт санал авсан ба уг заавартай танилцан Өргөдөл, гомдол, санал, мэдэгдлийг хүлээн авах, бүртгэл

хөтлөхтэй холбоотойгоор 1 санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хариу өгөхтэй холбоотой 2 санал, нийт 3 саналыг 2024 оны 11 дүгээр сарын 07-нд хүргүүлэв.

6.Төрийн албаны зөвлөлөөс авсан Төрийн албаны үйлчилгээний стандартын төсөлд 9 санал өгч, аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн байна.

## **ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, ХАМТЫН АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД**

Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2024 оныг хуулийн хэрэгжилтийг хангаж, хамтын ажиллагааг сайжруулах жил болгон зарласантай холбогдуулан хэлтэс, тасгийн зүгээс ажил уялдаа холбоотой ажилладаг байгууллагуудтайгаа харилцаагаа сайжруулж, хуулийг нэг мөр ойлгож, адил ойлголттой байж иргэдийг чирэгдүүлэхгүй байх, мөн хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр олон байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажиллалаа. Тодруулбал,

1. Аймгийн Төрийн цахим үйлчилгээний хэлтэс, Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран төрийн цахим үйлчилгээг сурталчлан таниулах, Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, цахим үйлчилгээг авах хэрэглэгчийн цахим ур чадварыг сайжруулах, Цахим гарын үсгийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль зэрэг цахим шилжилтэй холбоотойгоор гарсан хуулиудыг болон төрийн цахим шилжилтийн явц, цаашдын зорилтын талаар сурталчлан таниулах ажлыг хийлээ. Тус ажлын хүрээнд төрийн байгууллагууд, сургууль, төрийн өмчит болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудад сургалт орж, тоон гарын үсгийг болон төрийн цахим үйлчилгээний нэгдсэн платформ системээс төрийн үйлчилгээ хэрхэн авах талаар арга зүйн сургалт, зөвлөгөө зааварчилгааг өглөө. Мөн тоон гарын үсэг болон төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг хүрээнд “Цахим хөтөч-цахим ур чадварын сургагч багш” нарыг бэлтгэж, тэд нараар дамжуулан нөлөөллийн олон талт арга хэмжээг зохион байгуулж байна.

2. Иргэний улсын бүртгэлийн тасгаас хуулий хүрээнд харилцан хамааралтай, холбоотой ажилладаг байгууллага, мэргэжилтнүүдтэй харилцан ойлголцож, хамтран ажиллах чиглэлээр “Өглөөний цай” зөвлөлдөх уулзалтыг Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхамын санаачлагаар эхлүүлсэн ба анхны “Өглөөний цай” зөвлөлдөх уулзалтыг Баянхонгор аймгийн Нотариатын танхимын нотариатуудтай 2024 оны 04 дүгээр сарын 08-ны

өглөөний 08:00 цагт нотариатын өрөөнд хийсэн. Тус уулзалтаар цаг үеийн чухал сэдэв болох Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл, Сонгогч шилжилтийн бүртгэлтэй холбогдуулан итгэмжлэлээр төлөөлөн оролцох харилцаанд талуудын анхаарах асуудал, гарч болох эрсдлийг тооцон харилцан зөвлөлдөх, хуулийн хүрээнд, иргэдэд чирэгдэлгүй үйлчлэх, улсын бүртгэл болоод нотариатын үйлдэл үнэн зөв, шударга байх зарчмыг ханган ажиллах, аливаа асуудалд талууд ижил байр суурьтай байх зэрэг тодорхой асуудлууд дээр нэг мөр ойлголтод хүрч, уулзалт амжилттай болсон.

3. Дараагийн “Өглөөний цай” зөвлөлдөх уулзалт /2 дахь уулзалт/-ыг Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхам, улсын бүртгэгч Г.Бадамханд нар 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн өглөөний 08.00 цагт Баянхонгор сумын Засаг даргын орлогч Д.Ууганцэцэг даргын албан өрөөнд Баянхонгор сумын төвийн 8 багийн Засаг дарга нартай хийлээ. Уг уулзалтаар цаг үеийн чухал сэдэв болох Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл 4 дүгээр сарын 29-нд зогсохтой холбоотой багийн түр оршин суугч нарын шилжилт хөдөлгөөний бүртгэлээ хийлгүүлэх ажлыг ухуулан сурталчлах, Сонгогчдын нэрийн жагсаалт Улсын бүртгэлийн байгууллагын цахим сайтад нээлттэй байршуулсантай холбоотой Сонгогч өөрийн болон гэр бүлийн гишүүдийн мэдээлэлтэйгээ танилцах ажлыг багийн төвүүд дээрээ зохион байгуулж, хамтран ажиллах талаар ярилцахын зэрэгцээ Сонгуулийн хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу Улсын бүртгэлийн байгууллагын хийж хэрэгжүүлж байгаа ажлын талаар товч танилцууллаа.

Багийн Засаг дарга нар багийн хилийн цэс өөрчлөгдсөнтэй холбоотой хаяг, түр оршин суугчийн иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл зэрэг асуудлаар харилцан мэдээлэл солилцож, цаашдаа энэ чиглэлээр хуулийн хүрээнд хамтран ажиллахаар болов.

4. Сонгуулийн жилтэй холбогдуулан сонгуулийн хуулийн хэрэгжилтийг хангах, сонгогчийг мэдээллээр хангах чиглэлээр Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл 4 дүгээр сарын 29-нд зогсохтой холбоотой багийн түр оршин суугч нарын шилжилт хөдөлгөөний бүртгэлээ хийлгүүлэх ажлыг ухуулан сурталчлах, Сонгогчдын нэрийн жагсаалт /цахим хэлбэр/ Улсын бүртгэлийн байгууллагын цахим сайтад нээлттэй байршуулсантай холбоотой Сонгогч өөрийн болон гэр бүлийн гишүүдийн мэдээлэлтэйгээ танилцах ажлыг өөрийн байгууллага дээрээ шуурхай зохион байгуулж, сонгогчийн мэдээлэлтэй холбоотой гомдлыг шийдвэрлэх ажилд хамтын ажиллагааны дэмжлэг үзүүлж ажиллахтай холбоотой чиглэл, зөвлөмжийг аймгийн Засаг даргын ажлын албаны болон газар, хэлтэс болон харъяа

агентлагуудад, орон нутгийн өмчит компани, сургууль, цэцэрлэг зэрэг 60 гаруй байгууллагууд, мөн сумдын Засаг дарга, Тамгын газрын дарга нарт хүргүүлж ажилласнаар Улсын Их Хурлын сонгогчдын нэрийн жагсаалттай 1700 гаруй сонгогч мэдээлэлтэйгээ танилцаж, 200 гаруй сонгогчийн гомдлыг шийдвэрлэсэн байна.

5. Насанд хүрээгүй буюу 14-18 насны иргэд иргэний улсын бүртгэлийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчлөлтийн бүртгэл хийлгүүлэхтэй холбоотойгоор Цагдаагийн байгууллагаас ял шийтгэлгүй лавлагаа авч чадахгүйгээс шалтгаалан бүртгэлээ хийлгүүлж чадахгүй нөхцөл байдал үүссэнтэй холбоотойгоор аймгийн Цагдаагийн газрын дэд даргатай холбогдон лавлагаа мэдээлэл хариуцсан албан хаагчтэй “Өглөөний цай “уулзалтыг хийж, асуудлыг шийдвэрлэсэн. Өөрөөр хэлбэл, сумдын хэсгийн төлөөлөгчөөр дамжуулан эцэг эхийн өргөдөл, хүсэлтээр холбогдох лавлагааг гаргаж өгөхөөр тохиролцож, сумын улсын бүртгэгч нарт болон суманд ажиллаж байгаа цагдаагийн хэсгийн төлөөлөгч нарт мэдээллийг дамжуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

6. Хуулийн хэрэгжилт, хамтын ажиллагааг дэмжих зорилтод арга хэмжээний хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс, “Хөгжлийн шийдэл-BEST” хөтөлбөрийн Баянхонгор аймаг дахь салбартай хамтран Монгол Улсын Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого”-ын баримт бичгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдаж байгаа "Шинэ хоршоо хөдөлгөөн", "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээг хэрэгжүүлэхэд малчдад тулгамдаад байгаа нэн тэргүүний асуудал болох хоршоог хэрхэн байгуулах, хоршоог байгуулахад болон хоршоог улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбоотой баримт бичгийг боловсруулахад чухалчлан анхаарах зүйл, шинээр байгуулсан болон хуулийн этгээдийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулсан бол цахим **E-Mongolia 8 E-business.mn** цахим платформ ашиглан хэрхэн бүртгүүлэх, **Тоон гарын үсэг, цахим гарын үсгийг** хэрхэн ашиглах хэрэглэх гэх зэрэг олон асуудлын шийдлийг олгох болон цахим ур чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх зорилго бүхий хамтын сургалтыг 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр зохион байгууллаа. Тус сургалтанд хөдөө аж ахуйн чиглэлийн үйл ажиллагаа эрхлэдэг, эрхлэхээр төлөвлөж шинээр үүссэн байгуулагдаж буй 16 хоршоо, тэдгээрийн дарга, тэргүүлэгч гишүүд, нийт 39 хүн хамрагдав. Сургалтанд оролцсон хоршооны дарга, тэргүүлэгчид маш хэрэгтэй чухал мэдлэг мэдээллийг авахын зэрэгцээ төрийн цахим үйлчилгээний өнөөгийн хөгжил үнэхээр хурдацтай хөгжиж, хүртээмж нэмэгдсэн байна, бид хоршоогоо хөгжүүлэхийн тулд хамгийн түрүүнд хоршооны гишүүдээ мэдлэг, мэдээлэлтэй болгож, чадавхжуулах, мөн

төрийн үйлчилгээг цахимаар авах чадвартай болох нь ихээхэн чухал байна гэж сургалтыг дүгнэж сэтгэгдлээ илэрхийлсэн нь төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны сургалтын үр дүнг үнэлсэн үнэлгээ байв.

7. Байдраг ахлах сургуулийн 1994-2004 оны төгсөгчдийн 20 жилийн ойг угтан Төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх, Улсын бүртгэлийн бүх үйлчилгээ, Эрүүл мэндийн үзлэг оношилгооны нарийн мэргэжлийн эмч нар, Цагдаагийн байгууллага Хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт мэдээлэл өгч Хуулийн зөвөлгөөг нэг цэгээс хүргэх ажлын хүрээнд **НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ**-ийг 2024 оны 03 дугаар сарын 09-нөөс 03 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус арга хэмжээг улсын бүртгэгч Т.Алтаншагай санаачлан, удирдан зохион байгуулж явуулсан ба иргэний улсын бүртгэлийн үйлчилгээний төрлөөс төрсний бүртгэл 1, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 3, лавлагаа 3, гадаад паспорт 49 нийт 57 бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна. Мөн хэлстээс томилогдсон ажлын багт улсын бүртгэгч З.Дуламсүрэн хамтран ажиллав.

8. Аймгийн Засаг даргын Тамгын газраас сумдын Хууль эрх зүй, дотоод асуудал хариуцсан ажилтнууд, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд, Насан туршийн суралцахын төв, сургуулиудын эрх зүйн хөтөч нарын мэдлэгийг дээшлүүлж чадавхжуулах танхимын ээлжилт сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 26,27-ны өдрүүдэд зохион байгууллаа. Уг сургалтанд хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхам "Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хууль"-ийн үзэл баримтлал, хуульд орсон шинэ нэр томъёо, шинэлэг зохицуулалт, мөн тус хуулиар зохицуулсан харилцаа бусад хуультай, нэн ялангуяа Улсын бүртгэлийн багц хууль тогтоомжтой хэрхэн холбогдож байгаа талаар сургалт орж, эрх зүйн хөтөч нарын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, чадавхжуулахад хамтран ажиллалаа.

9. ХААН банктай хамтран Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, тоон гарын үсэгтэй холбоотой гарч буй бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх, иргэдэд өгөх зөвлөгөө зааварт хоёр байгууллага нэг ойлголтой байх талаар ХААН банкны ажилтан албан хаагч нарт сургалт орж, харилцан санал солилцлоо.

10. Сонгуулийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, хамтын ажиллагааг сайжруулах зорилтын хүрээнд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн ажлын хүрээнд аймгийн Сонгуулийн хорооноос сумын сонгуулийн хорооны дарга, нарийн бичиг, ня-бо нарт зориулсан хууль, эрх зүйн сургалтанд Улсын бүртгэлийн хэлтсээс Иргэний улсын



бүртгэлийн тасгийн дарга П.Бүжинлхам оролцож, сумын сонгуулийн хорооны дарга, хэсгийн хорооны дарга, даамал болон улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан нарын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулж хамтран ажиллах чиглэлээр холбогдох мэдээллийг өглөө.

11. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Сонгогчдын нэрийн жагсаалт хүргэгдсэн өдрөөс эхлэн хэсгийн хороо сонгогчийн өөрт нь холбоотой мэдээлэлтэй танилцах боломжоор хангах, итгэмжлэгдсэн ажилтан болон улсын бүртгэлийн байгууллага сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотойгоор гарсан гомдлыг шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна. Үүнтэй холбогдуулан Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс "Хуулиар хүлээсэн хамтын чиг үүргийн хүрээнд хамтын ажиллагааг сайжруулж, сонгогчийн сонгох, сонгогдох эрхийг ханган ажиллах" сэдэвт цахим сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулав. Сургалтанд Баянхонгор аймгийн 106 хэсгийн сонгуулийн хэсгийн хорооны дарга нар болон итгэмжлэгдсэн ажилтнууд оролцлоо.

12. Жаргалант сумын улсын бүртгэгч Т.Алтаншагай Монгол бахархлын өдрийг угтан залуу хойч үеийнхэнд төрт ёс, түүх соёлоо эрхэмлэн дээдэлсэн, үүрэг хариуцлагаа ухамсарласан, эх оронч үзэл төлөвшүүлэх зорилготойгоор жил бүр зохион байгуулдаг Монгол Улсын "Иргэний андгай өргөх ёслол"-ын үйл ажиллагааг сумын ЗДТГ-тай хамтран зохион байгуулж, 15 сурагчийг иргэний андгай өргөлүүлээ. Харин Монгол Улсын Тусгаар тогтнолын өдөр буюу 11 дүгээр сарын 26-ны өдөр "Иргэний андгай өргөх ёслол"-ыг аймгийн ЗДТГ-ын Хүүхэд залуучуудын хөгжлийн төвтэй хамтран зохион байгуулахаар төлөвлөсөн болно.

### **ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТООН МЭДЭЭ:**


Монгол Улсын Иргэний хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль болон улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой хууль, дүрэм, журмыг бүртгэлийн өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллалаа.

**Тайлант хугацаанд буюу 2023 оны 11 дүгээр сарын 27-оос 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийг хүртэлх хугацаанд хийгдсэн нийт иргэний улсын бүртгэлийг эрх үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болох төрлөөр нь ангилан графикаар харуулбал:**

**эрх үүсэх, дуусгавар болох бүртгэл**






**Эрх үүсэх, дуусгавар болох бүртгэл  
2023-2024 он**



**■ өөрчлөлтийн бүртгэл**







## 2.2. ХУУЛИЙН ЭТГЭЭД, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

### НЭГ.ЕРӨНХИЙ ГАЗРААС БОЛОН УДИРДЛАГААС ӨГСӨН ЧИГЛЭЛ, ЗӨВЛӨМЖ, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ТАЛААР:

**Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 1/2559 тоот албан бичгийн биелэлт:**

УБЕГ-ын даргын 2023 оны 1/2559 дугаарт албан бичгээр ирүүлсэн чиглэлтэй танилцаад улсын ахлах бүртгэгч Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан эрхийн улсын бүртгэлийн тусгай тэмдэглэл, мөн тус хуулийн 31 дүгээр зүйлд заасан урьдчилсан тэмдэглэлийн бүртгэлийг бүртгэхдээ хуулийг зөв ойлгож хэрэглэх талаар арга зүйн зөвлөгөө өгч, хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн тусгай тэмдэглэл хийх албан бичиг, холбогдох, эрх зүйн актуудыг дор бүр нь хугацаа алдалгүй бүртгэж, цахимжуулан ажиллах талаар тогтмол үүрэг даалгавар өгөн хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд тусгай тэмдэглэлийн бүртгэлийг тухай бүрд нь хөтөлсөн байна.

Харин МИК активаас 11 сарын 14-ний өдрийн байдлаар онлайн-аар ирүүлсэн Тусгай тэмдэглэл сэргээх буюу барьцаат зээлийн гэрээ дуусгавар болгосон тухай **100** хүсэлтээс **6** татгалзаж, **94** хүсэлтийг шийдвэрлэсэн байна.

**Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/1614 тушаал, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 5/7833 тоот албан бичгүүдийн биелэлт:**

Тус тушаал, болон чиглэлийн биелэлтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт **56** хувийн хэрэг хааж бүртгэсэн. Үүнээс үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд **23**, газар өмчлөх эрхийн бүртгэлд **33** бүртгэл хааж бүртгэсэн байна.

Холбогдох тайлан мэдээг хугацаанд нь тасгийн даргаар хянуулан сарын мэдээтэй нэгтгэн [e.suvderdene@burtgel.gov.mn](mailto:e.suvderdene@burtgel.gov.mn) хаягаар хүргүүлсэн.

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 5/9854 тоот албан бичгийн биелэлт:**

УБЕГ-ын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар болон 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газраас өгсөн зөвлөмжийн дагуу 2024 онд заасан хугацаанд нь үнэн зөв гаргаж **11** удаа хүргүүлэн ажиллаад байна.

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 5/9855, 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 5/10279, 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 2/2820 тоот албан бичгүүдийн биелэлт :**

Баянхонгор аймгийн хэмжээнд Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн, шинээр баригдсан нийтийн орон сууц, авто зогсоол, үйлчилгээ, бусад зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийг захиалагч, хөрөнгө оруулагч, худалдан авагчийн нэрсийн жагсаалт /цаашид жагсаалт гэх/, түүнд хавсарган ирүүлсэн холбогдох нотлох баримтуудыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн систем /ePRS/-ийн “Бүртгэл” цэсний “Шинээр баригдаж буй орон сууцнууд” цонхонд нийт **7** материалыг нэмж цахимжуулсан байна

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 5/10482 тоот албан бичгийн биелэлт:**

Тус чиглэлийн дагуу 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс өмнө улсын бүртгэлд “Г” дугаарт бүртгэгдэн дундын мэдээллийн санд газар эзэмших эрхийн “Э” дугаар давхардуулж авсан 355 мэдүүлэг нотлох баримтыг шалган эрх бүхий иргэн, хуулийн этгээдтэй холбогдон эрхийн улсын бүртгэлийг хаах тухай **26** мэдүүлэг нотлох баримтыг хүлээн авч бүртгэл хаасан байна.

**Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн улсын бүртгэлийн газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 5/281 тоот албан бичиг:**

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх хэсэгт “газрын эрх үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалах тохиолдолд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн барьцааны гэрээ, эсхүл барьцаалбарт тусгагдсан тухайн эд хөрөнгийн барьцааны үнэ” гэж эрхийн улсын бүртгэлд тусгах үл хөдлөх эд хөрөнгийн үнийг тодорхойлж өгсөн байна. Иймд ЭУБ-06 маягтыг үйлдэхдээ барьцаа хөрөнгийн мэдээлэл хэсгийн бусад гэсэн талбарт барьцааны зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийн үнийг дурдан ирүүлж байхыг мэдэгдэх зорилгоор орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Нотариат, банк, банк бус санхүүгийн байгууллагатай хамтарсан уулзалт зөвлөгөөнийг 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр Улсын бүртгэлийн хэлтсийн сургалтын зааланд зохион байгуулж ажилласан.

Мөн газраас 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 5/12510 дугаартай албан бичгээр хүргүүлсэн чиглэлд бүхэлдээ барьцааны эрх бүртгэлтэй байгаа үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг захиалагч, хөрөнгө оруулагч, худалдан авагчдын өмчлөлд хэсэгчлэн салгаж бүртгэхэд эрх ашиг нь хөндөгдөж болох этгээдэд бичгээр мэдэгдэх талаар дурьдсан.

Жагсаалтаар салж бүртгэгдэж байгаа үл хөдлөх эд хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөх бүртгэл 11 сарын 14 –ний өдрийн байдлаар **88** бүртгэгдсэн байна. Эдгээр бүртгэлүүд дээр холбогдох банк нь бүртгэл хийлгэхдээ өөрсдөө зөвшөөрч, өмчлөх эрхийн гэрчилгээний хэмжээ хасагдах тухай хүсэлтээ хамт хавсарган ирүүлж байна.

**Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 1/655 тоот , Эд хөрөнгийн улсын бүртгэлийн газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 5/2170, 2024 оны 04 дүгээр сарн 12-ны өдрийн 4/4802 тоот албан бичиг**

Улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаа, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэнд болон иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг шийдвэрлэхтэй холбоотой хийсэн хяналт шалгалтаар хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд зөрчлүүд гарч байгаатай холбогдуулан ирүүлсэн үүрэг, чиглэлийн биелэлтийг ханган ажиллаж байна. Хуулийн этгээд, эд хөрөнгийн улсын бүртгэгч нарт дотоод хурал зохион байгуулан анхааруулан ажиллаж байна.

Жаргалант сумын улсын бүртгэгчийн бүртгэсэн 2023 оны 06 дугаар сараас 2024 оны 05 дугаар сар хүртэлх 394 бүртгэлийг цахим санд шалгаад, зөрчил арилгасан талаарх илтгэх хуудсыг хүлээн авсан.

Эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой иргэн Г.Сосорбарам, С.Цэцгээгийн өргөдөл, гомдлыг нягтлан шалгаж, маргаж буй хөрөнгө байрлах Эрдэнэцогт сумын төвд газар дээр нь очиж судлан, холбогдох хариуг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

Мөн хэлтсийн хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгчдийн өдөр тутмын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, чиглүүлэн ажиллаж байна.

**Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын хяналтын улсын ахлах байцаагчийн 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 04 тоот албан шаардлагын талаар:**

Албан шаардлагад улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхамтай холбоотой 9 бүртгэлийн зөрчлийн мэдээлэл ирсэн ба холбогдох гарын үсэг дутуу, нотлох баримт зөрүүтэй, хууль журам зөрчиж хийсэн бүртгэлүүдийн зөрчлийг бүрэн арилгасан.

Тус зөрчлийг арилгасан тухай холбогдох хүсэлтийг хэлтсийн хяналтын улсын байцаагчид уламжлан 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 766 тоот дүгнэлт гаргуулан цахим санд засвар өөрчлөлт оруулсан.

Засвар өөрчлөлт оруулсан мэдээг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт хүргүүлэн ажилласан.

Харин эрхийн улсын бүртгэлийн Ү-0307000014 дугаарт бүртгэгдсэн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлээс хэмжээ өөрчлөлт хийж, хасалгүйгээр буруу бүртгэл бүртгэсэн П.Бүжинлхам /Ү-0307000104/, С.Баярмаа /Ү-0307000045/ нарын давхардуулан бүртгэсэн бүртгэлийг илрүүлэн, холбогдох өмч хувьчлалын нотлох баримтыг аймгийн Төрийн Архивын тасгаас гаргуулан авч нягтлан шалгаж байна.

**Улсын бүртгэлийн ерөнхий газар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын даргын “Чиглэл хүргүүлэх тухай” 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 4/1399 дугаар албан бичгийн биелэлт:**

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8-д зааснаар улсын бүртгэлийн байгууллага тамга, тэмдгийн хяналтын дугаар олгох, хүчингүй болгох, лавлагаа олгох чиг үүрэгтэй ба Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас

хийлгэх, хэрэглэх журам”, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А\216 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тамга, тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам”-ыг тус тус бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж улсын бүртгэгч хураалгасан тамга, тэмдгийг улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан маягтад бүртгэж, хадгалалт, хамгаалалтын шаардлага хангасан сейф, шүүгээнд хадгалан, хураалгаж хүчингүй болсон тамга, тэмдгийг устгах ажлыг хагас жил тутамд хэлтсийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг зохион байгуулж тамга, тэмдгийг устгасан тухай ажлын тайлан болон бусад нотлох баримтыг архивын хадгаламжийн нэгж болгон үдэж хэлтсийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивт хүлээлгэн өгч хэвшсэн.

**Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын даргын 2024 оны 01 сарын 23-ны өдрийн 4/957 тоот албан бичиг:**

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 онд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр албан хаагчдыг дадлагажуулах сургалтын төлөвлөгөөнд 3 санал хүргүүлсэн. Үүнд:

- 1.Хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх, программын сургалт,
- 2.Хуулийн этгээдийн бүртгэл тус бүрээр анхаарах асуудал,
3. Хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх дадлага хийх тухай

**Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 4/1609 тоот албан бичиг:**

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2023 оны 07 сарын 07-ны өдөр батлагдсантай холбогдуулан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт “Улс төрийн намыг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг намын бүртгэлд бүртгэх, иргэн, хуулийн этгээд, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд лавлагаа олгох, намын бүртгэл хөтлөхтэй холбогдсон харилцааг Улс төрийн намын хуулиар зохицуулна.” гэж нэмсэн бөгөөд уг зохицуулалтыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхтэй холбоотой ирүүлсэн зөвлөмжид дурьдагдсан 4 төрлийн заалтыг уншиж танилцан хууль хэрэгжиж эхэлснээс хойш улс төрийн намын нэр шинээр баталгаажуулах, нэрийн баталгаажуулалтын хугацаа сунгах зэрэг зөрчлүүдийг гаргахгүй байхад анхаарч, нийт улсын бүртгэгч нарт албан бичгийг танилцуулсан.



**Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн  
улсын бүртгэлийн газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 20-ны  
өдрийн 4/2151 тоот албан бичиг:**

Чиглэлд дурьдсаны дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэл хөтлөхдөө мэдээлэл зөрүүтэй бүртгэхгүй байх, алдаагүй, зөрчилгүй бүртгэл хөтлөх талаар анхааруулан ажиллаж байна. Тайлант хугацаанд хуулийн этгээдийн **2359** бүртгэл хийсэн ба бүгд бүрэн цахимжсан.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэл хөтлөхдөө УБ-03, УБ-12 маягтыг үнэн зөв, бүрэн гүйцэт бөглөсөн эсэхийг сайтар шалган хүлээн авч хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, хувьцаа эзэмшигчийн тоо, эрх бүхий этгээд, гүйцэтгэх удирдлага зэрэгт өөрчлөлт орж байгаа тохиолдолд өмнөх бүртгэлтэй байсан мэдээллийг идэвхгүй төлөвт оруулж дахин шинээр бүртгэх мөн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан ажлын 15 хоногт бүртгүүлээгүй хугацаа хэтэрсэн тохиолдолд хяналтын улсын байцаагчид танилцуулж, шийдвэрлэсний дараа бүртгэж тухай бүр бүртгэлийн нотлох баримтыг цахимжуулан ажиллаж байна.

Хуулийн этгээдийн нэр, хэлбэр олгохдоо УБЕГ-ын даргын 2021 онд батлагдсан А/55 дугаар тушаалыг чанд мөрдөн үнэн зөв алдаагүй бүртгэж байна.

Хуулийн этгээдийн мэдээллийн санд засвар өөрчлөлт хийлгэхдээ албан хэрэг хөтлөлтийн E-Doc систем болон хуулийн этгээдийн бүртгэлийн программын “Мэдээ, мэдээлэл” системд байршуулан хариуцсан улсын бүртгэгч нартай холбогдож мэдээллийн санд нийт **11** төрлийн бүртгэлд засвар өөрчлөлтийг хийлгэж дээрх чиглэлийг мөрдөн ажиллаж байна.

**Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын  
бүртгэлийн газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 20-ны  
өдрийн 4/2084 дугаар албан бичиг:**

“Улсын бүртгэлийн байгууллагад Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны дэмжлэгтэй хэрэгжүүлэх төслийн хүрээнд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн системийг шинэчлэх ажил хийгдэх тул шинэ системд тусгах саналаа 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн дотор ирүүлнэ үү” гэх албан бичгийн дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлийн системд тусгах шаардлагатай **5** төрлийн саналыг нэгтгэн заасан хугацаанд нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт

хүргүүлсэн. Жишээлбэл: Хуулийн этгээдийн нэр хайх системийг боловсронгуй болгох гэх мэт.

**Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын даргын “Чиглэл хүргүүлэх тухай” 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 4/3519 дугаар албан бичгийн биелэлтийн талаар:**

Монгол Улсын Их Хурлаас “мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай” хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэн ажиллах талаар нийт улсын бүртгэгч нар албан бичгийг танилцуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

**Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн улсын бүртгэлийн газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн 4/5784 тоот албан бичгийн талаар:**

Чиглэлийн дагуу Хот хөдөөгийн сэргэлтийн хүрээнд Монгол улсын Засгийн газраас баталсан “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх , “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 4 дүгээр сарын 1-нээс 11 дүгээр сарын 14-ний өдрийн хооронд **255** шинэ хоршоо бүртгэсэн байна. Харин өөрчлөлт оруулсан **83** хоршооны бүртгэлийн хөтлөгдсөн байна.

Нийт **709** нэр олгосоноос E-BUSINESS –цахим системээр хоршоонд **468** нэр баталгаажуулсан ба биечлэн танхимаар **241** нэр олгосон байна.

Сумын бүртгэгчдийг хэлтсийн хуулийн этгээдийн улсын бүртгэгч, болон ахлах бүртгэгч нь мэдээ мэдээллээр тогтмол ханган заавар зөвлөгөө өгөн ажиллаж байна.

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн 5/2717 тоот албан бичгийн биелэлтийн талаар:**

Голомт банк, “Монголын ипотекийн корпораци” ХХК-иас барьцаат зээлийн гэрээ бүртгүүлэх, барьцааны гэрээ дуусгавар болгох үйлчилгээг дундын мэдээллийн сангаар дамжуулан /ePRS/ системд “Онлайн мэдүүлэг” цэсэнд цахимаар илгээн бүртгэхтэй холбоотой **96** бүртгэлийг бүртгэн баталгаажуулсан байна.

**Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн Б/297 тоот албан бичгийн талаар:**

Сумын улсын бүртгэгч нарт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх олгох тухай тушаалын дагуу Баянхонгор аймгийн 6 сумын бүртгэгчид эд хөрөнгийн бүртгэлийн эрх нээгдсэн ба нийт 8 сум эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр иргэдэд мэдээлэл өгч ажиллаж байна.

Эрх зүйч мэргэжлээр төгссөн тус бүртгэгч нарт 2024 оны 04 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр танхимаар сургалт зохион байгуулж, өдөр тутамдаа зааварчилгаа өгч ажиллаж байна.

**Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналтын улсын байцаагчийн 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1500 дугаар дүгнэлтийн талаар:**

Тайлант хугацаанд Хяналтын улсын байцаагч Л.Мэндбаярын 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 1567 дүгнэлт, мөн 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 766 тоот дүгнэлт, УБЕГ-ын ХУАБ-ийн 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1500 дүгнэлтээр хувийн хэргийн цахимжуулалтад болон цаасан нотлох баримтад нийт 41 хувийн хэрэгт засвар өөрчлөлт оруулж, гарсан алдаа зөрчлийг арилгасан болно.

Засвар өөрчлөлтийн тайлан мэдээг сар бүр [e.suvderdene@burtgel.gov.mn](mailto:e.suvderdene@burtgel.gov.mn) хаягаар хугацаанд нь хүргүүлсэн.

Мөн сар бүр 11 удаа батлагдан ирсэн маягтын дагуу засвар өөрчлөлт оруулсан бүртгэлийн мэдээг [e.suvderdene@burtgel.gov.mn](mailto:e.suvderdene@burtgel.gov.mn), [edkhourungu@burtgel.gov.mn](mailto:edkhourungu@burtgel.gov.mn) хаягуудад хугацаанд нь хүргүүлсэн.

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 5/2366, 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 5/4803 тоот албан бичгүүдийн биелэлтийн талаар:**

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх хэсэгт “газрын эрх үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалах тохиолдолд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн барьцааны гэрээ, эсхүл барьцаалбарт тусгагдсан тухайн эд хөрөнгийн барьцааны үнэ” гэж эрхийн улсын бүртгэлд тусгах үл хөдлөх эд хөрөнгийн үнийг тодорхойлж өгсөн байна. Иймд ЭУБ-06 маягийг үйлдэхдээ барьцаа хөрөнгийн мэдээлэл хэсгийн бусад гэсэн талбарт барьцааны зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийн үнийг дурьдан ирүүлж байхыг мэдэгдэх зорилгоор орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Нотариат, банк, банк бус санхүүгийн байгууллагатай хамтарсан уулзалт зөвлөгөөнийг 2024 оны 03 дугаар

сарын 12-ны өдөр Улсын бүртгэлийн хэлтсийн сургалтын зааланд зохион байгуулж ажилласан. Мөн өдөр тутамдаа бүртгэлийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллахаас гадна зөрчилтэй ирүүлсэн холбогдох гэрээг цаг тухай бүрт нь банк болон банк бус санхүүгийн байгууллагад буцаан зөрчлийг арилгуулан бүртгэж ажиллаж байна.

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын  
2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 5/3783 тоот албан бичгийн  
биелэлтийн талаар:**

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.06-д “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 14.4-т заасан тусгай тэмдэглэл хийлгэх хүсэлт гаргасан” бол тусгай тэмдэглэл хийнэ гэж заасны дагуу эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэлийг хийхдээ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2013 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/167/203 дугаарт тушаалын хавсралтаар батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх журам”-ыг удирдлага болгон бүртгэж байна. Нийт **291** хувийн хэрэгт холбогдох бүртгэлийг бүртгэсэн байна.

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2024 оны 04 дүгээр  
сарын 12-ны өдрийн 5/4803 тоот албан бичгийн биелэлтийн талаар:**

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.2-т заасны дагуу 1 бүртгэлийн үнийг өөрчилж бүртгэсэн байна.

Барьцааны гэрээ /ипотек/ болон эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт /ЭУБ-06 маягт/-ийн барьцаа хөрөнгийн мэдээллийг нягтлан шалгаж нийт **3276** бүртгэл бүртгэсэн байна.

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2024 оны 05 дугаар  
сарын 08-ны өдрийн 5/6203 тоот албан бичгийн биелэлтийн талаар:**

Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас зээл авсан иргэн, хуулийн этгээд нь төлбөрөө төлж барагдуулаагүй тохиолдолд зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцаа хөрөнгөөр хангуулах тухай албан бичигт дурдсаны дагуу нийт улсын бүртгэгч нарт танилцуулж бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус чиглэл ирүүлсэн өдрөөс хойш болон 2024 оны жилийн эцсийн байдлаар тус бүртгэлийн үйлчилгээг авахаар Баянхонгор аймгийн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасагт мэдүүлэг гаргаагүй байна.

**Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/110 тоот албан бичгийн биелэлтийн талаар:**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.10 дахь заалт, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4 дэх хэсгийг үндэслэн өөрчлөгдсөн маягтын загварын дагуу **587** бүртгэлийг бүртгэн баталгаажуулсан байна.

**Улсын бүртгэлийн Ерөнхий газрын хяналт шалгалтын газрын 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 91 тоот дотоод албан бичгээр ирүүлсэн санал авах тухай албан бичгийн биелэлтийн талаар:**

Дээрх албан бичгийг нийт улсын бүртгэгч нарт танилцуулан, холбогдох саналыг нэгтгэсэн.

2024 оны 10 дугаар сарын 01-ны өдөр цахим санд бүртгэлийн **үйлчилгээний төрөл засаж болдог** байхаар болон **яаралтай төлөвийг байхгүй болгох** талаар саналаа хүргүүлсэн.

**Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Тамгын газрын эрх зүйн хэлтсээс 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 2-1/12503 тоот албан бичиг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/167 дугаарт тушаалын хэрэгжилтийн талаар:**

Холбогдох тушаал, албан бичгийг нийт улсын бүртгэгч нарт танилцуулан, хэрэгжүүлж ажиллаж байна.

Эд хөрөнгийн улсын бүртгэлийн тасгийн нийт улсын бүртгэгч нар нь 2023 оны 7 дугаар сараас эхлэн иргэн, хуулийн этгээдэд бүртгэлийн үйлчилгээг түргэн, шуурхай үзүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг бүрэн хангасан бүх төрлийн барьцаалбартай болон барьцаалбаргүй зээлийн гэрээ, барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг ажлын нэг өдөр буюу мэдүүлэг гаргасан даруйд нь бүртгэн үйлчилгээ үзүүлдэг. Дээрх тушаалын дагуу хэвшмэл болгосон бүртгэлийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн үзүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд нийт **6828** бүртгэлийг бүртгэн, баталгаажуулсан байна.

## Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 1/12638 дугаарт албан бичгийн биелэлтийн талаар:

Дээрх албан бичгийн дагуу бүртгэлийн үйлчилгээг авахад хүндрэлтэй ажлын ачаалал ихтэй цэцэрлэг, сургууль, цэргийн анги, цагдаагийн байгууллагын албан хаагч нарт хүрч үйлчлэх зорилгоор байгууллагуудад нь хүсэлт хүргүүлж хуваарийн дагуу “Номгон” ахлах сургууль, 3-р цэцэрлэг, Цагдаагийн газар, 4 дүгээр сургуулийн ажлын байранд нь очиж бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн ажилласан. Нийт 9 бүртгэл бүртгэж, 107 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн байна.

## ХУУЛИЙН ЭТГЭЭД, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛ

### Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:


2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн байдлаар эд хөрөнгийн нийт 9324 бүртгэлийн мэдүүлэг хүлээн авч, холбогдох бүртгэлийг Улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хөтлөн бүртгэж, цахимжуулан хадгалсан.

- Анхны бүртгэл 817
- Өмчлөх эрх шилжих гэрээний бүртгэл 1043
- Эд хөрөнгийн бүртгэлд өөрчлөлт оруулах бүртгэл 398
- Барьцааны гэрээ болон дуусгавар 3552
- Барьцааны гэрээ 3276
- Архивын лавлагаа, хуулбар, хувийн хэрэг хаах бүртгэл 233
- Урьдчилсан тэмдэглэл -4
- Түрээсийн гэрээ 1

2024 онд УАБ У.Золзаяа 1104, улсын бүртгэгч А.Оюунсүвд 2603, Т.Мягмарсүрэн 2889, С.Баярмаа 1226, С.Авирмэд 950, Т.Алтаншагай 115, Д.Мягмар 271, Ц.Эрдэнэчимэг 21, Ц.Ганчөдөр 21, Ж.Оргилмаа 8, Б.Ууганбаяр 11, З.Ёндонжамц 105 бүртгэл тус тус хийсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нийт үзүүлсэн үйлчилгээнээс улсын төсөвт үйлчилгээний хураамж 113,072,484 төгрөгийг, орон нутгийн төсөвт тэмдэгтийн хураамж 16,446,781 төгрөгийг, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны орлогын албан татварт 577, 259,866 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Эд хөрөнгийн бүртгэлийг төрлөөр нь ангилан графикаар харьцуулан харуулбал:



-Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн цахимжсан хувийн хэргүүдэд үйлчилгээ хийхдээ нотлох баримтын дараалал болон дугаарлалтыг шалгаж алдаатай байгаа хувийн хэргийг тухай бүр нь захиалгын хуудсаар архиваас татан авч /Хувийн хэргийн буцаалт хийлгүүлж, зөрчил арилгуулах тухай/ дүгнэлтийн хуудас үйлдэн тасгийн даргаар батлуулж, хяналтын улсын байцаагчаар дүгнэлт гаргуулан дахин цахимжуулж нийт 18 ширхэг хувийн хэргийн зөрчлийг арилган ажиллаа.

-Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлд зааснаар 4 иргэн хуулийн этгээдийн өргөдөл хүсэлтэд хариу өгсөн.

Тус өргөдөл гаргасан иргэнд Баянхонгор аймгийн сум дундын шүүхэд өмчлөгчөөр тогтоолгох тухай хүсэлт гаргах нь зүйтэй гэсэн хариу өгсний дагуу иргэн шүүхээр өмчлөгчөөр тогтоолгож, өмчлөх эрхийн гэрчилгээ авсан байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газарт гаргасан иргэний өргөдөл гомдлын дагуу холбогдох хувийн хэргүүдэд эд хөрөнгийн эрхийн улсын ахлах бүртгэгч У.Золзаяа хяналт хийж, сонсож ажиллагаа явуулан холбогдох баримтыг шүүхээс бүрдүүлэн Улсын бүртгэлийн газарт хүргүүлснээр тухай иргэний гомдолыг үндэслэлгүй гэж үзэн УБЕГ-ын хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гарсан байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газарт гаргасан иргэн С.Цэцгээгийн өргөдөл гомдолд дурьдсан холбогдох эд хөрөнгө байрлах Эрдэнэцогт сумд газар дээр нь улсын бүртгэгч Т.Мягмарсүрэн, А.Оюунсүвд нарын хамт очиж судлан холбогдох хариуг эд хөрөнгийн улсын бүртгэлийн газраар дамжуулан иргэнд хүргүүлэн ажилласан.

Иргэн Г.Сосорбарамын өргөдөлд мөн хариуг албан бичгээр хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

Тайлант хугацаанд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбогдуулан газар өмчлөх эрхийн гэрчилгээ **907**, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээ **1450**, нийт **2357** гэрчилгээ бичиж олгосон байна.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивт 2023 оны 12 сарын 26 -аас 2024 оны 11 дүгээр 14-ний өдрийн байдлаар нийт **9324** бүртгэлийн нотлох баримтыг архивт шилжүүлэн өгсөн байна.

Эд хөрөнгийн улсын бүртгэлийн чиглэлээр иргэн, хуулийн этгээд төрийн байгууллагад **233** лавлагаа, хуулбар хүргүүлсэн байна.

Сумын бүртгэгч нар нь 2024 онд эд хөрөнгийн чиглэлээр **552** бүртгэл, хуулийн этгээдийн чиглэлээр **130** бүртгэл тус тус хийсэн байна.


### Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр

Тайлант хугацаанд буюу 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн байдлаар хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт **2359** төрлийн бүртгэлийн үйлчилгээг иргэн, аж ахуй нэгжид түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлж ажилласан байна.

Дээрх бүртгэлүүдийг дэлгэрэнгүй графикаар харьцуулбал:



2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн байдлаар бүртгэгдсэн хуулийн этгээдийн бүртгэлийн төрлийг дараах графикаар дэлгэрэнгүй харуулбал: Үүнд:





Хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой хууль тогтоомж, журмыг судлах, түүнд нийцүүлэн үнэн зөв бүртгэл хөтлөх, хуулийн этгээдийн цахим мэдээллийн санд алдаагүй, зөв бүртгэх, эх нотлох баримтын цахимжуулалтыг тухай бүрт цахимжуулан ажиллаж байна.

Цаасан нотлох баримтыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/1050 дугаар тушаалын дагуу “Хуулийн этгээдийн хувийн хэргийг архивт шилжүүлсэн жагсаалт”-аар нийт 528 шинэ бүртгэлийн хувийн хэрэг, “Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн баримт бичгийг архивт шилжүүлсэн жагсаалт”-р нийт 1827, татан буугдсан 4 нийт 2359 хувийн хэргийн архивын материалыг ажлын 5 хоногийн дотор архивчид хүлээлгэн өгч ажиллалаа.

Тайлант хугацаанд нийт **709** нэр олгосноос E-BUSINESS –цахим системээр хоршоонд **468** нэр баталгаажуулсан ба биечлэн танхимаар **241** нэр олгосон байна.

Хуулийн этгээдийн бүртгэлээр Улсын төсөв болон орон нутгийн төсөвт нийт **35,634,500** төгрөгний орлого төвлөрүүлсэн байна.

Мөн цаг үеийн ажилтай холбоотойгоор Зээлийн батлан даалтын сан, Баянхонгор аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газраас ирүүлсэн “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд Баянхонгор аймагт шинээр болон өмнө бүртгэлтэй байсан хоршооны мэдээлэлд өөрчлөлт орсон хоршооны мэдээллийг ирүүлэх тухай албан бичгийн дагуу хуульд заасан мэдээллийг, Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Сонгуулийн хорооны албан бичгийн дагуу нэр бүхий нэр дэвшигчдийн хуулийн этгээдтэй эсэх лавлагааг тус тус гарган хүргүүлсэн байна.

### **Хуулийн этгээд, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн архивын чиглэлээр:**

Хэлтсийн архивч өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж томилогдоогүй байх хугацаанд архивын сан хөмрөгийн бүрэн бүтэн байдал, хадгалалт, хамгаалалт аюулгүй ажиллагааг хангах, хувийн хэргийн баяжилт хийх зайлшгүй шаардлага гарсан тул тус тасгийн улсын бүртгэгч Т.Мягмарсүрэн, А.Оюунсүвд, Т.Отгонсүрэн нар нь архивыг цэгцлэх, дугаарлах, нотлох баримтыг савлах, хаягжуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Эд хөрөнгийн бүртгэлийн нийт **20814** хувийн хэрэг /газрын 10440 хувийн хэрэг, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 10317 хувийн хэрэг/

2.Шинээр баригдсан орон сууцны материалыг төрөлжүүлэн байрлуулах ажлыг хийж гүйцэтгэн баримт, бүртгэлийн төрөлжүүлэлт, эмх цэгц, хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг ханган ажиллалаа.

3.Эд хөрөнгийн бүртгэлийн 817 хувийн хэрэг шинээр үүсгэн архивт байршуулсан. Мөн нэмэлт өөрчлөлт, хөдөлгөөн орсон нийт 8507 хувийн хэргийн баяжилтийг цаасан архивтын хувийн хэрэгт хавсарган хадгалсан.

4.Хуулийн этгээдийн улсын бүртгэгчээс 2024 онд бүртгэл хөтлөгдсөн нийт **709** баримтыг архивт хүлээн авч хадгаламжийн нэгж үүсгэн, тавиурт байршуулан ажилласан байна.

5.Хуулийн этгээдийн архивын **2984** ширхэг хувийн хэргийг төрөлжүүлэн хаягжуулалт хийлээ.

6.Сумдын үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн хувийн хэргийг сум сумаар нь төрөлжүүлэн байршуулсан.

7.Улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээдийн 1 хувийн хэргийг архивын сангаас ялган, тусгай тавиурт хаягжуулалт хийн төрөлжүүллээ.

2024 оны 10 сарын 25-ны өдрийн байдлаар Хуулийн этгээдийн бүртгэлийн архивт нийт **3290** ширхэг хувийн хэрэг, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 20814 хувийн хэрэг хадгалагдаж байна.

#### **ГУРАВ. БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТ;**

##### **Бүртгэлийн хяналт хийсэн талаар:**

**Нэг. 2024 оны 10 дугаар сарын 25-ны байдлаар бүртгэлийн төрөл тус бүрд хяналт тавьсан байдал.**

Иргэний бүртгэлийн чиглэлээр 4284

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 482

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 195

Архивын чиглэлээр 642 бүртгэлд хяналт тавьж , нийтдээ **5603** бүртгэлд хяналт тавьсан байна.

**Хоёр.2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар хяналт шалгалт хийгдсэн байдал.**

2024 онд Бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөө гарган батлуулж төлөвлөгөөт шалгалт-2, гүйцэтгэлийн шалгалт-1, гэнэтийн болон төлөвлөгөөт бус шалгалт -2 тус тус хийгдэж **2350** бүртгэлд хяналт шалгалт хийсэн бол өргөдөл, гомдлын мөрөөр нийт **206** бүртгэлд хяналт шалгалт хийсэн байна.

Хяналт шалгалтын төлөвлөгөө болон Зөрчлөөс урьдчилсан сэргийлэх ажлын төлөвлөгөөг батлан ххэрэгжилтийг ханган ажиллалаа.

**Гурав. Иргэн, Эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр илрүүлсэн зөрчил.** Иргэний бүртгэл -161, Эд хөрөнгийн чиглэлээр -46, Хуулийн этгээд -3, Улсын бүртгэлийн архивын /иргэний/ чиглэлээр -10, Нийт **220** зөрчил илрүүлснийг тухай бүр залруулж ажиллав.

**Дөрөв. Зөрчлийн тухай хууль.** Зөрчлийн тухай хуульд заасны дагуу нийт **365** иргэний өргөдөл, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Үүнээс 365 иргэн /хуулийн этгээд шийтгэл ногдуулаагүй/ шийтгэл ногдуулснаас улсын төсөвт 7 300 000 төгрөгийн орлого оруулж ажилласан байна. Зөрчлийн тухай хуульд заасан Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу Прокурорын байнгын хяналтан дор явуулж байна.

#### **Тав. Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт.**

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил дутагдал гаргахгүй, улсын бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бүртгэл хөтлөхийг зорилтоо болгон ажиллаж билээ.

2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар гаргасан Хяналтын улсын байцаагчийн нийт **70** дүгнэлт гаргаснаас иргэний бүртгэлийн чиглэлээр гарсан дүгнэлтүүдийг хүснэгтээр харуулвал. Үүнд:

Бүртгэлийн төрлөөр ангилвал.

№	Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тоо
1	Иргэний бүртгэл	36
2	Хуулийн этгээдийн бүртгэлийн талаар	7
3	Эд хөрөнгө	27
	<b>Нийт</b>	<b>70ш</b>

#### **Зургаа. Хяналтын улсын байцаагчаас гарсан**

№	Хяналтын улсын байцаагчийн	тоо
1	Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт	70
2	Хяналтын улсын байцаагчийн шийтгэлийн хуудсаар	365
3	Хяналтын улсын байцаагийн мэдэгдэл	0
4	Хяналтын улсын байцаагчийн акт	0
5	Хяналтын улсын байцаагчийн албан шаардлага	0
	<b>Нийт</b>	<b>435ш</b>

#### **Долоо. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар**

2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар иргэнээс ирүүлсэн нийт **20** өргөдлийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр бүрэн шийдвэрлэсэн байна.

Мөн байгууллагын /тус хэлтсийн/ эрх бүхийн албан тушаалтны нийт **20** хүсэлтийг хүлээн авсан байна. Үүнээс эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 23 хүсэлт,

Иргэний бүртгэлтэй холбоотой 14 хүсэлт, хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой 8 хүсэлтийг тус тус хүлээн авч хяналтын улсын байцаагчийн дүнгэлтээр 100 хувь шийдвэрлэсэн байна.

#### **Найм.Улсын бүртгэлийн газраас ирүүлсэн үүрэг чиглэлийн биелэлт**

Хяналтын улсын ахлах байцаагчийн 2022 оны 1497, 1499, 1500, 2023 оны 4865 дугаартай дүгнэлтүүдийн биелэлтийг тогтмол ханган ажиллаж байна. Мөн 2024 онд Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн чиглэл, зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа болно.

**Ес.**2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар бүртгэлийн хяналтын чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын мэдээг Хяналт шалгалтын газарт 10 удаа [zurhliin.san@burtgel.gov.mn](mailto:zurhliin.san@burtgel.gov.mn) хаягаар хугацаандаа хүргүүлсэн, Аймгийн Прокурорын газарт зөрчлийн хэрэг бүртгэлттэй хүлээн авсан өргөдөл, гомдлын мэдээг өдөр бүр [bayankhongor@prokuror.mn](mailto:bayankhongor@prokuror.mn) хаягаар илгээж, хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн зөрчлийн материалыг ажлын 5 өдөрт багтаан тухай бүр хүргүүлэн ажиллаж байна. Мөн хэлтсийн нягтлан бодогчид маягт үнэт цаасны мэдээ, шийтгэлийн хуудасны мэдээг 10 удаа хугацаандаа өгч ажилласан байна.

Хяналтын шалгалтын төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 9 арга хэмжээг төлөвлөн батлан хэрэгжүүлж байгаагаас хэрэгжилт 55,5 хувьтай байна.

#### **ДӨРӨВ. САНХҮҮ, ТӨСВИЙН УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТ БОЛОН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

Улсын бүртгэлийн хэлтэс нь 2024 оны 11 дүгээр сарын 15-ны байдлаар улсын төсвөөс 163.366.423,4 мянган төгрөгийн урсгал санхүүжилт авч цалин хөлсний зардалд 926.479,2, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 125.200,6 гэрэл цахилгааны зардалд 2.784,9, түлш халаалтын 48.759,2, цэвэр бохир усны зардалд 2.208,4, бичиг хэргийн зардалд 12.988,3, тээвэр шатахууны зардалд 3.235,7 шуудан холбооны зардалд 2.248,3, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардалд 1800,0, багаж техник хэрэгслийн зардалд 335,0, хөдөлмөр хамгааллын хэрэглэлийн зардалд 200,0, мэдээллийн технологийн зардалд 2.970,0, урсгал засварын зардалд 2.035,0, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 554,2, тээврийн хэрэгслийн татварын зардалд 83,0, газрын төлбөрт 167,0, хөдөө орон нутагт тогтвортой ажилласны тэтгэмжийн зардалд 194.129,2, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 400,0, мянган төгрөг зарцуулж улсын төсвийн орлогын дансанд үндсэн үйл ажиллагааны орлого 174.343,1 мянган төгрөгийг улсын төсвийн дансанд төвлөрүүлэн ажиллаж байна.

УБЕГ-ын Санхүү аж ахуйн хэлтсээс 14.183,6 мянган төгрөгийн үнэт цаас, хангамжийн материал, 5.994,5 төгрөгийн бэлэн бүтээгдэхүүн хүлээн авч, төсвийн хөрөнгөөр 37.138,1 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан байна. Бараа материалын данснаас 41.809,6 мянган төгрөгийн үнэт цаас, хангамж, бусад бараа материалд хөдлөл өөрчлөлтөөр бүртгэн сар бүр үнэт цаасны тайлан няравын тайланг гаргуулан авч Санхүү ,аж ахуйн хэлтэст хүргүүлж хэвшсэн.

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж сар, улирал, хагас жилийн тайланг УБЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтэст 10 удаа, Аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэст сар бүр ,Татварын хэлтэст улирал бүр тайлан мэдээг хуулийн хугацаанд баталгаажуулан харилцагч байгууллагуутдай тооцоо нийлж өглөг, авлага үүсгэхүй байх тал дээр анхааран ажиллаж байна.

Байгууллагын 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг хуулийн хугацаанд гарган УБЕГ-т хүргүүлсэн.

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын тогтоолын дагуу байгууллагын санхүүгийн мэдээллийг [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn), сайтад сар бүр тогтмол байршуулан 139 удаагийн мэдээлэл шинэчилж, [www.bayankhongorburtgel.com](http://www.bayankhongorburtgel.com) сайтад тогтмол байршуулан 10 удаагийн мэдээлэл шинэчилж ажилласан.

2023 оны Санхүүгийн тайлан, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Төрийн Аудитын байгуулагаар шалгагдаж “Зөрчилгүй” санал дүгнэлтэй ажиллаж аудитаар өгсөн зөвлөмж, зөвлөмжийн биелэлтийг заасан хугацаанд Төрийн аудитын байгууллага болон УБЕГ-ын БТДШГазарт хүргүүлсэн.

2024 оны 11 дүгээр сарын 15-ны байдлаар батлагдсан төсөв хүрэхгүйгээс шалтгаалан шуудан холбооны зардалд 328,2 мянган төгрөгийн өглөгтэй байна.

## **ТАВ.БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АЖИЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ СУРТАЛЧЛАХ АЖИЛЛАГАА**

### **5.1.Байгууллагын архив, бичиг хэргийн эргэлтийн бүртгэл, тайлан**

Хэлтсийн хэмжээнд 2024 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар ирсэн албан бичиг 933, Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын даргын тушаал, чиглэл, зөвлөмж , дотоод албан бичиг нийт 50 тус тус бүртгэгдсэн байх ба хэлтсээс 898 албан бичиг явуулсан байна.

Ирсэн, явсан албан бичиг болон өргөдөл, гомдлыг скайнердэж тус тус программ дээр бүртгэн хяналтын карт хөтлөн хяналт тавин ажиллаж байна.

Хэлтэст нийт 653 хариутай албан бичиг ирүүлсэн ба хуулийн хугацаа хэтрүүлэн хариу илгээсэн албан бичиг байхгүй болно.

Удирдлагаас гарах шийдвэрийн болоод зохион байгуулалтын баримт бичиг буюу Хэлтсийн даргын тушаал 33, хамт олны хурлын тэмдэглэл 8 гарсан байна.

## **5.2 Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт**

Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу байгууллагад ирсэн өргөдлийг бүртгэлжүүлэн хариуг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна. 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар нийт 27 өргөдөл ирсэн. Үүнээс бүрэн шийдвэрлэсэн 23 буюу 85,1 хувьтай байна. Харин 4 өргөдөл судлагдаж байна. Өргөдөл гомдлын мэдээг тогтоосон цаг хугацаанд Улсын бүртгэлийн Ерөнхий газар болон аймгийн Төрийн захиргаа удирдлагын хэлтэст тус тус хүргүүлэн ажиллаж байна.

## **5.3 Үйл ажиллагааг сурталчилсан байдал**

УБЕГ-аас нэгдсэн байдлаар үүсгэн хөтлөж буй хэлтсийн вэйб хуудсанд хэлтсээс хийж хэрэгжүүлж буй ажил үйлчилгээ, зохион байгуулсан сургалт, цаашид хийж хэрэгжүүлэх ажлууд, бүртгэлийн тоон мэдээ, нээлттэй ажлын байрны зар болон цаг үеийн мэдээ мэдээллийг тухай бүр нь байршуулж иргэд олон нийтэд түгээн дэлгэрүүлж ажиллаж байна. /Bayankhongor.burtgel.gov.mn/ Тус хаягт жилийн эцсийн байдлаар 54 үйл ажиллагааг сурталчлан байршуулсан байна. Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс гэсэн фэйсбүүк пэйж хуудсанд 476 удаагийн мэдээ мэдээллийг тавьж байршуулан иргэд олон нийтэд сурталчилж хамгийн олон хандалт авсан мэдээ мэдээлэл нь “Архивч ажилд авах зар”, “Бүртгэлийн үйчилгээг Бямба гарагт” үзүүлэх зар мэдээллүүд тус тус байна.

Хэлтсийн албан хаагчдад УБЕГ болон хэлтсээс зохион байгуулсан ажил үйлчилгээ, орон нутгийн төр захиргааны байгууллагын бодлого шийдвэрийг сурталчлахад идэвхтэй оролцон холбогдох цахим хаягуудад хандалт хийж уншиж танилцаж, шэйр хийн хууль тогтоомжийг сурталчлан таниулах үүргээ гүйцэтгэж идэвхтэй ажиллах үүргийг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд арга хэмжээ болгон тусган хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж хэвшсэн.

Байгууллагын үйл ажиллагааг сурталчилж буй бас нэг хэлбэр бол “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулах ажил бөгөөд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг Баянговь, Жаргалант сумдад хийлээ. Эдгээр сумдад хийсэн бүртгэлийн талаарх тоо


мэдээ болон бусад дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн Арав.Идэвх санаачилга, шинэлэг ажлын талаарх бүлгээс үзнэ үү.

#### 5.4 Гадагш чиглэсэн сургалт, үйл ажиллагаа

1.Аймгийн Засаг даргын Тамгын газраас сумдын Хууль эрх зүй, дотоод асуудал хариуцсан ажилтнууд, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд, Насан туршийн суралцахын төв, сургуулиудын эрх зүйн хөтөч нарын мэдлэгийг дээшлүүлж чадавхжуулах танхимын ээлжилт сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 26,27-ны өдрүүдэд зохион байгууллаа. Уг сургалтанд хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхам "Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хууль"-ийн үзэл баримтлал, хуульд орсон шинэ нэр томъёо, шинэлэг зохицуулалт, мөн тус хуулиар зохицуулсан харилцаа бусад хуультай, нэн ялангуяа Улсын бүртгэлийн багц хууль тогтоомжтой хэрхэн холбогдож байгаа талаар сургалт орж, эрх зүйн хөтөч нарын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, чадавхжуулахад хувь нэмрээ орууллаа.



2.Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхам, улсын бүртгэгч Э.Адъяабаяр нар 2024 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Баянхонгор аймгийн Хаан банкны салбар, тооцооны төвийн 24 нэгжийн нийт



106 менежер, зээлийн мэргэжилтэн, салбарын захирал, эрхлэгч нарт Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим шилжилтийн хүрээнд хийж, хэрэгжүүлж байгаа ажил, үйлчилгээ, Тоон гарын үсгийн хэрэглээ, ач холбогдол зэрэг цаг үеийн мэдээллээр сургалт хийж, тоон гарын үсэгтэй холбоотой гарч буй алдаа, анхаарах зүйлийн талаар харилцан санал солилцлоо.

3. Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхам, улсын бүртгэгч Э.Адъяабаяр нар 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Эрдэнэмандал ахлах сургуулийн ажилтан, алба хаагчидад Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим шилжилтийн хүрээнд хийж, хэрэгжүүлж байгаа ажил, үйлчилгээ, тоон гарын үсгийн хэрэглээ, ач холбогдол зэрэг цаг үеийн мэдээллээр сургалт хийж, 25 иргэний гар утсанд Gsign аппликейшн суулгуулж, арга зүйн зөвлөгөө өглөө.



4. Аймгийн Сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга нарын дунд 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан танхимын сургалтаар "Сонгогчийн нэрийн жагсаалт ба улсын бүртгэлийн байгууллагын чиг үүрэг" сэдвээр мэдээлэл өгч ажиллалаа.

5. Улсын бүртгэлийн хэлтсээс хуулийн хэрэгжилт хамтын ажиллагааг дэмжих ажлын хүрээнд төрийн байгууллагуудын чиг үүргийн уялдаа холбоог сайжруулах, хамтын ажиллагааг уялдуулах замаар төрийн цахим үйлчилгээг сурталчилан таниулах, иргэдэд цахим ур чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн багц сургалтыг Баянхонгор аймаг дахь Цахим үйлчилгээний хэлтэс, аймгийн Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран зохион байгуулж байна. Энэ удаагийн сургалтаар Төрийн цахим үйлчилгээг хэрэглэх чадварыг сургагч багшаар дамжуулан нэмэгдүүлэхэд чиглэсэн "Цахим хөтөч-сургагч багш" бэлтгэх сургалтыг арван



жилийн сургуулийн 10 дугаар ангийн хүүхдүүдийг хамруулан 5 сарын 16, 17-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулав.

Тус сургалтанд аймгийн төвийн Номундалай, Номгон, Эрдэнэмандал, Эрдэм цогцолбор сургуулийн 10 дугаар ангийн 24 хүүхэд хамрагдаж "Цахим хөтөч-сургагч багш" сертификатаа 5 дугаар сарын 27-ны өдөр гардан авлаа.

Төрийн цахим үйлчилгээг сурталчлах, иргэд цахим үйлчилгээг авахад чиглүүлэгч анхны (улсын хэмжээнд) "Цахим хөтөч-сургагч багш" бэлтгэгдсэнээрээ энэ удаагийн сургалт ихээхэн онцлог байлаа



6. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулж явуулах Баянхонгор сумын сонгуулийн хороо болон 11 хэсгийн хороодын ажлын албаны ажилтан албан хаагчдад зориулсан эрх зүйн сургалтанд Улсын бүртгэлийн хэлтсээс оролцож "Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, давхардал зөрчлийг арилгах, танилцуулах, сонгогч шилжих журам"-ын талаар танилцуулж, анхаархах асуудал, хамтын ажиллагааг нягтлан уялдуулан ажиллах, хууль, журмыг нэг мөр ойлгож хэрэглэх талаар арга зүйн зөвлөгөө мэдээллийг өглөө.

7. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн ажлын хүрээнд аймгийн Сонгуулийн хорооноос сумын сонгуулийн хорооны дарга, нарийн бичиг, ня-бо нарт зориулсан хууль, эрх зүйн сургалтанд Улсын бүртгэлийн хэлтсээс Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга П.Бүжинлхам оролцож, сумын сонгуулийн хорооны дарга, хэсгийн хорооны дарга, даамал болон улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан нарын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулж хамтран ажиллах чиглэлээр холбогдох мэдээллийг өглөө.

8. Улсын бүртгэлийн хэлтэс нь Баянхонгор аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс, "Хөгжлийн шийдэл-BEST" хөтөлбөрийн Баянхонгор аймаг дахь салбартай хамтран Монгол Улсын Засгийн газрын "Шинэ сэргэлтийн бодлого"-ын баримт бичгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдаж байгаа "Шинэ хоршоо хөдөлгөөн", "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлаар 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр сургалт зохион байгуулсан.

Тус сургалтаар хоршоог хэрхэн байгуулах, улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбоотой баримт бичгийг боловсруулахад чухалчлан анхаарах зүйл, шинээр байгуулсан болон хуулийн этгээдийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулсан бол цахим E-Mongolia 8 E-buseness.mn цахим платформ ашиглан хэрхэн бүртгүүлэх гэх зэрэг олон асуудалд мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлсэн.

Сургалтанд хөдөө аж ахуйн чиглэлийн үйл ажиллагаа эрхлэдэг, эрхлэхээр төлөвлөж шинээр үүссэн байгуулагдаж буй 16 хоршоо, тэдгээрийн дарга, тэргүүлэгч гишүүд нийт 39 иргэн хамрагдсан.



9. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Сонгогчдын нэрийн жагсаалт хүргэгдсэн өдрөөс эхлэн хэсгийн хороо сонгогчийн өөрт нь холбоотой мэдээлэлтэй танилцах боломжоор хангах, итгэмжлэгдсэн ажилтан болон улсын бүртгэлийн байгууллага сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотойгоор гарсан гомдлыг шийдвэрлэх ажиллагааны хүрээнд Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс "Хуулиар хүлээсэн хамтын чиг үүргийн хүрээнд хамтын ажиллагааг сайжруулж, сонгогчийн сонгох, сонгогдох эрхийг ханган ажиллах" сэдэвт цахим сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулав. Сургалтанд

Баянхонгор аймгийн 106 хэсгийн сонгуулийн хэсгийн хорооны дарга нар болон итгэмжлэгдсэн ажилтнууд оролцов.

## **ЗУРГАА. БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТ, ХӨГЖИЛ, ЁС ЗҮЙ**

### **6.1. Албан хаагчдын сургалт, хөгжил**

Байгууллагын нийт албан хаагчдыг чадавхжуулах, мэдлэг чадварыг дээшлүүлэх, төрийн албан хаагчийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хэлтэс нь сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөөг хагас бүтэн жилээр батлан хэрэгжүүллээ. Энэ онд төлөвлөгөөний дагуу хэлтсийн дотоод сургалт нийт 21 удаа амжилттай зохион байгуулагдсан бол хэлтсийн албан хаагчдаас өөрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт арга хэмжээний хүрээнд бие даан 8 албан хаагч тус тус сургалтыг зохион байгууллаа.

Жил бүр хийж хэвшсэн хэлтсийн албан хаагчдын нэгдсэн сургалтыг мөн тусгай хөтөлбөр гарган хэрэгжүүлж 4 дүгээр сарын 18-19-ний өдөр зохион байгуулж ирц 100 хувьтай оролцлоо. Сургалтуудаас дурьдвал:

Тус хэлтсээс аймгийн Насан туршийн суралцахуйн төвтэй 3 дахь жилдээ хамтран ажиллаж байна. Байгууллагын 2024 оны сургалтын төлөвлөгөөнд туссан дагуу 2024 оны анхны сургалтыг 02 дугаар сарын 21-ний өдөр хийж хэлтсийн 7 хоног бүр хийж хэвшсэн Лхагва гарагт хэлтсийн дарга Ц.Мөнхжаргал цаг үеийн асуудлаар мэдээлэл өгч, Насан туршийн суралцахуйн төвөөс мэргэжилтэн С.Отгонцэцэг “Зорилгоороо удирдуулах нь” сэдвээр,

-2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр Насан туршийн суралцахуйн төвийн багш П.Дайрийсүрэн “ЕМРАТУ-БУСДЫГ МЭДЭРЧ, ОЙЛГОХ ЧАДВАР” сэдвээр,

- 3 дугаар сарын 06-ны өглөөний 08.00 цагт "Минималист амьдралын хэв маяг" сэдвээр эхлэн "Насан туршийн суралцахуйн төв"-ийн багш Амарсанаа сургалт хийсэн бол үргэлжлүүлэн "Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт" сэдвээр иргэний улсын бүртгэгч З.Дуламсүрэн,

-7 хоног бүрийн Лхагва гараг бүрийн 08.00 цаг хийдэг сургалт мэдээллийн цаг 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулагдан бичиг хэргийн ажилтан Л.Ичинхорлоо -Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулиар, хэлтсийн дарга Ц.Мөнхжаргал- Монгол улсын Их хурлын сонгуулийн тухай хуулиар тус тус сургалт мэдээллийг хийлээ. Сургалтанд төвийн албан хаагчид танхимаар, сумдын албан хаагчид онлайнаар хамрагдлаа.

- 03 дугаар сарын 13-ны өдөр Насан туршийн суралцахуйн төвийн сургагч багш “Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо” сэдвээр,



Тус сургалтанд хэлтсийн төвийн албан хаагчид танхимаар, сумдын албан хаагчид онлайнаар хамрагдлаа.

-2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн хэлтсийн мэдээллийн цагаар хэлтсийн дарга Ц.Мөнхжаргал “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль”-иар,

-Улсын бүртгэлийн Ерөнхий газарт 2024 оны 04 дүгээр сарын 4-5-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Удирдах ажилтны нэгдсэн сургалт семинарийн дараагаар хэлтсийн нийт албан хаагчдын нэгдсэн сургалт зөвлөлгөөнийг 2024 оны 4 дүгээр сарын 18-19-ний өдөр тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулж



явуулав.Сургалтаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 он, 2024 оны үйл ажиллагааны талаар, Сонгуулийн ерөнхий болон дэд төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, цаашид хийж хэрэгжүүлэх ажлын танилцуулга, Цахим системээс лавлагаа гаргах, анхаарах асуудал, И-монгол-оор ирсэн хүсэлтийг шийдвэрлэхэд анхаарах асуудал зэрэг нийт 2 өдөр 16 цагт 25 сэдвийг хамруулан зохион байгуулж, УИХ-ын сонгуулийн тухай хууль тогтоомжийн сургагч багш бэлтгэн сертификат гардуулан өглөө.

Мөн энэ үеэр хэлтсийн улсын бүртгэгч Ж.Оргилмаа Хууль зүй, дотоод хэргийн яамны "Жуух бичиг" -ээр шагнагдсныг гардуулан өгч хамт олноос нь амжилтын дээдийг хүсэн ерөөлөө.

Мөн Монгол орон даяар жил бүрийн 4 дүгээр сард тэмдэглэн өнгөрүүлдэг "Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй" аяны хүрээнд зохион байгуулан хэвшсэн сургалтыг дээрх сургалттай хамтатган зохион байгуулж аймгийн Үйлдвэрчний хорооны дэд дарга П.Уранчимэг оролцлоо.



2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр сургалт мэдээллийн цагаар "Миний эрүүл мэнд миний гарт", 11 дүгээр сарын 6-ны өдөр улсын бүртгэгч Д.Мягмар "Төрийн захиргааны болон үйлчилгээний албн хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, 11 сарын 13, 20-ний өдрүүдэд Суралцагч хот төслийн хүрээнд хэрэгжиж буй "Суралцагч байгууллага" дэд ажил, арга хэмжээг хэрэгжүүлэн тус хэлтсийн албан хаагчдад



эхний багц сургалтыг Насан туршийн суралцахуйн төвийн багш Б.Мөнхнасан зохион байгууллаа. Сумдын албан хаагчид цахимаар хамрагдлаа.

Албан хаагчид эрүүл идэвхтэй хөдөлгөнийг эрхэмлэдэг бөгөөд Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар зохион байгуулж буй "Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөн, "Цаг гаргая" аянд нэгдэж хэлтсийн хамт олон 1 дүгээр сарын 16-ны өдрөөс 5 хоног Бүжгийн сургалтанд хамрагдсан бол 1 дүгээр сарын 25-ны өдрөөс сарын эхлэн Аймгийн Эрүүл мэндийн газраас зохион байгуулж буй "Эрүүл Иргэн -Хонгорын баялаг" аяны хүрээнд ажлын байрны дасгалыг хийж хэвшүүлээд байна.

Энэ талаарх мэдээллийг "Эрүүл иргэн- Хонгорын баялаг" пэйж хуудсанд өдөр бүр байршуулан ажиллаж байна.

-Хэлтсийн албан хаагчдын Монгол бичгийн чадварыг сайжруулж Хос бичгээр албан хэрэг хөтлөх бэлтгэл ажлыг хангах зорилгоор 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн 20 цагийн "Монгол бичгийн хичээл"-ийг аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн багшаар заалган суралцаж 12 албан хаагч сертификат авсан байна.



## 6.2. Албан хаагчийн ёс зүйн асуудал

Улсын бүртгэлийн байгууллага нь төрийн үйлчилгээний 70 гаруй хувийг үзүүлдэг, мөн өдөр тутамдаа байнгын ачаалалтай ажилдаг зэрэг ажлын онцлогоос шалтгаалан харилцааны ур чадварыг цаг ямагт шаардаж байдаг ба хамгийн гол нь

харилцаа хандлага л чухал түүнд анхаарч түүнийг эрхэмлэн ажиллахыг зөвлөн ажиллаж байна.

Иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг тандах, албан хаагчдын харилцаа хандлагыг өөрчлөх, байгууллагын үйлчилгээг сайжруулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, үйлчилгээний стандартыг мөрдүүлэх зорилгоор үйлчилгээний зааланд санал хүсэлтийн дэвтэр, өргөдөл гомдол хүлээн авах 70440517 дугаарын утсыг тогтмол ажиллуулж байна.

2024 он гарсаар ёс зүйн зөрчил гаргасан талаар ямар нэгэн өргөдөл гомдол ирүүлээгүй байна.

## **ДОЛОО. ОРОН НУТАГ ДАХЬ ХАМТЫН АЖИЛЛАГАА**

Аливаа байгууллага орон нутгийн удирдах байгууллага, түүний хамт олонтой нягт хамтран ажиллах нь төрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, байгууллага чиг үүргээ амжилттай хэрэгжүүлэх бас нэгэн тулгуур билээ. 2024 онд хэлтсээс орон нутагтай дараах байдлаар хамтарч ажиллалаа.

1. Баянхонгор сумын Засаг даргын захирамжийн дагуу сар бүрийн 12-ны өдөр хуваарьт газартаа бүх нийтийн цэвэрлэгээ хийхээр тогтоосон дагуу хэлтсийн албан хаагчид аймгаас баруун тийш зорчих хот хоорондын замын хоёр талаарх хог хаягдлыг 8 удаа цэвэрлэж дахивар хог хаягдлыг тушаах цэгт нь хүргэж өгч ажиллалаа.



2. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлсэнд нэгдэж тус хэлтэс нь Баянхонгор сумын Засаг даргын А/95 дугаар захирамжийн дагуу Бүх нийтээр мод тарих өдрийг тохиолдуулан 2024 оны

05 дугаар сарын 17-ны өдөр аймгийн төвийн хойд талаар хуваарилсан газарт 100 ширхэг Улиас, Голт бор, Бургас модыг, Намрын сүүл сарын шинийн 15-ны билэгт сайн өдөр мод тарьдаг 4 дүгээр талбайдаа 25 мод шинээр тарьж, хавар тарьсан 100 ширхэг моддынхоо усалгаа арчилгааг хийлээ. 2016 оноос хойш мод тарьдаг хуваарьт талбайдаа буюу 1, 2, 3 дугаар талбайдаа нийт 600 гаруй модыг тарьж ургуулан Баянхонгор суманд хүлээлгэн өгсөн байна.



3.Аймгийн Төрийн албаны салбар зөвлөлөөс 3, 5, 11 дүгээр саруудад зохион байгуулсан төрийн албан хаагчийн шалгалтын комисст ажиллан, шалгалтанд оролцогчдын мэдээллийг хурууны хээгээр шалган оруулж хамтран ажиллалаа.

4.Аймгийн ЗДТГ-аас 14 хоног бүрийн Мягмар гарагт зохион байгуулагддаг шуурхай мэдээллийн цагт хэлтсийн дарга бүрэн хамрагдаж албан хаагчдад мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэж ажилласан ба нэг удаагийн "Удирдлагуудын шуурхай мэдээллийн цаг"-ийг тус хэлтсийн сургалтын танхимд 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулж явууллаа.Тус мэдээллийн цагаар хэлтсийн хяналтын улсын байцаагч Л.Мэндбаяр "Зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь", Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга П.Бүжинлхам "МУ-ын Их хурлын сонгуулийн тухай хуульд орсон өөрчлөлт ба Улсын бүртгэлийн байгууллагын гүйцэтгэх үүрэг" сэдвээр тус тус мэдээлэл хийлээ.





5.2024 оны 4 дүгээр сарын 1-нд аймгийн Удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулагдаж аймгийн Засаг даргатай Хамтран ажиллах 2024 оны гэрээгээ байгуулан ажиллалаа.



6.Цахим хөгжил, харилцаа холбооны яам "Цахим аймаг" бодлогын зөвлөмжийн хүрээнд цахим шилжилтийг үндэсний хэмжээнд эрчимжүүлэх зорилгоор "Цахимд хэвшье" уриатай "Цахим хөгжлийн өдөрлөг" арга хэмжээг харьяа, салбар байгууллагуудын дэмжлэгтэйгээр харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын 20 гаруй төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын идэвх санаачилга, оролцоотойгоор хамтран зохион байгуулсанд байгууллага хамт олноороо оролцлоо.



7.2024 оны 03 дугаар сарын 21-ний өдөр орон даяар зохион байгуулсан Төрийн Аудитын газрын хэлэлцүүлэгт хэлтсийн дарга, ахлах нягтлан бодогч нар оролцлоо.

8.Улсын их хурлын сонгуулийн тухай хуульд заасан дагуу аймгийн Сонгуулийн хорооны гишүүнээр томилогдон ажиллаж тус хорооны 5 удаагийн хуралдаан болон сонгуулийн хэсгийн хороодын ажлын бэлэн байдал шалгах, саналыг хуудас бусад материал тараах зэрэг ажлаар хөдөө сумдад ажиллав.

9.Өвөрхангай аймагт 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр болсон “Монгол улсын Их хурлын сонгуулийн томосгосон тойрог дахь маргаан шийдвэрлэх ажиллагаа” мэдээлэл солилцох хамтарсан арга хэмжээнд хэлтсийн хяналтын улсын байцаагч Л.Мэндбаяр оролцлоо.

10.Хүний эрхийн комисс Баянхонгор аймагт ажиллах үеэр хэлтсийн дарга болон албан хаагчид тус тус хөтөлбөрт арга хэмжээ сургалтанд бүрэн оролцлоо.

11.Засгийн газрын 2017 оны “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”-ийн 67 дугаар тогтоолын хүрээнд тус газраас ерөнхий боловсролын “Номгон” сургууль дээр гал түймрийг унтраах, эрэн хайх аврах ажиллагааг зохион байгуулах, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн харилцан ажиллагаа, бэлтгэл бэлэн байдлыг хангах, гал түймэр унтраах, аврах “Тактикийн дадлага, сургууль”-ийг зохион байгуулсан ажлын хүрээнд мэргэжлийн байгууллагын бэлтгэл, бэлэн байдлыг шалгасанд нь мэргэжлийн ангиар Улсын бүртгэлийн хэлтэс хамрагдлаа.



12.Аймгийн Засаг даргын А/480 дугаар захирамж, Аймгийн онцгой комиссоос өгөгдсөн үүргийн дагуу төрийн байгууллагууд улаан буудай савлах, ачих ажлыг 2 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд хийж нийт 1575 ш шуудай буудайг бэлтгэн шиф сум болох Бууцагаан суманд Баянхонгор аймгийн Боловсрол шинжлэх ухааны газар Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Баянхонгор сумын 13-р цэцэрлэг, Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны хамт олонтой тус тус хамтран гүйцэтгэлээ. Мөн хамт олны сэтгэлийн өглөг 500,000 төгрөгийг "Бууцагаан сумын ЗДТГ-т хүргүүлээ.



13.Хэлтсийн байранд их засвар хийгдсэнтэй холбоотойгоор аймгийн Засаг даргад албан бичгээр санал хүргүүлснээр Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Сургалтын танхимд 2024 оны 04 дүгээр сарын 1-ээс 2024 оны 8 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд бүтэн 4 сар үнэ төлбөргүйгээр Бүртгэлийн үйлчилгээний хэвийн тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллалаа.



14. Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 71 дүгээр захирамжаар батлагдсан “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Жендэрийн үндэсний хорооноос 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр цахимаар танилцуулсан бөгөөд уг сургалт,



мэдээллийн арга хэмжээнд тус хэлтсийн хамт олон Аймгийн ЗДТГ-ын хурлын зааланд танхимаар хамрагдав.

15. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар “Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв” УТҮГ-тай хамтран бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх, кибер аюулгүй



байдлын “ЦАХИМД ЗӨВ БАЙЯ” аяныг улсын хэмжээнд өрнүүлэн аяны хүрээнд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын томилогдсон багийн гишүүд Баянхонгор аймагт 10 дугаар сарын 25-ны өдөр ажиллан “Кибер аюулгүй байдал” сэдэвт сургалтыг аймаг, сумдын удирдлагууд болон холбогдох 280 гаруй албан хаагчдад өнөөдөр зохион байгуулсанд хэлтсийн хамт олны төлөөлөл хамрагдав.

16. Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар, Насан туршийн суралцахуйн төвөөс санаачлан Баянхонгор сумын Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр төрийн албан хаагчид, гэр бүл, иргэн, хүүхэд, үндэсний өв соёл, нийгмийн харилцааны соёл, хууль, дүрэм журмын мэдлэг ойлголтоо тасралтгүй дээшлүүлж, эрүүл зөв амьдралын хэвшилтэйгээр эрүүл аюулгүй орчныг бүрдүүлж чанартай сурах, ажиллах, амьдрах арга, дадлыг өөртөө бий болгон хэвшүүлэх, тасралтгүй суралцахуйг эрхэмлэн, насан туршдаа суралцагч иргэн бүхий Суралцагч хот болох зорилгоор "Суралцагч хот" төсөлт ажлыг Баянхонгор сумын хэмжээнд эхлүүлээд байна.

Тус төслийн зорилго нь тасралтгүй суралцах нь ажил, амьдралдаа амжилттай байх, орон нутгийн болон улсын хөгжлийн гол хөдөлгөгч хүч болох, үр хүүхдэдээ гэрэл, гэгээтэй ирээдүйг үлдээх ач холбогдолтойг ухааруулсан насан туршдаа суралцагч иргэн бүхий Суралцагч хотыг бий болгоход чиглэгдэж байна. Тус нээлтийн арга хэмжээнд хэлтсийн эцэг, эхийн зөвлөл оролцож суралцагч байгууллага төрөлд оролцох паззалыг гардан авлаа.



17. Хуулийн хэрэгжилт, хамтын ажиллагааг дэмжих зорилтод арга хэмжээний хүрээнд Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь Баянхонгор аймаг дахь

Төрийн цахим үйлчилгээний хэлтэс, “Хөгжлийн шийдэл-BEST” хөтөлбөрийн Баянхонгор аймаг дахь салбартай хамтран Монгол Улсын Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого”-ын баримт бичгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдаж байгаа “Шинэ хоршоо хөдөлгөөн”, “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээг хэрэгжүүлэхэд малчдад тулгамдаад байгаа нэн тэргүүний асуудал болох хоршоог хэрхэн байгуулах, хоршоог байгуулахад болон хоршоог улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбоотой баримт бичгийг боловсруулахад чухалчлан анхаарах зүйл, шинээр байгуулсан болон хуулийн этгээдийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулсан бол цахим E-Mongolia 8 [E-business.mn](http://E-business.mn) цахим платформ ашиглан хэрхэн бүртгүүлэх гэх зэрэг олон асуудлын шийдлийг олгох болон цахим ур чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх зорилго бүхий хамтын сургалтыг 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр зохион байгууллаа.

Тус сургалтанд хөдөө аж ахуйн чиглэлийн үйл ажиллагаа эрхлэдэг, эрхлэхээр төлөвлөж шинээр үүссэн байгуулагдаж буй 16 хоршоо, тэдгээрийн дарга, тэргүүлэгч гишүүд, нийт 39 хүн хамрагдав

18.Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Хууль, эрх зүйн хэлтэстэй хамтран 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр “Авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” Нээлттэй хаалганы өдөрлөг арга хэмжээг зохион байгуулж явуулав.



### **НАЙМ.ХЭЛТСЭЭС ЗОХИОН БАЙГУУЛСАН БУСАД АЖИЛ**

Албан хаагчдынхаа чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, холбогдох төлөвлөгөөний биелэлтийг хангах чиглэлээр Улсын бүртгэлийн байгууллагын 83

жилийн ой, "Улсын бүртгэлийн ажилтны өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хөтөлбөрийн хүрээнд хэлтсээс дараах ажлуудыг амжилттай зохион байгууллаа. Үүнд:

1. "Эрүүл мэнд эрхэм баян" уриан дор 11 сарын 27-ны өдрөөс 5 хоног спорт бүжгийн багшийг урьж ажилтнууддаа дасгал хөдөлгөөнийг заалгав.

2. "Хос бичигтэн" Монгол бичгийн олимпиадад бэлтгэж 11 сарын 09-ний өдрөөс 7 хоногийн хичээлийг Номундалай цогцолбор сургуулийн багш Г.Энхтуяаг урин заалгаж албан хаагчид бүрэн хамрагдсан.Тус уралдааны Хичээнгүй бичгийн төрөлд хамт олноороо Гуравдугаар байр эзлэв.

3.12 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд тусгай хөтөлбөрийн дагуу Албан хаагчиддаа мэргэжил арга зүйн сургалтыг зохион байгуулсны дараагаар хэлтсийн албан хаагчид 6 багт хуваагдан спорт, урлагийн бэсрэг наадмаар өрсөлдөж Г.Бадамханд ахлагчтай "Хатуу самарнууд" баг Тэргүүн байр эзэлж Шилжин явах цом, мөнгөн шагналаар шагнагдлаа.



Мөн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч С.Баярмаа "Улсын бүртгэлийн тэргүүний ажилтан цол" тэмдгээр, мэдээллийн технологийн ажилтан Р.Доржнямбуу Хууль зүй, дотоод хэргийн яамны "Жуух бичиг"-ээр тус тус шагнагдаж хөдөлмөр зүтгэлээ үнэлүүллээ.



- Хэлтсээс сайн үйлсийн аянд нэгдэж Баянхонгор сумын иргэн Ц.Дагийсүрэнгийн эмчилгээнд зориулан сэтгэлийн хандиваа өргөн хурдан эдгээрэй гээд 370000 төгрөгийг хандивлав.

- Улсын бүртгэдийн Ерөнхий газраас зохион байгуулсан өвөлжилтийн хүндрэлтэй цаг хугацаанд малчдад туслах "Бүртгэлийн илч" аянд нэгдэж 780,000 төгрөг хандивласан.

- Улсын бүртгэлийн байгууллагын түүхт 84, Бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд шилжсэний 15 жилийн ой, "Улсын бүртгэлийн ажилтны өдөр"-ийг угтан УБЕГ-аас зохион байгуулсан Хандивын аянд нэгдэж 385000 төгрөгийн хандивыг илгээсэн.

-Улсын бүртгэлийн байгууллагын түүхт 84, Бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд шилжсэний 15 жилийн ой, "Улсын бүртгэлийн ажилтны өдөр"-ийг угтан Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд ажилтан, албан хаагчдыг идэвхжүүлэх, ажлын байр, өрөө тасалгааг цэцэгжүүлэх, тохижуулах ажилчдын идэвх оролцоо, шинэлэг санааг тодорхойлох зорилгоор "Ногоон нэгж" аяныг харьяа улсын бүртгэлийн хэлтсүүдийн дунд өрнүүлсэнд идэвхтэй оролцож зохион байгуулсан ажлын тайлан, контентыг хийн хугацаанд нь хүргүүлсэн.



-Аливаа байгууллагын үнэт зүйл бол боловсон хүчин хүний нөөц бөгөөд тэдгээрийн ажиллах орчныг сайжруулах, ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, эрүүл аюулгүй орчинд ажиллах явдал маш чухал билээ.

Энэ ч утгаараа 2022 онд Баянхонгор аймагт Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ахлуулсан ажлын хэсэг ажиллах үеэр хүсэлт тавьснаар 2022 онд зураг төсөв нь хийгдэж, 2024 онд тус сайдын багцаас шийдвэрлэгдсэн дагуу 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс барилгын их засварын ажлыг эхлүүлэн 7 дугаар сарын 31-ний өдөр улсын комисс хүлээн авч ашиглалтад орсноор үйл ажиллагаа хэвийн ажилтнуудын сэтгэл ханамж дээшилсэн байна.

Тус барилгын их засварын ажлын төсөвт өртөг нь 911,4 сая төгрөг болно.



## **ЕС.ИДЭВХ САНААЧИЛГА, ШИНЭЛЭГ АЖЛЫН ТАЛААР**

### **Зөвлөлдөх уулзалтыг зохион байгууллаа.**

Улсын бүртгэлийн Ерөнхий газраас зарласан “Хуулийн хэрэгжилт, хамтын ажиллагааг дэмжих жил”-ийн хүрээнд харилцан уялдаа, холбоотой ажилладаг байгууллага, мэргэжилтнүүдтэй харилцан ойлголцож, хамтран ажиллах чиглэлээр “Өглөөний цай” зөвлөлдөх уулзалтыг Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхам эхлүүлэн хийсэн бөгөөд 4 дүгээр сарын 08-ны өдрийн 08.00 цагт Баянхонгор




аймгийн Нотариатын танхимын нотариатуудтай нотариатын өрөөнд хийлээ.Тус уулзалтаар цаг үеийн чухал сэдэв болох Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл, Сонгогч шилжилтийн бүртгэлтэй холбогдуулан итгэмжлэлээр төлөөлөн оролцох харилцаанд талуудын анхаарах асуудал, гарч болох эрсдлийг тооцон харилцан зөвлөлдөх, хуулийн хүрээнд, иргэдэд чирэгдэлгүй үйлчлэх, улсын бүртгэл болоод нотариатын үйлдэл үнэн зөв, шударга байх зарчмыг ханган ажиллах, аливаа асуудалд талууд ижил байр суурьтай байх зэрэг тодорхой асуудлууд дээр нэг мөр ойлголтод хүрч, уулзалт амжилттай халуун дулаан сайхан болж өндөрлөсөн бол

2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн өглөөний 08.00 цагт Баянхонгор сумын Засаг даргын орлогч Д.Ууганцэцэг даргын албан өрөөнд Баянхонгор сумын төвийн 8 багийн Засаг дарга нартай хийлээ. Уг уулзалтаар цаг үеийн чухал сэдэв болох Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл 4 дүгээр сарын 29-нд



зогсохтой холбоотой багийн түр оршин суугч нарын шилжилт хөдөлгөөний бүртгэлээ хийлгүүлэх ажлыг ухуулан сурталчлах, Сонгогчдын нэрийн жагсаалт Улсын бүртгэлийн байгууллагын цахим сайтад нээлттэй байршуулсантай холбоотой Сонгогч өөрийн болон гэр бүлийн гишүүдийн мэдээлэлтэйгээ танилцах ажлыг багийн төвүүд дээрээ зохион байгуулж, хамтран ажиллах талаар ярилцахын зэрэгцээ Сонгуулийн хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу Улсын бүртгэлийн байгууллагын хийж хэрэгжүүлж байгаа ажлын талаар товч танилцууллаа.

Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хэлтсийн үйлчилгээний зааланд 24/7 үйлчилгээг нэвтрүүлж энэ талаар бэлтгэсэн контент мэдээллийг хэлтсийн цахим хаягт байршуулан сурталчиллаа.



**Баянхонгор аймгийн улсын бүртгэлийн хэлтэс** *Иргэдэд ойр төрийн үйлчилгээ*

Тус хэлтсээс зорилтод бүлэг болон байгууллага хамт олонд Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр явуулын үйлчилгээг үзүүлж байна. Үүнд:

- 01 Жирэмсэн болон 0-3 насны хүүхдээ асарч байгаа иргэд 
- 02 Хөгжлийн бэрхшээлтэй болон асаргаанд байдаг иргэд 
- 03 Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа болон хүндээр өвчилсөн иргэд 
- 04 Өндөр настан, ахмадууд 
- 05 Хорих ангид хоригдож байгаа болон бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар Улсын бүртгэлийн байгууллагад ирэх боломжгүй иргэд 
- 06 Байгууллага хамт олны хүсэлтээр 

Хүсэлт хүлээн авах утас: 70442177, 99783883

## Явуулын үйлчилгээг үзүүлэв.

Хэлтсийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, зорилтот бүлгийн иргэдэд хүрч үйлчлэх зорилгоор “Явуулын үйлчилгээ” үзүүлэхээр УБЕГ-т хөдөлгөөнт төхөөрөмж хүсэн 2024 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 1/42 тоот албан бичгийг хүргүүлснээр нэмж 1 төхөөрөмж авч 2 төхөөрөмжтэй боллоо.

Тайлант хугацаанд уг төхөөрөмжөөр дараах үйлчилгээнүүдийг үзүүллээ.

- Хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэнд гэрт нь очиж үйлчилгээ биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл .
- Байдраг ахлах сургуулийн 1994-2004 оны төгсөгчдийн 20 жилийн ойг угтан төгсөгчид төрж өссөн Жаргалант сумын ард иргэдээ төрийн үйлчилгээг хүргэх зорилтод ажлын хүрээнд "НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ" арга хэмжээг 2024 оны 03 дугаар сарын 09-нөөс 03 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулахаар хүсэлт ирүүлсэн. Хүсэлтийг хүлээн авч тус хэлтсээс 3 бүртгэгч ажиллуулснаар аймгийн төвөөс 165 км алслагдсан Жаргалант сумын иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг шуурхай хүргэж, иргэдийн хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг үзүүллээ.

Үүнд: **Иргэний улсын бүртгэл:** Төрсний бүртгэл 1, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд 3, лавлагаа 3, гадаад паспорт 49 нийт 57 бүртгэл

**Хуулийн этгээд:** Шинээр хуулийн этгээд байгуулсан бүртгэл 4, хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулсан бүртгэл 1, оноосон шинэ нэрийн баталагаажилтын бүртгэл 2, нийт 7 бүртгэл

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл:** Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг анх удаа улсын бүртгэлд бүртгүүлэх бүртгэл 2, эд хөрөнгийн хаяг, хэмжээ, нэгж талбарын дугаар, хэмжээ өөрчлөлтийн бүртгэл 3, төрөөс үнэгүй хувьчилсан газрын өмчлөх эрхийн анх удаа баталгаажуулах бүртгэл 1, барьцааны эрхийн гэрээ 1, нийт 7 бүртгэл хийж нийт 71 бүртгэл хийж, давхардсан тоогоор 56 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Энэ хугацаанд бүртгэл хийлгэсэн иргэдийн Гадаад паспортыг хүлээн авч 2024 оны 03 дугаар сарын 16-ны өдөр тус суманд ажилладаг улсын бүртгэгч Т.Алтаншагай гэрт хүргэж өгч үйлчиллээ.



Улсын бүртгэлийн үйлчилгээг амжилттай хүргэж, иргэдэд шуурхай үйлчилсэн, улсын бүртгэгч З.Дуламсүрэн (үндэсний энгийн гадаад паспортын бүртгэл), улсын бүртгэгч Д.Отгонсүрэн (хуулийн этгээдийн улсын бүртгэл) нарт нийт төгсөгчид болон нутгийн зон олны талархал цахимаар ирсэн болно.

Баянговь сумын Засаг даргын Тамгын газартай хамтран тус суманд "Төрийн үйлчилгээ иргэдэд ойрхон" уриатай Улсын бүртгэлийн явуулын үйлчилгээг 2024 оны 5 дугаар сарын 6,7-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Тус явуулын үйлчилгээгээр үндэсний цахим гадаад паспортын 76 бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 24 бүртгэлийн үйлчилгээг үзүүлж, улсын бүртгэл (иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл)-тэй холбоотой асуудлаар 30 иргэнд эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгсөн байна. Баянговь сум нь аймгийн төвөөс 230 км зайтай алслагдсан бөгөөд тус сумын иргэд, малчид хавар цагийн их ажлын үед газар дээрээ улсын бүртгэлийн үйлчилгээг авсан нь бидний цаг, зардлыг хэмнэсэн чухал арга хэмжээ боллоо гэж талархсаныг дурдъя.



#### ТА БҮХНИЙГ УРЬЖ БАЙНА

Бүртгэлийн  
үйлчилгээг Бямба гарагт  
төлөвлөгөөг хэрэгжүүлэв.

"Бүртгэлийн үйлчилгээг Бямба гарагт" төлөвлөгөөг хэрэгжүүлэн тус хэлтсээс 2024 оны 09 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн Бямба гараг бүрийн 11.00-16.00 цагийн хооронд бүртгэлийн үйлчилгээг хүргэх гэж байна.

Ажлын өдрүүдэд бүртгэлийн үйлчилгээг авч амждаггүй иргэд үйлчлүүлэгчдийг урьж байна.

ТА БҮХЭН СУМАНДАА ДАРААХ ЧИГЛЭЛЭЭР БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВЧ ҮЙЛЧЛҮҮЛНЭ ҮҮ

ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:  
ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:  
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:  
ТООН ГАРЫН ҮСЭГ ОЛГОЛТ  
ГАДААД ПАСПОРТЫН БҮРТГЭЛ

БАЯНХОНГОР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

Хурдан төвтэй хамтран ажиллав.



БАЯНХОНГОР УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТЭС



ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГ - ХААНААС Ч ОЙРХОН

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.11. Сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө шалгасан байвал зохино” гэж заасан ба хуулийн уг заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Улсын бүртгэлийн байгууллагын цахим сайтад байршуулсан “Сонгогчийн нэрийн жагсаалт”-аас сонгогч өөрийн болон гэр бүлийн гишүүдийн мэдээллийг шалгах үйлчилгээг Баянхонгор аймгийн Цахим үйлчилгээний хэлтсийн Төрийн үйлчилгээний “ХУРДАН” төвтэй хамтран үзүүлж байна.

Иргэн та Төрийн үйлчилгээний “Хурдан” төв дээр очин өөрийн болон гэр бүлийн гишүүдийн мэдээллээ шалгана уу.

**Хэлтсийн үйл ажиллагааг гэр бүлийн гишүүдэд танилцуулах уулзалт,  
сургалтыг зохион байгуулав.**

Хууль зүй, дотоод хэргийн сайдын Зорилтот арга хэмжээ зохион байгуулах, удирдамж батлах тухай А/110 дугаар тушаал болон “Хамгийн чухал нь” арга хэмжээний удирдамжийн дагуу хэлтсийн албан хаагчдыг гэр бүлийн насанд хүрсэн гишүүдийн хамтаар эрүүл мэндийн үзлэгт 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр хамруулсан ба энэ үеэр албан хаагчдын гэр бүлийнхэнд хэлтсийн үйл ажиллагааг танилцуулан, “Гэр бүлийн харилцаа” сэдэвт сургалтыг зохион байгуулав. Эрүүл мэндийн үзлэгт нийт 56 хүн хамрагдсан.



## **ДҮГНЭЛТ, САНАЛ**

Улсын бүртгэлийн хэлтэс нь УБЕГ-аас өгсөн зөвлөмж, чиглэлийг баримтлан хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Хэлтсийн албан хаагч, сумдын улсын бүртгэгч нараар дамжуулан бүрэн эрхээ хэрэгжүүлж, 2024 оны үндсэн зорилтоо амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа. Дараах саналыг хүргүүлж байна.

### **Бүртгэлийн хэвийн үйл ажиллагааг хангах талаар**

1.1 Бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэхэд шаардлагатай тоног төхөөрөмж шинэчлэлт хийгдэж байгаа боловч сүлжээний доголдол тасалдал байнга үүсэж байгаа тул найдвартай байдлыг хангах арга хэмжээг авах

1.2 Бүртгэлийн архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулахад анхаарч орон нутгийн хэлтсүүдэд нягтруулсан шүүгээ, хадгаламжийн нэгжийн хамгаалалтын хайрцаг /A4/ бэлтгэн нийлүүлэх

1.3 Байгууллагын архивыг нягтруулсан шүүгээгээр хангаж холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах

### **2. Албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшсэн тогтвортой байлгах талаар**

2.1 Төрийн албаны тухай хууль тогтоомж, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журманд заасан урамшуулал, тусламж дэмжлэгийг тогтоосон хэмжээгээр олгоход шаардагдах төсвийг бүрэн тусган батлуулж олгох ;

2.2 УБЕГ-аас дүүрэг, аймгуудын хэлтсүүдийн ажилтнуудын туршлага солилцох сургалт семинарыг бүсчилж зохион байгуулах

Эдгээр саналыг анхааран шийдвэрлэх нь байгууллага, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг сайжруулах, бүртгэлийн байгууллагын хэвийн ажиллах нөхцөл боломжийг бий болгоход ач холбогдолтой байх болно.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.МӨНХЖАРГАЛ

